Хавсралт 6.

Төслийн сонин (Дугаар 1-4)

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

JICA

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

# “ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”

2016 оны 03 дугаар сар

Дугаар 1

***Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хэрэгцээндээ тохирсон хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авах боломжийг бий болгох…***



## ГАРЧИГ:


| | |
|---|---|
| Төслийн танилцуулга | 1 |
| Төслийн зорилтот бүс нутаг | 1 |
| “Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, эрт оролцоо” семинар | 2 |
| 26-р сургууль дээр сургуульд сурахад хүндрэлтэй байгаа хүүхдүүдтэй танилцах арга хэмжээ | 2 |
| “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” форумд илтгэл тавив | 2 |
| Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар боловсруулав | 3 |
| Тусгай сургуулиудаас ердийн сургуулиудад зөвлөгөө өгөх үйл ажиллагаа | 3 |
| Японд сургалт зохион байгуулав | 4 |


## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) нь 2015 оны 08 сараас эхлэн БСШУЯ болон ХАХНХЯ-ны хүсэлтээр “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь төслийн туршилтын бүс нутаг болон туршилтын сургуулиудад үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг болон боловсролын загварыг бий болгохоор зорьж байна.

Эдүгээ Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд,

**<u>Боловсролын хүртээмжийн асуудал</u>**

- Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт хангалтгүй.
- Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн цогц хөгжлийн дэмжлэг дутагдалтай.
- Элсэн суралцах сургууль олдоцгүй.
- Асран хамгаалагчид болон бүс нутгийн нийгэм дэх хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хангалтгүй.
- Эцэг/эх, асран хамгаалагчид нь ажил эрхлэх боломж хомс тул ядууралд өртөмтгий.
- Явган зам, нийтийн тээврийн орчин хангалттай бүрдээгүйн улмаас сургуульд явахад хүндрэлтэй.

**<u>Боловсролын чанарын асуудал</u>**

- Сургалтын агуулга нь хүүхэд бүрийн хэрэгцээнд тохироогүй.
- Багш нарын арга зүй хангалтгүй.
- Анги дүүргэлт хэт их.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарыг урамшуулах, ажлын идэвхийг нь дээшлүүлэх тогтолцоо хэрэгждэггүй.
- Сургалтын материал, техник хэрэгсэл, орчин бүрдээгүй.

Төслийн хүрээнд, дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн, аль болох олон хүүхдэд өндөр чанартай боловсрол эзэмшүүлж, нийгэмд бие даан амьдрах чадвартай болгох чиглэлээр Монголын талтай хамтарч ажиллана.

## ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ БҮС НУТАГ

Нийслэл болон орон нутагт төслийн туршилтын дүүрэг, аймгийг сонгоно.

Оюуны бэрхшээлтэй хүүхэд сурдаг Улаанбаатар хотын 4 тусгай сургууь (25, 55,63,70-р сургуулиуд) тус бүр 2 ердийн сургуультай хамтран үйл ажиллагаа явуулж байна.

Уг хамтын ажиллагаагаар дамжуулан тусгай сургуулийн багш нарын мэдлэг, туршлагыг ойролцоох ердийн сургуулийн багш нарт танилцуулахад чиглэсэн зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.




## ТӨСЛИЙН БАГИЙН ХАЯГ:

◇ БСШУЯ:
Засгийн газрын байр III, 212 тоот

◇ ХАХНХЯ:
Сэргээн засалт хөгжлийн үндэсний төв, 209 тоот
Утас: 976-9424-0702
976-8634-0702
Цахим хаяг: jica15start@gmail.com

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИССТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ



“Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, оролцоо”-ны талаар Японы туршлагыг танилцуулав

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс /ХБХЭМБНХК/” нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэлт, эрт оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд 2014 оны 06 сард ХАХНХЯ-ны харьяа Сэргээн засалт хөгжлийн үндэсний төвийг түшиглэн ХБХЭМБНХ-ын Төв комисс, Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт Салбар комиссуудыг байгуулжээ.

Төслийн баг 2015 оны 09 сарын 09-нд Төв комисстой хамтран 9 дүүргийн Салбар комиссын гишүүдэд зориулан сургалт зохион байгуулсан.

Уг сургалтад Японы мэргэжилтнүүд лекц уншин, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, оролцооны талаарх Японы туршлагыг фото зураг болон видео бичлэг ашиглан танилцуулав. Мөн хэрхэн хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн дэмжлэгийн чухлын талаар эцэг эхчүүдэд ухуулан таниулах, хэрхэн хөгжлийн дэмжлэгийн тогтолцоо бүй болгох талаар дэлгэрэнгүй тайлбар өгсөн юм.

Лекцийн дараа оролцогчдоос өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлийн талаарх санал бодлыг нь сонссон юм. Төслийн баг цаашид оролцогчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт, ур чадварыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлийн нэр томьёог нэгтгэх, салбар комиссын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах болно.

## 26-Р СУРГУУЛЬД ТАНИЛЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүд хамт тоглож буй байдал

26-р сургууль нь Нийслэлийн төвөөс 35 км зайтай орших Хан-Уул дүүргийн Туул тосгонд байрладаг. 2015 оны 12 сарын 20-нд /Ням/, тус сургуульд ойрхон амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурагчидтай танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд сургуульд явдаггүй, хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд эцэг/эх, асран хамгаалагч, ах дүүгийн хамт хүрэлцэн ирж оролцсон. Арга хэмжээний эхэнд 5-р ангийн сурагчид өөрсдийгөө танилцуулж, бишгүүр тоглож үзүүлсэн бөгөөд дараа нь бүх хүүхдүүд багаар хуваагдан хамт тоглов. Тоглож дууссаны дараа үдийн цай уугаад тарах хугацааны хувьд богино арга хэмжээ байсан ч гэлээ, асран хамгаалагчид хүүхдүүдийнхээ хамт цагийг зугаатай өнгөрүүлж чадлаа. Багш нар “Өнөөдөр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн ангид бусад хүүхдүүдтэй хамт сурч чадахаар юм байна”, “Багш нар тусгай анги албан ёсоор нээгдэхийг хүлээлгүй, өөрсдийн чадах зүйлээсээ эхлэх нь зүйтэй” гэх зэргээр санал бодлоо илэрхийлж байв.

Дараагийн өдөр нь зохион байгуулсан сургуулийн шинэ жилийн баярын арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 8 хүүхэд, асран хамгаалагчдын хамт ирж оролцсон бөгөөд хүүхдийн тоо нэмэгдсэн нь өмнөх өдрийн арга хэмжээний тухай сонсcоных болов уу.

Арга хэмжээний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэйн улмаас сургуульд сурч чадахгүй байгаа хүүхдүүдэд сургуульд элсэн суралцах боломжоо олгох чиглэлээр цаашид сургуулийн захиргааны зүгээс эцэг/эх, асран хамгаалагчидтай хамтарч ажиллахаар боллоо.

## “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ” ФОРУМД ИЛТГЭЛ ТАВИВ



Японы тэгш хамруулан сургах боловсролын талаар танилцуулав

2015 оны 12 сарын 21-22-нд Нээлттэй нийгэм форум ТББ-аас “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол форум”-ыг зохион байгуулав.

Уг форумд БСШУЯ, МУБИС, тусгай сургууль, цэцэрлэг, ХБХЭМБНХ-ын Төв комисс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдтэй холбогдох байгууллагууд, эцэг эхийн холбоод, ТББ-уудын төлөөлөл оролцсон. Форумын эхний өдөр нийт 11 илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан бөгөөд төслийн багаас Монгол Улсын тэгш хамруулан сургах боловсролын төлөв байдлыг судлан, амьдралд бодитоор хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор тусгай боловсролоос тэгш хамруулан сургах боловсролд шилжих шилжилт, олон улсын чиг хандлагын тухай илтгэл тавив.

Мөн 30 гаруй жилийн өмнөөс ердийн сургуулийн ердийн ангид хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдэд хамт боловсрол эзэмшүүлэх зорилт тавин ажиллаж ирсэн Осака хотын үйл ажиллагааны талаар танилцуулсан.

Янз бүрийн нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийг ердийн сургуульд хүлээн авч сургах, тэдний хэрэгцээнд нийцсэн боловсрол олгох хэрэгцээ шаардлага, үйл явц нь туйлын чухал юм. Эдгээрт анхаарал хандуулан, Монгол Улсад бий болговол зохих тэгш хамруулан сургах боловсролын талаарх судалгааг цаашид ч үргэлжлүүлэхийг төслийн зүгээс хүсч байна.

## “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЯПОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАВ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд, 2015 оны 11 сарын 16-наас 12 сарын 11-ны хооронд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хичээл зохион байгуулах нь” сэдэвт сургалтыг Япон Улсад зохион байгуулав. Уг сургалтад БСШУЯ, Боловсролын хүрээлэн, тусгай сургуулиуд, ХАХНХЯ, ХХБХЭМНХ-ын Төв комисс болон Баянгол дүүргийн Салбар комиссыг төлөөлөн нийт 10 хүн оролцлоо.

Оролцогчид сургалтын хугацаанд хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийн дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох боловсролын тухай танхимын сургалтаас гадна, танилцах дадлага сургалтаар Японы “Тусгай дэмжлэгт боловсролын үндэсний хүрээлэн”, Цүкүба их сургуулийн харьяа Тусгай дэмжлэгт боловсролын сургууль, Токио хотын Бүнкёо дүүргийн бага сургууль, Ёкосүка, Насүшиобара хотын холбогдох байгууллагуудад зочилж үйл ажиллагаатай нь танилцсан.

Энд Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах ажилд ашиглах боломжтой зарим зүйлийг танилцуулж байна.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ЭРТ ОРОЛЦОО

Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн, эрт оролцоог хангах нь туйлын чухал. Ингэснээр хоёрдогч бэрхшээлээс сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдрах ухаанд сурган, нийгэм болон ахуйн дадал суулгах боломж бүрдэнэ. Мөн асран хамгаалагчдад нь зориулан зөвлөгөө өгч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний гэр бүл нийгэмд ганцаардахаас сэргийлэх ч боломжтой.

Япон Улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан эмчилгээ, сэргээн засалт болон боловсролын аль алиныг нь чухалчилж иржээ. Харин сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зөвхөн эрүүл мэнд, боловсролын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх нь хангалттай бус бөгөөд гэр бүл, бүс нутгийн нийгмийг хамарсан цогц хандлага нэн чухал гэж үзэх болсон юм. Хүүхдийн хөгжлийн бүх үе шатанд салбарын дотоод дахь хөндлөн уялдаа бүхий хамтын ажиллагаа (Хэвтээ уялдаа холбоо) болон хөгжлийн үе шат ахих үед дэмжлэг үзүүлэгчид хоорондын уялдаа холбоо (Босоо уялдаа холбоо) шаардлагатай байдаг.

Японд эх хүүхдийн дэвтэр, эрүүл мэндийн тогтмол үзлэг, оношилгоогоор дамжуулан эрт илрүүлгийг зохион байгуулдаг бөгөөд хөгжлийн хоцрогдолтой байж болзошгүй хүүхэд, тэдний гэр бүлд зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна. 。

### ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ (ICF)

Хөгжлийн хоцрогдолтой байж болзошгүй хүүхдэд хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ? Юуны өмнө тухайн хүүхдийн бодит төлөв байдлыг үнэн зөв тодорхойлох нь чухал. Бодит байдлыг үнэн зөв тодорхойлохын тулд хөгжлийн сорил, эсхүл оюун ухааны сорил гэх мэт хэрэглэгдэхүүнүүдийг ашигладаг гэж олон хүн боддог байх. Гэвч зөвхөн эдгээр сорилуудаар хүүхдийн хөгжлийг цогцоор нь авч үзэх боломжгүй. Ийм тохиолдолд өргөн ашигладаг үр дүнтэй арга нь “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)” юм. ICF-г ашиглаж болох жишээг доор танилцуулав.




*Эх сурвалж: Кооно Макото (Кёорин их сургууль, Эрүүл мэндийн факультет) 2015 оны Япон дахь сургалтын материалаас Японы БШУЯ-ны вебсайт: http://www.mext.go.jp/b_menu/shingi/chukyo/chukyo3/032/siryo/06091306/002.htm-г ашиглав.*

ICF-г ашиглан хүүхэд А”-гийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж үзвэл, энэ хүүхдийн сул тал төдийгүй, давуу талуудыг нь ч анзаарч болно. Мөн зөвхөн сэтгэл санаа, бие махбодын үйл ажиллагаа, бүтцэд нь анхаарал хандуулалгүйгээр хүрээлэн буй орчны хүчин зүйл зэрэгт нь дүн шинжилгээ хийх замаар “Нийгмийн оролцоо” хэмээх эцсийн зорилтод хэрхэн хүргэх арга замыг эрэлхийлэн судлах боломжийг олгодог. Тухайн хүүхдийн талаарх ерөнхий зураглалыг гаргах боломжтой гэсэн үг юм. Жишээлбэл, хүүхэд “А”-г “Өөрөө дэлгүүр явж чаддаг болгох” гэсэн зорилт тавьж, бүс нутгийн оршин суугчдын дунд энэ талаар ухуулан тайлбарлах, хүүхэд “А”-гийн гэр бүлд сургалт, зөвлөгөө өгөх зэрэг арга замыг бодож олох боломжтой.



Япон дахь сургалтын лекц сонсож буй байдал



Япон дахь сургалтын үр дүнг тайлагнах уулзалт

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

JICA

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

# Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл

2017 оны 02 дугаар сар Дугаар 2

## Хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг авна...



## ГАРЧИГ


| | |
|---|---|
| Төслийн танилцуулга | 1 |
| Туршилтын аймаг/дүүрэг | 1 |
| Төслийн багийн хаяг | 1 |
| Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх видео сургалтын материал боловсруулав | 2 |
| "Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр"-ийг турших үйл ажиллагаа | 2 |
| Суралцах бэрхшээлтэй (LD) хүүхдийг сурахад хялбар болгох санал санаачлага | 2 |
| Аль болох олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах | 3 |
| БСШУСЯ болон ХНХЯ-ны үйл ажиллагаа | 3 |
| Гар зургийн уралдаан | 4 |


## Төслийн багийн хаяг


○ БСШУСЯ:
Засгийн газрын III байр, 212 тоот
Утас: 976-9424-0702

○ ХНХЯ:
Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, 224 тоот
Утас: 976-8634-0702

○ Цахим хаяг:
jica15start@gmail.com

○ Цахим хуудас:
http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html


## Төслийн танилцуулга

ЖАЙКА нь 2015 оны 08 дугаар сараас эхлэн Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам *(Одоогийн Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, цаашид БСШУСЯ гэх)* болон Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яамтай *(Одоогийн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, цаашид ХНХЯ гэх)* хамтран "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байна.

Тус төслийг 2019 оны 07 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд "Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, үнэлгээ, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох" зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.

## Туршилтын аймаг/дүүрэг

Төслийн үйл ажиллагаа явуулах туршилтын дүүргээр Нийслэлээс Баянгол дүүрэг, туршилтын аймгаар орон нутгаас Хөвсгөл аймгийг сонгон авсан.

Эдгээр туршилтын аймаг/дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст *(Тайлбар)* зориулан хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийн дэмжлэгийн чиглэлээр сургалт зохион байгуулж байна.







Улаанбаатар хотод оюуны бэрхшээлтэй болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг 4 тусгай сургууль, тэдгээр сургуулийн ойролцоох ердийн сургуулийг туршилтын сургуулиар сонгосон.

Туршилтын сургууль дээр хэлэлцүүлэг сургалт, судалгаат хичээл зохион байгуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсрол олгох үүднээс багш нарын ур чадварыг дээшлүүлж байна.

***Тайлбар:*** *Эмч, багш, халамжийн болон сэргээн засалтын мэргэжилтэн зэрэг хүмүүсээс бүрдэх бөгөөд хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг тогтоон эрүүл мэнд, боловсрол, халамжийн талын хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө гаргах үндсэн чиг үүрэгтэй комисс. Бүх дүүрэг, бүх аймагт байгуулагдсан. 0-16 настай хүүхдийн эцэг/эх, асран хамгаалагчдын хүсэлтэд тулгуурлан, тухайн хүүхдийн сурах сургуулийг сонгох зэрэг ажлыг зохион байгуулдаг.*

## Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор видео сургалтын материал боловсрууллав

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх үүднээс төслийн хүрээнд 3 төрлийн видео сургалтын материал боловсруулсан.

Эхнийх нь "Аутизмыг эрт илрүүлэх, түүний тухай ойлголт" сэдэвт видео сургалтын материал (Хамтран ажилласан: Монголын Аутизмын Холбоо ТББ).

Удаах нь "Дауны хам шинжийг эрт илрүүлэх, түүний талаарх ойлголт" сэдэвт видео сургалтын материал (Хамтран ажилласан: Монголын Дауны Холбоо ТББ). Эдгээр сургалтын материалыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэгийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор боловсруулсан. Хөгжлийн дэмжлэгийг гардан зохион байгуулах зөвлөх мэргэжилтнүүдэд зориулан бэрхшээл бүрийн тодорхойлолт, оношлогооны стандарт, үйлийн болон хөгжлийн онцлог шинж, хавсран илэрч болох эмгэгийн талаарх тайлбарыг багтаасан болно.

Сүүлийнх нь "Бага насны хүүхдийн хөгжил" сэдэвт видео сургалтын материал болно. Дэмжлэг үзүүлэх зөвлөх мэргэжилтнүүд төдийгүй, хүүхэдтэй ажилладаг бусад бүх хүмүүст зориулан 4 хүртэлх настай хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэхийг зорьсон. 6 ай бүрээр (1. Биеийн байрлал, хөдөлгөөн, 2, Хараа, сонсгол, 3. Эрэлхийлэх, удирдах, 4. Ой тогтоолт, 5. Хэл яриа, 6. Нийгэмшихүй) сар, жилийн насны дараалаар нь хөгжлийн онцлогийг тайлбарласан.



Уг сургалтын материалыг холбогдох хүмүүст тараан хүргүүлснээс гадна аль болох олон хүнд ашиглуулах үүднээс видео танилцуулах уулзалт зохион байгуулсан.

## Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөрийг турших үйл ажиллагаа

Эдүгээ төслийн хүрээнд, Портеж эрт боловсролын хөтөлбөрийн Монгол хувилбарыг боловсруулж байна.

Портеж эрт боловсролын хөтөлбөр нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд ар гэрт нь хөгжлийн дэмжлэг үзүүлэх боломжтой АНУ-д анх гарсан хөтөлбөр бөгөөд Япон хувилбарыг Японы Портеж Нийгэмлэг АББ боловсруулжээ. Энэ хөтөлбөр нь өдөр тутмын үйлийн дүн шинжилгээний зарчмаар хүүхэд бүрийн хөгжилд тохирсон дэмжлэгийг үзүүлэх боломжтой гэдгээрээ онцлог гэж болно.

Төслийн баг 2016 оны 09 дүгээр сараас эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна. Одоогоор 9 гэр бүлд энэхүү хөтөлбөрийг туршиж байна.

## Суралцах бэрхшээлтэй (LD) хүүхдийг сурахад хялбар болгох санал санаачлага

Японы БШУЯ нь Суралцах бэрхшээлийг (Learning Disabilities: LD) "Оюуны ерөнхий хөгжилд хоцрогдол байхгүй ч сонсох, ярих, унших, бичих, тоо бодох, эсвэл таамаглах чадваруудаас тодорхой нэг зүйлийг сурах, ашиглахад багагүй хүндрэл үүсэх янз бүрийн нөхцөл байдлыг хэлнэ" гэж тодорхойлжээ.

Суралцах бэрхшээлийг төв мэдрэлийн системд ямар нэг саатал үүссэнтэй холбоотой гэж үздэг ба харааны, сонсголын, оюуны, зан төлвийн бэрхшээл, бусадтай харилцах бэрхшээл, орчны хүчин зүйлүүд шууд нөлөө үзүүлдэггүй. Суралцах бэрхшээлийн шалтгааныг "Танин мэдэхүйн тэнцвэргүй байдал"-тай холбон тайлбарладаг.

Танин мэдэхүйд,

- **Анхаарлаа хандуулах чадвар**
- **Харсан зүйл болон бусдын хэлснийг цээжилж тогтоох чадвар (Ой тогтоолт)**
- **Хэлбэр дүрс, байрлалыг ялган таних чадвар (Харааны танин мэдэхүй)**
- **Дуу чимээ сонсож ялгах чадвар (Сонсголын танин мэдэхүй)**

зэрэг олон чадварууд багтах ба эд бүгд суралцахуйн үндэс суурь болдог. Эдгээр чадвар тэнцвэртэй хөгжсөн бол хүүхэд сурахад асуудал үүсэхгүй. Харин харааны танин мэдэхүйн өндөр чадвартай боловч, ой тогтоолт тааруу байвал, хүүхэд багшийнхаа хэлснийг цээжилж чаддаггүйн улмаас сурах явцад нь бүдрэлт үүсдэг байна. Үүнийг суралцах бэрхшээл гэдэг.

Хичээллэх явцад суралцах бэрхшээлтэй хүүхэд "Танин мэдэхүйн тэнцвэргүй байдал"-д нь нөлөөлдөг янз бүрийн асуудлуудтай тулгардаг ажээ. Энд жишээ болгон дараах зүйлийг дурьдаж болно.

- **Багшийн ярианд анхаарлаа хандуулж сайн чадахгүй (Анхаарал)**
- **Багшийн хэлснийг түр цээжлэн дэвтэрт бичиж авахдаа тааруу (Богино хугацааны харааны ой тогтоолт)**
- **Олон үг орсон өгүүлбэр уншуулахад, үг үсгүүдийн хэлбэр дүрсийг ялгаж танихдаа тааруу (Харааны орон зайн танин мэдэхүй)**
- **Самбарт бичсэн үг үсгийг цээжлэн хуулж бичихдээ тааруу (Богино хугацааны харааны ой тогтоолт)**

**Ийм асуудалтай хүүхдэд** дараах дэмжлэг үр дүнгээ өгдөг.

- ***Чухал газруудыг тодруулагчаар тодосгох, эсвэл доогуур нь зурж өгөх***


Зөндөө олон хүүхэд гоё чимэглэлтэй малгай өмсөөд, чангаар дуу дуулсаар хотын төвийг чиглээд алхаа нийлүүлэн хүрч ирэв.

- ***Номын хуудсыг томоор хэвлэн өгч, үг өгүүлбэрийг уншихад хялбар болгож өгөх***
- ***Мөр болгоныг дагуулан шугам барих, эсвэл хуруугаар зааж уншуулах***
- ***Самбарт бичсэнийг хүүхэд хуулж авч чадахгүй байвал, бичих гэж байгаагаа урьдчилан цаасан дээр бичиж өгөх***

Сургуулийн өдөр тутмын амьдрал дахь янз бүрийн нөхцөл байдалд тохируулан багахан зохицуулалтыг хийж өгснөөр суралцах бэрхшээлтэй хүүхдүүд сурахад хялбар болно.

## Аль болох олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах...

Төслийн хүрээнд, хүүхдүүдийн боловсролын тусгай хэрэгцээнд нь нийцсэн боловсролын янз бүрийн арга хэлбэрийг судлан, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загварыг боловсруулах зорилгоор жижиг хэмжээний туршилтын үйл ажиллагаа (Бичил төсөл) хэрэгжүүлж байна.

2016 оны 04 дүгээр сард сонгон шалгаруулалтыг зарлаж, нийт 35 байгууллагаас төсөл хүлээн авсан. Бичиг баримтын болон ярилцлагын сонгон шалгаруулалтын үр дүнд 3 төслийг шалгаруулсан бөгөөд эдгээр төслүүд 2016 оны 06 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн юм.

Монголын Дауны Холбоо ТББ нь “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд боловсролын тэгш оролцоог хангах нь” төслийнхөө хүрээнд Нийслэлийн 130-р сургуультай хамтран ажиллаж, тус сургууль дээр даунтай хүүхдийн анги нээсэн. Даунтай хүүхэд биеийн тамир, дуу хөгжмийн хичээлд ердийн ангийн хүүхдүүдтэй хамт оролцдог болсноос гадна, тус сургуулийн багш нар болон асран хамгаалагчдад зориулсан сургалтыг ч зохион байгуулж байна.

Орхон аймгийн Насан туршийн боловсрол олгох төв нь “Бид сурч чадна” төслөөрөө сургуульд явдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд албан бус сургалтыг явуулж байна. Төвд хамруулахаас гадна, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ар гэрээр очин сургалтаа зохион байгуулдаг.

Хүүхдийн хөгжил мэдээллийн Учрал төвийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээ” төсөл нь, төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу хүүхэд харах үйлчилгээ үзүүлж хүмүүст хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах болон багшлах арга зүйд сургах сургалтын модуль боловсруулан, түүнийгээ ашиглан сургалт зохион байгуулж байна.

Эдгээр бичил төслийг 2017 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслийн баг бичил төсөл хэрэгжүүлж буй эдгээр байгууллагуудтай холбогдон хэрэгжилтэд нь хяналт тавин, шаардлагатай зөвлөгөөг өгч байна. Бичил төслүүдийг хэрэгжиж дуусах үед үнэлгээ хийхээр төлөвлөж байгаа бөгөөд өөр бусад байгууллагуудад ашиглах боломжтой арга зүй болон хэрэглэгдэхүүнүүдийг тодорхойлох болно.

Мөн 2017 оны 03 дугаар сард, 2017 оны 06 дугаар сараас шинээр хэрэгжүүлэх бичил төслүүдийн сонгон шалгаруулалтыг зарлахаар төлөвлөж байна.



Орхон аймгийн Насан туршийн боловсрол олгох төвд суралцаж байгаа хүүхдүүд

## БСШУСЯ болон ХНХЯ-ны үйл ажиллагаа

### БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б. Баярсайхан



Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Боловсролын тухай багц хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш боломж олгох, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон улсын гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон бүхий түвшинд бодлогын зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн боловсролын үйлчилгээ, хөгжлийн дэмжлэг хүртэх эрхтэй.

Бид өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдний сурч боловсрох орчныг сайжруулахад чиглэсэн техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний шууд хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхэд анхаарч ирсэн билээ.

Харин өнөөдөр багш, удирдах ажилтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадварыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд чанартай боловсрол олгох шаардлага бидэнд тулгараад байна.

Иймд тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн бодлогын төлөвлөлт, хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн зорилгын дагуу Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай (ЖАЙКА) хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгоно.

Энэхүү төслийн үр дүнд бий болох загварыг үндэсний хэмжээний тогтолцоо бодлогод тусгаж, үндэсний хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг улам боловсронгуй болгохоор хамтран ажиллаж байна.

### ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын дарга С.Тунгалагтамир



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хязгаарлагдмал чадавхи боломжийг ойлгож хүндэтгэх, эрт илрүүлэх, оношлох, тэдний онцлог хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг сайжруулах замаар дэмжин хөгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд бие даан оролцох боломжийг нь нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгамдсан олон асуудлын нэг болоод байна. Тэднийг боловсрол, эрүүл мэнд, сэргээн засалт, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээнд тэгш хамруулахад төр засгийн зүгээс зайлшгүй анхаарах шаардлагатай юм.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сард батлан хэрэгжүүлж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, нийгмийн халамжийн дэмжлэг авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зохицуулсан заалтуудыг тусгасан. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг байгуулан, дүрмийг Засгийн газрын тогтоолоор батлуулан ажиллаж байна. Бид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, тэдний оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. Тус хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хүмүүс нь амьдарч буй орчиндоо бусдын адил бүх шатны боловсролын үйлчилгээнд тэгш, чанартай хамрагдах боломжийг бүрдүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эрүүл мэнд, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг тулгамдаж буй олон асуудлуудыг шийдвэрлэх тодорхой зорилтуудыг тусгаад байна. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд манай яам болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төсөл томоохон хувь нэмэр оруулах юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэгт хамруулах үндэсний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ЖАЙКА-гийн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төсөлтэй хамтран ажиллахдаа бидний хувьд таатай байх болно.

Хүүхдийн төлөөх бидний хамтын ажиллагаа улам өргөжиж, сайн үйлс дэлгэрэх болтугай. .

# Нийслэлийн “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн гар зургийн уралдаан”

## Танилцуулга, зорилго



Тусгай байр: Э.Даваасангийн бүтээл (9 нас)

Жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдөр нь НҮБ-ээс зарласан “Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр” билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгэмд бие даан өсч хөгжин, сэтгэл тэнүүн амьдрахад нь туслах, хүүхдүүдэд билиг авъяасаа нээн харуулах боломжийг олгох зорилгоор БСШУСЯ, ХНХЯ-тай хамтран нийслэлийн **“Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн гар зургийн уралдаан”**-ыг зохион байгуулав.

Уралдааныг **“Миний ертөнц”** сэдвээр зохион байгуулсан бөгөөд хүүхдүүд өөрсдийн төсөөлдөг ертөнцийг чөлөөтэй дүрслэн илэрхийлсэн байлаа.

Ирүүлсэн нийт 143 бүтээлийн эхний шатны шалгаруулалтыг нийслэлийн бүх дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс болон тусгай сургуулиудад зохион байгуулсан. Ингээд БСШУСЯ болон ХНХЯ, Монголын Хүүхдийн ордны мэргэжлийн зураач багш, төслийн багийн гишүүнээс бүрдсэн шүүгчдийн баг нарийн шүүн хэлэлцсэний эцэст 12 бүтээл шалгарав.

## Шагнал гардуулах ёслол




Шагнал гардуулах ёслолд оролцогчид дурсгалын зураг татуулав

2016 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр БСШУСЯ-нд шагнал гардуулах ёслолын ажиллагаар зохион байгуулж, уралдаанд байр эзэлсэн хүүхдүүд, тэдний ар гэр, салбар комиссын гишүүд, тусгай сургуулийн багш нар зэрэг 50 орчим хүн оролцсон. ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын дарга, БСШУСЯ-ны Сууръ, бүрэн дунд боловсролын хэлтсийн дарга, Японы ЭСЯ-ны хоёрдугаар нарийн бичгийн дарга, ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч, төслийн ерөнхий менежер нар байр эзэлсэн хүүхдүүдэд өргөмжлөл, үнэ бүхий зүйл гардуулсан.

Мөн уг ёслолын ажиллагаанд харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р тусгай сургуулийн 5-р ангийн сурагч ая дууны мэндчилгээ хүргэсэн.

## Гар зургийн үзэсгэлэн ба бүтээлийн цомог



Гар зургийн үзэсгэлэн

Мөн оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 13-ны өдрүүдэд БСШУСЯ болон ХНХЯ-наас Шангри-Ла төвд гар зургийн үзэсгэлэн гаргасан бөгөөд иргэд олноор хүрэлцэн ирж, хүүхдүүдийн бүтээлийг үзэж сонирхлоо. Үзэсгэлэнгийн санал сэтгэгдлийн дэвтэрт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дүрсэлсэн ертөнцийг харахад сэтгэл ариусч байна”, “Хүүхдүүдийн зурсан зураг яагаад ч юм дотно санагдаж, хүүхэд ахуй үеийг минь бодогдууллаа” гэх зэргээр сэтгэгдлээ бичиж үлдээжээ.

Мөн төслийн зүгээс эхний шатны сонгон шалгаруулалтад оролцсон бүтээлүүдийг багтаасан “Бүтээлийн цомог”-ийг хэвлүүлэн уралдаанд оролцсон хүүхдүүд, тусгай сургуулиуд, бүх салбар комиссууд болон Төв номын санд бэлэглэсэн.




Бүтээлийн цомог

## Тэргүүн байр эзэлсэн хүүхдийн ярилцлагаас...



Э.Энххалиуны бүтээл (15 нас)

Энэ зургийг хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүх хүн бүгд адилхан өөрсдийнхөө хүссэнээр амьдрах боломжтой тийм нийгэм бий болоосой гэж бодож зурсан.

Зургийн баруун талд байгаа тэргэнцэртэй хүн цонхоор гадагшаа харж байна. Зүүн талд нь гадаа явж байгаа хүнтэй адилхан, би ч гэсэн гадаа гараад жилийн дөрвөн улирал хэрхэн өөрчлөгддөгийг мэдэрмээр байна.

Зураг дээр зурсан ном нь яагаад ийм зузаан байгаа вэ гэвэл, хуудас бүр дээр нь энэ бодлуудаа зурмаар байгаа учраас юм.

Энэ зургаа зөндөө олон хүнд үзүүлмээр байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

# Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл

2017 оны 11 дүгээр сар

Дугаар 3

## Хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг авна...



## Гарчиг:


| | |
|---|---|
| Төслийн талаар товчхон | 1 |
| Туршилтын аймаг/дүүрэг | 1 |
| Төслийн хаяг | 1 |
| Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийг дэмжих | 2 |
| “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг”-ийг туршин зохион байгуулах -Эрт үеийн дэмжлэгт холбох- | 2 |
| “Эх хүүхдийн хөтөлбөр”-ийг туршин хэрэгжүүлэх - Ээж хүүхдэд илүү ойроос дэмжлэг үзүүлэх - | 2 |
| Нэг ч атугай хүүхдэд сурч боловсрох боломж олгох - Хөвсгөл аймагт сургуульд хамрагдалтыг дэмжих туршилтын үйл ажиллагаа - | 3 |
| Бичил төслийн үйл ажиллагаа (Эхний жил) | 4 |
| Бүгд хамтдаа суралцахын чухал | 4 |


## Төслийн хаяг


- БСШУСЯ:
  Засгийн газрын III байр, 212 тоот
  Утас: 976-9424-0702
- ХНХЯ:
  Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, 224 тоот
  Утас: 976-8634-0702
- Цахим хаяг: jica15start@gmail.com
- Цахим хуудас: http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html
- Facebook: https://www.facebook.com/jicastart/


## Төслийн талаар товчхон

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам *(БСШУСЯ)*, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам *(ХНХЯ)* нь Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай *(ЖАЙКА)* хамтран 2015 оны 8 дугаар сараас эхлэн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхшээлийг эрт илрүүлэн хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд хамруулах загварыг боловсруулан (Төслийн зорилго) турших замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх (Эрхэм зорилго) зорилготой юм.

Тус төслийн 4 жилийн үйл ажиллагаа дундаа орж байна. Төслийн 2 дахь хагаст, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх, тэгш хамруулан сургах боловсролыг дээшлүүлэхэд түлхүү анхаарна. Тухайлбал “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн ашиглалтыг сайжруулах, “18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг”-ийг зохион байгуулах, “Эх хүүхдийн хөтөлбөр” болон “Портеж эрт боловсролын хөтөлбөр”-өөр дамжуулан хүүхэд, гэр бүлийг дэмжих, “Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбарыг боловсруулах ажилд хамтран оролцож мэргэжил арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн ЕБС дахь тохирох хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг дээшлүүлэх, сурлагын үнэлгээний байдлыг судлах зэрэг ажлуудыг зохион байгуулна.

## Туршилтын аймаг/дүүрэг

Төслийн туршилтын аймаг/дүүргээр Улаанбаатар хотоос Баянгол дүүрэг, орон нутгаас Хөвсгөл аймгийг сонгосон бөгөөд Улаанбаатар хотод оюуны болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг 4 тусгай сургууль, эдгээр сургуультай ойролцоо байрладаг 8 ердийн сургууль, Хөвсгөл аймагт 2 ердийн сургуулийг сонгон үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.



## Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийг дэмжих

Төслийн хүрээнд, хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор холбогдох байгууллага, хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Төслийн туршилтын Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймагт "ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах", "18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг" болон үзлэгийн дараах үйл ажиллагаа болсон "Эх хүүхдийн хөтөлбөр"-ийг туршин хэрэгжүүлэх, Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүнийг сайжруулах, Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцооны загварыг бий болгохоор зорьж байна. Эдгээр үйл ажиллагааны талаар "ХБХЭМБНХ-ын комиссын ажилтнуудад зориулсан гарын авлага"-д тусгах юм. Баянгол дүүрэгт зохион байгуулсан "18 сартай хүүхдийн эрүүл мэндийн иж бүрэн үзлэг" болон "Эх хүүхдийн хөтөлбөр"-ийн талаар энд танилцуулж байна.

### "18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг"-ийг туршин хэрэгжүүлэх - Эрт үеийн дэмжлэгт холбох -

Монгол Улсын хувьд, Өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд ЭХЭМД-ээр дамжуулан эрүүл мэндийн үзлэг, дархлаажуулалтыг зохион байгуулж байгаа боловч эрүүл мэндийн товлолт үзлэг хийгддэггүй. Тус төслийн хүрээнд бага насны хүүхдийн эрүүл мэндийн товлолт үзлэгээр хөгжлийн хоцрогдол бэрхшээлийг илрүүлэн, хүүхдийг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулдаг Японы туршлагад тулгуурлан Баянгол дүүрэгт "18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг"-ийг туршин хэрэгжүүлж эхэллээ. Хөгжлийн дэмжлэг нь хоёрдогч хөгжлийн бэрхшээл үүсэхээс сэргийлэх, хүүхдэд зайлшгүй хэрэгтэй чадвар суулгахад маш чухал үүрэгтэй байдаг. Энэхүү үзлэгийн гол зорилго бол асран хамгаалагчид, холбогдох мэргэжилтнүүд тухайн хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт үед нь анзаарч, шаардлагатай тусламж, дэмжлэгийн үйлчилгээнд холбож өгөх явдал юм.

Эрүүл мэндийн үзлэгийг туршихтай холбогдуулан Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зөвшилцсөний үндсэн дээр үзлэгийн маягтын төслийг боловсруулан, дүүргийн хэмжээнд үзлэгийг хариуцан зохион байгуулах 23 Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 109 эмчид үзлэг хийх арга барил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж, үзлэгийн маягтыг засан сайжруулсан.

Ийнхүү 2017 оны 5 дугаар сарын 8-наас 12-нд Монголд анх удаа "18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг"-ийг зохион байгуулсан. Уг үзлэгт нийт зорилтот хүүхдийн 86.3% буюу 377 хүүхдийг 5 өдрийн турш хамруулсан бөгөөд 6 дугаар сараас эхлэн сар бүрийн 4 дэх долоо хоногт үзлэгийг тогтмол зохион байгуулж хэвшлээ.

Цаашид үзлэгийн арга зүй, агуулгыг боловсронгуй болгож засан сайжруулахаар төлөвлөж байна. Үзлэг зохион байгуулах нь хүүхэд өсгөх явцад хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжилд санаа амаргүй байгаа эцэг эхэд зөвлөгөө өгөх, хүүхдээ өсгөж бойжуулахад нь дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх болно.



### "Эх хүүхдийн хөтөлбөр"-ийг туршин хэрэгжүүлэх - Ээж хүүхдэд илүү ойроос дэмжлэг үзүүлэх -

"18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг"-ийг зохион байгуулснаар, хөгжлийн дэмжлэг шаардлагатай хүүхдийг эрүүл мэндийн байгууллагаар зогсохгүй, сургуулийн өмнөх боловсрол (Ясли, цэцэрлэг), түүнчлэн бага сургуульд орох хүртэл "Холбон зуучлах дэмжлэг" шаардлагатай болох нь харагдаж байна.

Японы муж, орон нутгууд "Холбон зуучлах дэмжлэг" болгож, хүүхдийнхээ хөгжилд санаа амаргүй байгаа асран хамгаалагчдын асуултад хариулт өгч, тэднийг хүүхдээ хөгжүүлэх, хүүхэдтэйгээ ажиллах аргад сургах зорилгоор "Эх хүүхдийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлдэг.

Энэхүү туршлагаас санаа авч, 2017 оны 10 дугаар сараас Баянгол дүүрэгт уг хөтөлбөрийг турших эхэллээ. Хөтөлбөрийн үйл ажиллагаа 5-8 дугаар сард зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэгээр зөвлөгөө, дэмжлэг шаардлагатай болох нь харагдсан хүүхдүүд, тэдний ээж нарт зориулан сард 1 удаа (Хагас өдөр), нийт 5 удаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Хөтөлбөрийг Баянгол дүүргийн 8 дугаар хороон дахь "Иргэний танхим"-д зохион байгуулж байгаа ба дүүргийн ЗДТГ-ын сэтгэл зүйч, нийгмийн ажилтан 2 хүн ажилладаг ба 10 дугаар тусгай цэцэрлэг, 186 дугаар тусгай цэцэрлэгийн багш нар хамтран ажиллаж байна.

10 дугаар сарын "Эх хүүхдийн хөтөлбөр"-т нийт 10 ээж, хүүхэд оролцлоо. Хөтөлбөрийн гол агуулга нь ээж нар хүүхдүүдтэйгээ хамт тоглох, хүүхдийн хөгжилд чухалд тооцогддог "Бусадтай харьцаж нийгэмших", "Мэдрэхүйгээр дамжуулан янз бүрийн зүйлийг таньж мэдэх" үйл ажиллагаа байсан. Хүүхдүүдийн сонирхлыг хамгийн ихээр татсан зүйл нь хуучин сонингоор хийсэн шүхэр байлаа. Багш нар сонингоор нааж хийсэн том шүхрийг сэвэн холдуулж ойртуулахад хүүхдүүд салхи сэвэлзэхийг мэдрэн, цаас шаржигнан дуугарахыг сонссон бөгөөд сонингоор хийсэн шүхрийг ихэд сониучирхан харж байв.

Эх хүүхдэд илүү ойроос дэмжлэг үзүүлж, хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжин дараагийн алхамд холбох нь чухал байдаг. Үүнд "Эх хүүхдийн хөтөлбөр" ихээхэн үүрэгтэй бөгөөд уг хөтөлбөрийг цаашид сар бүр тогтмол зохион байгуулахаар төлөвлөсөн.



## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа

## Ганц ч атугай хүүхдэд сурч боловсрох боломж олгох - Хөвсгөл аймагт сургуульд хамрагдалтыг дэмжих туршилтын үйл ажиллагаа -

Төслийн баг туршилтын сургуулийн багш нартай хамтран хүүхэд нэг бүрийн хөгжлийн түвшинд тохирсон зорилтыг дэвшүүлэх, багш нарыг шинэ арга зүйд сургах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ашиглах замаар сургалтын чанарыг сайжруулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг туршин хэрэгжүүлж байна.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд янз бүрийн шалтгаанаар сургууль завсардах явдал нийтлэг хэвээр байна. Ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд ирж очих, сургууль дээрээ өнжих, бие засах, хооллох зэрэг олон асуудлууд шийдэгдээгүй тул гэртээ байхаас аргагүйд хүрч, сургуульд орох нас нь хэтрэх, ТББ-аас ажиллуулж буй хүүхэд харах үйлчилгээ болон бусад сургалтын төвд явж байгаа тохиолдол цөөнгүй байна. Түүнчлэн орон нутагт тусгай сургууль, тусгай анги байхгүй учир ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Бүх хүүхдийг тухайн орон нутгийнх нь сургуульд хамруулах үйл ажиллагааны эхний алхам болгож Хөвсгөлд аймагт сургуульд хамрагдалтыг дэмжих ажлыг эхлүүлээд байна.

Хөвсгөл аймгийн БСУГ-ын мэргэжилтэн, туршилтын 2 сургуультай хамтран гэрээр байгаа сургуулийн насны хүүхдүүдийн судалгаа хийн жагсаалт гаргаж, гэрээр нь очиж уулзан шалтгааныг тодруулахад, тухайн гэр бүл болон хүүхдийн биеийн байдлаас хамаарч "Өөрөө бие засч чадахгүй", "Хэвтэрт байдаг тул орж гарч чадахгүй" зэрэг янз бүрийн шалтгааныг дурьджээ.

Туршилтын 2 сургуулийн "Сургуульд хамрагдалтыг дэмжих комисс" тус бүр нэг хүүхэд сонгон хурал зохион байгуулсан бөгөөд уг хуралд тухайн хүүхэд, түүний эцэг эхээс гадна сургуульдаа хүлээн авч хөгжлийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн "Хөгжүүлэн сургах төв"-ийн багш, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын боловсролын асуудал хариуцсан гишүүн, ХБХ-ийн эцэг эхийн холбооны сургалтын төвийн багш нар оролцсон. Сонгосон хүүхдийн эцэг эх, хүүхдийн өөрийнх нь хүсэлтийг асууж тодруулан, хүргэж өгөх, тосож авах тухай болон хөгжүүлэх сургалтын хэлбэр, дэмжлэгийн агуулга зэрэг сургуульд сурахад гол шаардлагатай нөхцлүүдийг цогцоор нь шийдвэрлэх тухай хэлэлцэв.

Туршилтын 2 сургуульд "Хүүхэд хөгжүүлэн сургах төв" ажилладаг бөгөөд энд тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд хичээлийн өмнө болон дараа нэмэлт давтлага авах, мөн бэрхшээлийнхээ онцлогт тохирсон дэмжлэгийг авдаг байна. Энэ удаа сонгосон 2 хүүхэд эхний ээлжинд тус төвд хичээллэн хөгжлийн дэмжлэг авах болсон. Явцын дунд дуу хөгжмийн хичээл ердийн ангийн хүүхдүүдтэй хамт хичээллэх боломжийг бий болгохоор тогтсон. Цаашид сургуульдаа үргэлжлүүлэн сурах асуудлыг эцэг эх болон сургууль нь тогтмол анхаарч, байнга холбоотой ажиллах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө бодитой хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.



**СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫГ ДЭМЖИХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ХУУДАС /ЖИШЭЭ/**

| | |
|---|---|
| Огноо | 2017 оны 9 дүгээр сарын 6 |
| Хүүхдийн нэр | Б.Ганбаатар |
| Нас | 14 |
| Хүйс | ☑Эр ☐Эм |
| Сургуульд хамрагдалтыг дэмжих комиссын хуралд оролцогчид | Зорилтот хүүхдийн эцэг эх, зорилтот хүүхэд, БСУГ-ын Насан туршийн боловсрол (НТБ) хариуцсан мэргэжилтэн, ХБХ-ийн эцэг эхийн холбооны ХХ төвийн багш, ХХ сумын НТБ-ын төвийн багш, ХХ сургуулийн багш, ХХ сургуулийн хүүхэд хөгжлийн төвийн багш, ХХ сургуулийн эмч, ХХ сургуулийн нийгмийн ажилтан, төслийн баг |

| | | | |
|---|---|---|---|
| Одоо сурч байгаа цэцэрлэг, төв, сургууль | Байхгүй /гэрт/ | Суралцахыг хүсэж буй сургууль | ХХ сургуулийн хүүхэд хөгжлийн төв |
| Онош (Оношилсон огноо/ байгууллага) | Дауны хам шинж (2003 оны 12 дугаар сарын 18/Нийслэл дэх сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч) | | |
| Хүүхдийн хүсэл | Сэтгэл хөдлөлөө сайн илэрхийлж чадахгүй тул мэдэхгүй. | | |
| Эцэг эхийн хүсэл | ХХ сургуулийн хүүхэд хөгжлийн төвд явуулмаар байна.<br>Өөрийнхөө хүслийг илэрхийлж чаддаг болохыг хүсэж байна. | | |
| Ажиглалт хийж байх үед анзаарагдсан хүүхдийн онцлог | • Нийгэмшихүйн чадвар сул<br>• Аль болох бусадтай харилцуулбал зүгээр<br>• Юм сайн хардагүй байх магадлалтай<br>• Булчингийн хөгжил сул байх магадлалтай<br>• Эцэг эх нь байнга асардаг тул булчингийн хөгжил султай<br>• Ам нь байнга ангайлттай | | |
| Сургуулиас гадуур шаардагдах дэмжлэг | Төрөл | Дэмжлэгийн агуулга | Хариуцах эзэн |
| | Эрүүл мэнд | Сард 1 удаа зүүний эмчилгээ хийлгэх | Сургуулийн эмч |
| | Нийгмийн халамж | Нийгмийн халамж үйлчилгээний мөнгө авах тухай хүсэлт гаргах | БСУГ |
| | Эмчилгээ, сэргээн засал | Алхах дасгал, тэнцвэр олох дасгал хийлгэх<br>Булчин ажиллуулах дасгал хийлгэх /бие бялдарыг хөгжүүлжх/ | Биеийн тамирын багш,<br>Сургуулийн эмч |
| Нэмэлт тэмдэглэл, оролцогчдын зөвлөгөө | Байхгүй | | |

| Сургуульд суралцахад шаардлагатай дэмжлэг | Хамрах хүрээ | Шаардлагатай дэмжлэг (Сургуульд) | Шаардлагатай дэмжлэг /Гэрт/ | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| | Сургуульд явах | Сургууль дээр ирэх бүрт нь хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр хүүхдийг магтах | Байнга цагийн дагуу хүүхдийг сургуульд хүргэж өгч, авах | Төвийн багш, Эцэг эх |
| | Өдөр тутмын амьдралд | Цамцаа өмсөж сурах төлөвлөгөө гаргах. Портежийг ашиглах. | Хувцасаа солиход нь зурагт карт ашиглан туслах.<br>Багшийн гаргаж өгсөн портежийн даалгавараар ажиллах. | Төвийн багш, Эцэг эх |
| | Сургалт | Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг хэвэнд хийх. /Хэвнээс гаргах, хэвэнд хийх/ | Гэртээ ч мөн ижил даалгавар хийлгэх. | Төвийн багш, Эцэг эх |

- Шийдвэрлэх зүйлүүд

| Суралцах орчин | 1 | 2 | 3 |
|---|---|---|---|
| Хаана (Сургуулийн нэр, анги) | ХХ хөгжлийн төв | ХХ сургууль 1а Дуу хөгжим | Дуу хөгжмийн ганцаарчилсан хичээл ХХ хөгжлийн төвд тус сургуулийн дуу хөгжмийн багш ирж заана. |
| Давтамж | 7 хоногт 2 удаа | Сард 1 удаа Төвийн багштай хамт оролцох | Сард 1 удаа |
| Хугацаа | 2 цаг | 1 цаг | 30 минут |

| | | |
|---|---|---|
| Дараагийн алхам | Сургууль | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө /ГСТ/ боловсруулах. |
| | БСУГ | Хүүхдийн бодит байдлыг судалж, хөгжлийн үнэлгээ хиймээр байна. |
| | Гэр бүл | Хүүхдийг магтах/хүлээн зөвшөөрөх/, гэрийн даалгаварыг нь туслах. |

| | |
|---|---|
| Эцэг, эхийн нэр: Д.Батчимэг | БСУГ-ын хариуцсан мэргэжилтний нэр: Д.Нямсүрэн |
| Гарын үсэг | Гарын үсэг |

Хуралд ашигласан тэмдэглэл хөтлөх хуудсын жишээ

## Бичил төслийн үйл ажиллагаа (Эхний жил)

Тус төслийн хүрээнд, хүүхдүүдийн тусгай хэрэгцээт боловсролын хэрэгцээнд нийцсэн сургалтын олон төрлийн аргуудыг туршин үр нөлөөг нь судалж, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загварыг бий болгох зорилгоор жижиг хэмжээний туршилтын үйл ажиллагаар (Бичил төсөл) хэрэгжүүлж байна.

2016 оны 6 дугаар сараас 2017 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд 3 бичил төслийг хэрэгжүүлээд байна.

| “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээ” | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | “Хүүхдийн хөгжил мэдээллийн Учрал төв” ТББ |
| Төслийн агуулга | Хүүхэд харах үйлчилгээ нь 2-5 насны хүүхдийг өдрийн турш харж асрах үйлчилгээ юм. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдсан хувь хүн, төрийн бус байгууллага нь хувийн болон байгууллагынхаа байранд ойр амьдардаг хүүхдүүдийг харж асрах үйлчилгээ үзүүлдэг. Энэхүү үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдах боломжтой гэж заасан боловч, одоо ашиглаж буй сургалтын агуулгад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, тэднийг хэрхэн сургаж хөгжүүлэх талаар тодорхой аргачилсан заавар зөвлөмж байхгүй тул “Хүүхдийн хөгжил мэдээллийн Учрал төв” ТББ нь бичил төслөөрөө дамжуулан хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад шаардлагатай мэдлэг чадвар, арга зүйг эзэмшүүлэх сургалтын модуль боловсруулан төсөл хэрэгжих дүүргүүдэд сургалт зохион байгуулсан. |

| “Бид сурч чадна” (Насан туршийн боловсрол олгох төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүлээн авч сургах төсөл) | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | Орхон аймаг “Албан бус боловсролоор насан туршийн боловсрол олгох төв” |
| Төслийн агуулга | Сургуульд сурдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, насанд хүрсэн хүмүүст албан бус боловсролоор боловсрол олгож, НТБТ-д ирэх боломжгүй хүүхдүүдэд зориулан явуулын сургалт зохион байгуулан ажилласан. |

| “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд боловсролын тэгш оролцоог хангах нь” | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | “Монголын дауны холбоо” ТББ |
| Төслийн агуулга | Нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 130-р сургуульд сургуулийн насны даунтай хүүхдүүдийн суралцах анги нээсэн. Багш нарын тусламжтайгаар туршилтын ангийн хүүхдүүд ердийн ангийн хүүхдүүдтэй хамт биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлагийн хичээлд оролцдог болсон. |

## Бүгд хамтдаа суралцахын чухал

Монголын дауны холбооны “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд боловсролын тэгш оролцоог хангах нь” төсөл нь Хан-уул дүүргийн 130-р сургуультай хамтран даунтай хүүхдэд зориулсан туршилтын анги нээсэн билээ. Уг ангид одоо 10 хүүхэд суралцаж байгаа ба хүүхдүүд бие даан өөртөө үйлчилж сурахад чиглэсэн үйл ажиллагаа, бага ангийн математик, эх хэлний хичээлийг туршилтын ангид орж байна. Харин биеийн тамир, дуу хөгжмийн хичээлд 130-р сургуулийн 3, 4, 5-р ангийн хүүхдүүдтэй хамт суудаг. Зөвхөн хичээл бус, урлаг спортын тэмцээн уралдаанд ч мөн бусад ангийн сурагчидтай хамтран оролцож байна.

Анх ердийн ангийн сурагчид гадаад төрхийн онцлог бүхий даунтай хүүхдүүдийг хачирхан хардаг байсан бол, хичээл сургалт, бусад арга хэмжээнд хамтдаа оролцох болсноор аажмаар хүүхдүүд хичээлийн үед даунтай хүүхдүүдийн сайн ойлгохгүй байгаа зүйлийг зааж өгөх, ангид нь хөтлөн хүргэж өгөх, мөн тосохоор ирдэг болжээ.

Бичил төслийн хүрээнд, 130-р сургуулийн багш нарын дауны хам шинжийн талаарх ойлголт, хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Багш нарын ойлголт, хандлага дээшилснээр хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд илүү идэвхтэй хамтарч ажиллах болсон.

Төслийн сүүлийн хагаст эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан. Зарим нэг эцэг эхчүүд “Манай хүүхэд яагаад заавал даунтай хүүхэдтэй хамт сурах ёстой юм бэ” гэж байсан хэдий ч, уг сургалтад хамрагдсанаар даунтай хүүхэд, тэгш хамруулан сургах боловсролын чухлыг ойлгон хүлээн авах болж, асран хамгаалагчдын хандлага өөрчлөгдсөн байна.

2017 оны 9 дүгээр сарын шинэ хичээлийн жилээс уг туршилтын ангийг 63-р тусгай сургуулийн салбар анги өөрчилж, Хан-Уул дүүрэгт албан ёсоор бүртгэгджээ.






БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
JICA
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн сонин**

2019 оны 3 дугаар сар

Дугаар 4

## Хүүхдэд үзүүлэх цогц дэмжлэг үйлчилгээ

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” нь 2015 оны 8 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн зорилго нь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг болон боловсролын тогтолцооны загварыг бий болгох явдал юм. Төслийн баг, энэхүү тогтолцооны загварыг бий болгоход чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг Нийслэлийн Баянгол дүүрэг, орон нутгаас Хөвсгөл аймаг, түүнчлэн эдгээр аймаг, дүүргийн зарим сургуулиудад зохион байгуулж байна.

Төсөл хэрэгжих хугацаанд буюу 2016 оны 2 дугаар сард Монгол Улсын Их хурал “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийг баталсан. Уг хуулинд заасан олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар сард “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (321-р тогтоол)”-ийг боловсруулан, Улсын Их Хурлаар батлуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санал бодлыг төрийн бодлогод тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан үйлчилгээг сайжруулах зэргээр төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тогтоосон. Харин тус төсөл нь баргацаалбал 3 жил хагасын турш, дараах зурагт үзүүлсэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн туршилтын үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.



*Сургууль, цэцэрлэгийн тоог БСШУСЯ-ны статистик мэдээ (2017-2018 хичээлийн жил)-ээс авав.

Эдгээр туршилтын үйл ажиллагааны үр дүнг эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, боловсролын дэмжлэгийн тогтолцоо, түүнд холбогдох байгууллагуудын чиг үүргийг илтгэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-т нэгтгэн боловсруулж, уг зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/304, А/699, А/460 тоот тушаалаар 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлуулсан билээ. Төслийн хугацаа удахгүй дуусах гэж байгаа ч, **бүх хүүхэд эрэлт хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэх** зорилгын үүднээс цаашид ч үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

☆ Цахим хаяг: jica15start@gmail.com
☆ Утас: 976-9424-0702, 976-8634-0702
☆ Цахим хуудас: http://www.jica.go.jp/project/mongolia/013/index.html
☆ Facebook: https://www.facebook.com/jicastart/

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтыг бодит болгоход чиглэсэн үйл ажиллагаа

Төслийн баг туршилтын аймаг, дүүргийн салбар комисстой хамтран, дэмжлэг үйлчилгээ хүндрэлтэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх чиглэл, төлөвлөгөө боловсруулах "Кэйс хэлэлцүүлэг"-ийг тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд кэйс хэлэлцүүлгээр дамжуулан ДЭМБ-ын "Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)"-ын ойлголтод суурилсан хөгжлийн үнэлгээ хийж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж байна.

Кэйс хэлэлцүүлэгт дараах 3 зарчмыг онцгойлон анхаарч байна. Нэгд, тухайн хүүхэд нийгэмд бусад хүүхдүүдийн адил сурч боловсрох, өсч хөгжихөд дэмжлэг үзүүлэхийг гол зорилт болгох. Тухайлбал "Цэцэрлэгт оруулах", "Гэрийнхэнтэйгээ хамт дэлгүүр явж сурах" зэрэг энгийн зорилт дэвшүүлэн, түүнд шаардагдах зүйлүүдийг судалж хэрэгжүүлэх. Хоёрт, амьдралын бүх нөхцөл байдлыг нь судлан үзүүлэх дэмжлэгээ төлөвлөх. Зөвхөн хөгжлийн бэрхшээлд нь анхаараад зогсохгүй, тухайн хүүхдийн давуу тал, ар гэрийн орчин, амьдарч буй газрын нөхцөл байдал зэрэг тухайн хүүхдийг тойрсон бүхий л орчны талаар мэдэж авахыг хичээх. Улмаар хөгжлийн бэрхшээлд нь шаардлагатай хөгжүүлэх арга хэмжээг (Эмчилгээ, сэргээн засалт зэрэг) авах төдийгүй, гэр бүл болон нийгэмд нөлөөлөх ажлыг ч дэмжлэгийнхээ нэг хэсэг болгох.

Гуравт, салбар комисс ба бусад байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллах. Туршилтын аймаг, дүүрэгт боловсруулсан дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг амьдралд хэрэгжүүлэхэд тухайн аймаг, дүүрэг дэх холбогдох төрийн байгууллага болон сургуулиудын уялдаатай үйл ажиллагаа үр дүнгээ өгч байна.

Салбар комисс төвтэй кэйс хэлэлцүүлгийг зохион байгуулснаар аль болох олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах боломжтой болно.



Кэйс хэлэлцүүлгээр боловсруулсан дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөний жишээ

Боловсруулсан: 2018.08 сар

| | | | |
|---|---|---|---|
| Нэр | М | Хүүхдийн хүсэл | Гэрийнхэнтэйгээ хамт дэлгүүр явдаг болох. |
| Нас | 5 нас 1 сартай | Асран хамгаалагчийн хүсэл | Бусад хүүхдийн адилаар өсгөж бойжуулах. Өөрийгөө илэрхийлдэг болгох. |
| Хүйс | Эр | | |

| Жилийн дараа хүрэх зорилт | Сургуульд явдаг болгох | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Жилийн дараах зорилтоо биелүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудал ба хэрэгцээ шаардлага | Дэмжлэгийн зорилт | Хүрэх цаг үе, хугацаа | Дэмжлэгийн агуулга (Давтамж, хугацаа) | Хариуцах байгууллага, мэргэжилтэн |
| 1 | Өөрийнхөө санаа бодол, хүсэж буй зүйлээ хэлж чаддаггүй. | Өдөр тутмын амьдралд ойр зуурын дохионы хэлээр ашиглаж сургах. | 2019.06 сар | Долоо хоногт 1 удаа дохионы хэлний хичээлд суулгах. | Салбар комиссын боловсролын мэргэжилтэн, Тусгай сургууль |
| 2 | Тэргэнцэрийнх нь хэмжээ тохиромжгүй. | Өөрт нь тохирсон тэргэнцэртэй болгох. | 2018.10 сар | Сэргээн засалтын төвийн шугамаар тэргэнцэр олгох. | Салбар комиссын халамжийн мэргэжилтэн, Сэргээн засалтын төв |
| 3 | Орцны шат нь налуу замгүй тул гадаа гарахад хэцүү байдаг. | Орцных нь шатанд налуу хийж өгөх. | 2018.11 сар | Сум, баг, хорооны туслалцааг авч, налуу замтай болгох. | Салбар комисс, Сум, баг, хороо |
| 4 | Сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авахаас зайлсхийх хандлагатай. | Элсэх сургуулийнх нь захирал, сургалтын менежерийг М хүүгийн талаар ойлголттой болгох. | 2019.07 сар | • Салбар комиссын гишүүн, цэцэрлэгийн багштай хамт М хүүг сургуульд хамруулах асуудлаар сургуультай нь уулзаж мэдээлэл өгөх.<br>• М хүү болон асран хамгаалагчийг нь сургуультай танилцуулах | Салбар комиссын боловсролын мэргэжилтэн, цэцэрлэг, сургууль |

## Аутизмтай хүүхдийн асран хамгаалагчдад зориулсан гарын авлага боловсруулав

Аутизмтай хүүхдийн асран хамгаалагчид болон дэмжлэг үзүүлж буй байгууллагууд, эмнэлгийн мэргэжилтнүүдийн аутизмын хүрээний эмгэгийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор төслийн баг энэхүү гарын авлагыг боловсруулан гаргалаа.

"Аутизмын хүрээний эмгэгийн тухай ойлгох нь" хэмээх нэгдүгээр бүлэгт, аутизмын оношилгооны стандарт, шинж тэмдэг, давуу болон сайн талууд, дэмжлэг үзүүлэх боломжтой байгууллагуудыг танилцуулсан. "Монголын аутизмын холбооны гишүүдийн ирүүлсэн асуултад хариулах нь" гэсэн хоёрдугаар бүлэгт, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй асран хамгаалагчдын ирүүлсэн 29 асуултад өгөх хариулт, сургуулийн насны хүүхэдтэй асран хамгаалагчдаас ирүүлсэн 30 асуултад өгөх хариултыг багтаасан.

Энэхүү гарын авлагыг төслийн цахим хуудас болон Facebook хуудсаас татаж авах боломжтой тул та бүхэн чөлөөтэй ашиглах боломжтой.



# Дэмжлэг шаардлагатай хүүхдэд сургууль нийтээрээ дэмжих тогтолцоо - Сургуулийн дэмжлэгийн зөвлөл -

Анх туршилтын сургуулиудад очиход, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангийн багш нь ганцаархнаа арга зүйгээ төлөвлөж чадахгүй цөхрөх, эцэг эх болон хүүхэд нь хэцүү байгаагаа хэлж ойлгуулж чаддаггүй зэрэг тохиолдлууд гардаг байсан. Сургуульд орсон ч өөртөө тохирсон дэмжлэг авч чаддаггүйн улмаас сурах сонирхолгүй болох, бусад хүүхдүүд доог тохуу хийх гэх мэт асуудал гардаг байжээ.

Харин сургуулийн зүгээс үзүүлэх дэмжлэг хүүхэд бүрт харилцан адилгүй байх ёстой. “Энэ арга зүйгээр явбал бүх хүүхдүүд адилхан сурна” гэсэн тусгай жор байхгүй бөгөөд хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийн арга зүйг сонгох шаардлага үүсдэг. Иймд сургууль нийтээрээ хамтран дэмжлэг шаардлагатай хүүхдэд үзүүлэх дэмжлэгээ бодож олохын тулд тус төсөл туршилтын сургуулиуддаа Сургуулийн дэмжлэгийн зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг нь туршин хэрэгжүүлж эхэлсэн юм. Сургуулийн дэмжлэгийн зөвлөл нь дэмжлэг шаардлагатай хүүхдийн жагсаалт боловсруулах, үзүүлэх дэмжлэгээ хэлэлцэх, тэгш хамруулан сургахад чиглэсэн багшийн мэргэжил, арга зүйг дээшлүүлэх сургалт болон тухайн орон нутгийнхаа иргэдэд чиглэсэн сургалтууд зохион байгуулах зэрэг үүрэг хүлээдэг. Зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвхөн сургуулийн удирдлага төдийгүй, шаардлагатай тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл, сум, баг, хорооны нийгмийн ажилтнуудыг хамруулах боломжтой. Гишүүдээс томилогдсон нарийн бичгийн дарга нь аливаа хурал, уулзалтын бэлтгэлийг хангах, бусад гишүүдтэй холбоо барих зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэдэг. Мөн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлуудыг сургуулийнхаа бусад багш нарт заавал мэдээлэх шаардлагатай байдаг.

### Сургуулийн дэмжлэгийн зөвлөлийн ажил, үүрэг

- Дэмжлэг шаардлагатай хүүхдийг сонгох
- Хүүхдийн бодит байдалд судалгаа хийх
- Хүүхэд бүрт шаардлагатай дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах
- Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих
- Шаардлагатай тохиолдолд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Багш нар болон эцэг эх, асран хамгаалагчид, тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах
- Тодорхой нэг хүүхэд сонгон кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах, багш нарын ойлголтыг сайжруулах, мэдээллээр хангах

### Сургуулийн дэмжлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн (жишээ)

- Захирал
- Сургалтын менежер
- Нийгмийн ажилтан
- Бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч
- Дунд ангийн багш
- Сургуулийн эмч
- Баг/хорооноос хариуцах мэргэжилтэн
- Харъяа Боловсролын газар/хэлтсийн хариуцсан мэргэжилтэн

4. Сургууль дээр хэрэгжүүлэх боломжтой дэмжлэгийн агуулга






Хөвсгөл аймаг дахь туршилтын 2 сургуульд 2018 оны 4 дүгээр сард “Сургуулийн дэмжлэгийн зөвлөл”-ийг байгуулав. Сургуулийн захирал зөвлөлийн гишүүдийг томилж, нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Энэхүү зөвлөл 2018 оны 5 дугаар сард анхны хурлаа зохион байгуулсан (Баруун талын зураг) бөгөөд зохицуулалтын үүрэг хүлээсэн сургуулийн нийгмийн ажилтан бусад гишүүдэд зарлан мэдэгдэж, хурлын өөрөөний бэлтгэлийг хангасан. Эхний хурлын зорилго нь дэмжлэг шаардлагатай хүүхдийг сонгох, тухайн хүүхдэд үзүүлэх дэмжлэгийн чиглэлийг тогтоох явдал байв. Хурлын өмнө, нийгмийн ажилтан нь анги удирдсан багш нараас дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн талаарх мэдээллийг цуглуулж, жагсаалт гаргасан. Уг жагсаалтыг үндэслэн, ямар асуудал тулгамддаг болох, ямар дэмжлэг шаардлагатай болох, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах эсэх зэрэг асуудлуудаар хэлэлцэж ярилцсан. Хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар анги удирдсан багш нарт ч мэдээлэл өгсөн.

Сургуулийн дэмжлэгийн зөвлөл зохион байгуулагдсанаар анги удирдсан багш нар төдийгүй, бусад багш нар ч дэмжлэг шаардлагатай хүүхдэд анхаарал хандуулах болсны зэрэгцээ, эцэг эх, асран хамгаалагчидтай уялдаж ажилладаг болсон. Мөн гаднах байдлаараа бараг анзаарагдахгүй хөгжлийн хоцрогдолтой болон суралцахуйн асуудалтай хүүхдүүдийн ар гэрийн орчин нөхцөл, анги танхим дахь байдлыг багш нар зөвлөн ярилцах боломжтой болсон нь энэхүү зөвлөлийн давуу тал болсон юм.

## Бичил төслийн үйл ажиллагаа (II дахь шат)

Төслийн хүрээнд, хүүхдүүдийн боловсролын тусгай хэрэгцээнд нийцсэн олон төрлийн сургалтын арга хэлбэрийг туршин хэрэгжүүлж, түүнээс гарсан үр дүнг судлан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломж бүхий загвар боловсруулах зорилгоор жижиг хэмжээний туршилтын төслийг (Бичил төсөл) хэрэгжүүлсэн. 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 6 дугаар сарын хооронд нийт 3 бичил төсөл хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр төслийн талаар дор товч танилцуулж байна.

**“Хөгжлийн бэрхшээл- хөгжих саад биш”**
**(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх хичээлийн бус үйл ажиллагаа)**

| | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | Ховд аймгийн Жаргалант сумын 7-р сургууль |
| Төслийн агуулга | Сургуулийнхаа нэг танхимыг “Хүүхэд хөгжлийн төв“ болгон тохижуулсан бөгөөд тус сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хөгжим, бүжиг, гар урлал зэрэг хичээлийн бус үйл ажиллагаанд оролцох боломжтой болсон. Энэ ажилд эцэг эхчүүдийн дэмжлэгийг авсан ба хүүхдүүдийн харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, урлагийн үзлэг, спортын тэмцээн, экскурс хичээл зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд адил тэгш эрхтэй оролцдог болгоход анхаарсан. |

**“Сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах төсөл”**

| | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | МУБИС-ийн харъяа 249-р цэцэрлэг |
| Төслийн агуулга | Цэцэрлэгт явдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд долоо хоногт 1 удаа бүлгийн сургалтад оролцсон. Мөн ердийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авч, МУБИС-ийн багш нарын сургалтаар дамжуулан, багшлах арга зүйгээ сайжруулсан. |

**“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрт оролцооны хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүн бүтээх”**

| | |
|---|---|
| Хэрэгжүүлэгч байгууллага | “Сонсголгүйн боловсрол” ТББ |
| Төслийн агуулга | Сонсголын болон оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үг, өгүүлбэрийг дохио, зураг, кирилл үсгээр илэрхийлсэн харилцааны картуудыг боловсруулан хамтран ажилладаг сургуулиудад туршиж байна.<br>1) Дохионы хэлний зурган карт<br>2) Дохионы хэлтэй харилцааны карт<br>3) Дохионы хэлтэй өгүүлбэртэй зурган карт |

## “Тэгш хамруулан сургах боловсрол” цахим сургалтын хэрэглэгдэхүүн

Тэгш хамруулан сургах боловсролын талаар боловсролын салбарын аль болох олон мэргэжилтнүүд сурч мэдэн, сонирхол хандуулаасай гэсэн үүднээс “Тэгш хамруулан сургах боловсрол” сэдэвт цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсрууллаа. Энэхүү цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын өмнөх цахим сургалтад ашиглаж эхэлсэн бөгөөд цахим сургалтын нэвтрэх нэр (ID), нууц үгийг ашигладаг бүх багш нар танилцах боломжтой. Харин нэвтрэх эрх аваагүй бусад хүмүүсийн хувьд, ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын нэр бүхий Youtube сувгаас үзэж болно. Нийт 9 удаагийн цахим лекцүүдээс гадна, лекцийн агуулгыг танилцуулах “Эхлэл” болон сэргээн санахад зориулсан “Дүгнэлт” хэсгээс бүрдэж байна. Цахим лекцүүдийг 3 модульд хуваасан ба модуль бүрийн төгсгөлд ойлголтыг тандах зорилгоор “Шалгах тест” оруулж өгсөн.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн цахим хаяг: http://esurgalt.itpd.mn/

ЖАЙКА, Монгол дахь төлөөлөгчийн газрын цахим хаяг: https://www.youtube.com/user/JICAmongolia/videos

| д/д | Сургалтын нэр | Сургагч багш |
|---|---|---|
| | Эхлэл (Агуулгын тайлбар) | БМДИ-ийн арга зүйч Ч.Жаргал |
| **1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүрээлэн буй орчин** | | |
| 1 | Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ? | “Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлын тухай сургалт (DET)”-ын Сургагч багш Б.Энхням |
| 2 | Олон улсын чиг хандлага (Саламанкагийн тунхаглал, ХБХ-ий эрхийн тухай конвенци, Тэгш хамруулан сургах боловсрол) | МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн багш Э.Мөнхбат |
| 3 | Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин, Үндэсний хөтөлбөр, зохион байгуулалт, дүрэм журам | БСШУСЯ, Ерөнхий боловсролын бодлогын газрын мэргэжилтэн Б.Гэрэлтуяа |
| **2. Тэгш хамруулан сургадаг сургуулийн тогтолцоо** | | |
| 4 | Сургуулийн дэмжлэгийн тогтолцоо<br>- Сургуулийн дэмжлэг<br>- Сургуулийн дэмжлэгийн зөвлөл<br>- Хөвсгөл аймгийн жишээ | Хөвсгөл аймгийн БСУГ-ын мэргэжилтэн Д.Баасансүрэн |

| д/д | Сургалтын нэр | Сургагч багш |
|---|---|---|
| 5 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тухай ойлголт<br>- ГСТ гэж юу вэ?<br>- ГСТ боловсруулах аргачлал | 25-р тусгай сургуулийн согог зүйч багш М.Батмөнх |
| 6 | Тохирох хэрэглэгдэхүүн | БМДИ-ийн арга зүйч Ч.Жаргал |
| **3. Хөгжлийн бэрхшээлийн онцлог түүний тухай ойлголт** | | |
| 7 | Хөгжлийн бэрхшээлийн онцлогийн тухай ойлголт<br>- Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, оюуны бэрхшээл, даун, аутизм | 70-р тусгай сургуулийн согог зүйч багш Б.Энхтуяа |
| 8 | 8-1 Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог<br>8-2 Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог | 29-р тусгай сургуулийн багш Н.Бурмаа, М.Ариунзул<br>116-р тусгай сургуулийн багш Д.Хорлоо |
| 9 | Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн асуудалтай хүүхдэд үзүүлэх дэмжлэг | МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн ТХБ-ын тэнхмийн эрхлэгч Г.Батцэнгэл |
| | Дүгнэлт | БМДИ-ийн арга зүйч Ч.Жаргал |

Тус төслийн хэрэгжих хугацаа 2019 оны 6 дугаар сард дуусгавар болно. Цаашид Монгол Улсын хэмжээнд, бүх хүүхэд өөрийн онцлог хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг болон чанартай боловсролын үйлчилгээг хүртдэг болгоход холбогдох бүх байгууллага, мэргэжилтнүүд хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

Хавсралт 7.

Төслийн эцсийн төлөв байдлын судалгааны тайлан

# “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

## Эцсийн төлөв байдлын судалгааны тайлан

**2019 оны 07 дугаар сар**

**Судалгаа, зөвлөх үйлчилгээний Коэй хувьцаат компани**

# Гарчиг

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 1

БҮЛЭГ 2. ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА ..... 3
1. Судалгааны зорилго ..... 3
2. Судалгааны үндсэн агуулга болон аргачлал ..... 3

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ДАХЬ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ..... 11
1. Эрхэм зорилго ..... 11
2. Зорилт 1 ..... 16
3. Зорилт 2 ..... 23

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ ..... 34

Хавсралт материалууд

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИСС ..... 1
1. Ерөнхий мэдээлэл ..... 1
2. Ажлын туршлага ..... 8
3. Мэдлэг, чадвар ..... 15
4. АСУУЛГЫН ХУУДАС ..... 24

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮД ..... 31
1. Ерөнхий мэдээлэл ..... 31
2. Ажлын туршлага ..... 32
3. Мэдлэг чадвар ..... 39
4. (Зөвхөн сургагч багш нар) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц ..... 43
5. АСУУЛГЫН ХУУДАС ..... 47

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 3. ТУРШИЛТЫН ТУСГАЙ, ЕРДИЙН СУРГУУЛИУД БОЛОН ТУРШИЛТЫН АЙМАГ, ДҮҮРГИЙН ТУРШИЛТЫН БУС СУРГУУЛИУД ..... 54
1. Ерөнхий мэдээлэл ..... 54
2. Тохируулгат орчин ..... 60
3. АСУУЛГЫН ХУУДАС ..... 74

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 4. ТУРШИЛТЫН СУРГУУЛИЙН БАГШ НАР ..... 78
1. Ерөнхий мэдээлэл ..... 78
2. Ажлын туршлага ..... 81
3. Мэдлэг, чадвар ..... 88
4. АСУУЛГЫН ХУУДАС ..... 111

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү бүлэгт төслийн эцсийн шатанд хийсэн судалгааны талаар танилцуулав.

1. Төслийн нэр: “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

2. Төсөл хэрэгжсэн хугацаа: 2015 оны 08 дугаар сараас 2019 оны 07 дугаар сар

3. Хэрэгжүүлэгч байгууллага:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (Цаашид БСШУСЯ гэх)
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Цаашид ХНХЯ гэх)

4. Зорилтот аймаг, дүүрэг (Туршилтын аймаг, дүүрэг) ба сургуулиуд:

- Зорилтот аймаг, дүүрэг: Нийслэлийн Баянгол дүүрэг, Хөвсгөл аймаг
- Зорилтот сургуулиуд: 25, 55, 63, 70 дугаар тусгай сургуулиуд

  Нийслэлийн 16, 26, 28, 34, 35, 79, 111, 113 дугаар ердийн сургуулиуд

  Хөвсгөл аймгийн Ирээдүй 21 дүгээр зуун цогцолбор сургууль, Титэм 2 дугаар сургууль




*Бүдүүвч, зураг 1 Зорилтот аймаг, дүүрэг (Туршилтын аймаг, дүүрэг) ба сургуулиуд*

## 5. Төслийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд (Project Design Matrix: PDM) суурилсан хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлтийг Хүснэгт 1-1-д харуулав.

*Хүснэгт 1-1 Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт*

| Эрхэм зорилго | Шалгуур үзүүлэлт |
|---|---|
| Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэх. | Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна. |
| **Төслийн зорилго** | **Шалгуур үзүүлэлт** |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох. | Төслийн үйл ажиллагааны явцад боловсруулсан хэрэглэгдэхүүн нь (Заавар, журам, хөтөлбөр, удирдамж, хичээл г.м) БСШУСЯ болон ХНХЯ-аар батлагдсан байна. |
| **Зорилт 1** | **Шалгуур үзүүлэлт** |
| Туршилтын аймаг, дүүрэг дэх холбогдох байгууллагуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийг хэрэгжүүлэх чадавх бэхжинэ. | 1. Үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирсан байна.<br>2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс" буюу Комисс[1], Салбар комисс чадавхжсан байна. |
| **Зорилт 2** | **Шалгуур үзүүлэлт** |
| Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ. | 1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах гарын авлага боловсруулагдсан байна.<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө сайжирсан байна.<br>3. Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирсан байна.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сайн хичээл, сайн туршлагын эмхэтгэл боловсруулагдсан байна. |
| **Зорилт 3** | **Шалгуур үзүүлэлт** |
| Бичил төслөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн төрөл бүрийн боловсролын үйлчилгээний хэлбэр, загвар, түүний үр дүн батлагдана. | Бичил төслийн үнэлгээ |
| **Зорилт 4** | **Шалгуур үзүүлэлт** |
| Зорилт 1-3-ын холбогдох хүмүүсийн туршлагыг хуваалцан, үндэсний бодлого тогтолцоонд тусгасан байна. | 1. БМДИ-ийн үндсэн сургалтын чанар сайжирна.<br>2. Багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөр сайжирна.<br>3. Тусгай сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр сайжирна.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан аян хэрэгжинэ. |

[1] 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 200 дугаар тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комисс"-ын нэр томъёоноос "Төв комисс" гэдэг үгийг хасаж, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс" (Цаашид комисс гэх) болгож өөрчилсөн.

## БҮЛЭГ 2. ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Төслийн “Эцсийн төлөв байдлын судалгаа”-г 2015 оны 08 дугаар сараас эхэлсэн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн 4 жилийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхийн сацуу төслийн үр дүнг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж, цаашид тогтвортой үргэлжлүүлэхэд лавлагаа болгох зорилгоор зохион байгуулав. Тус судалгааг 2018 оны 10 дугаар сараас 12 дугаар сарын хугацаанд 4 удаа хэсэгчлэн явуулсан болно. Судалгааны талаар дараах хэсэгт танилцуулав.

### 1. Судалгааны зорилго

Эцсийн төлөв байдлын судалгаа нь үндсэн 2 зорилготой. Үүнд:

1) Төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд тэмдэглэсэн эрхэм зорилго, төслийн зорилтууд, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг ашиглан төсөл хэрэгжих хугацаанд зорилт тус бүр биелсэн эсэхийг үнэлэх;
2) Төслийн үйл ажиллагааны үр дүнгийн чанар, амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс, орхигдсон асуудлууд, алдаа зэрэгт нарийвчилсан дүн шинжилгээ хийх замаар цаашид тус төслийн үр дүнг бодлого, тогтолцоонд тусгахад ашиглах;

### 2. Судалгааны үндсэн агуулга болон аргачлал

Дээр дурдсан зорилгыг хангахын тулд 4 зорилтот бүлгийг судалгаанд хамруулан үр дүнг нэгтгэн эцсийн төлөв байдлын судалгааг хийв.

Судалгааны агуулгыг дараах хүснэгтэд тусгаж, зорилтот сэдэв тус бүрийн судалгааны үр дүнг Хавсралт-д дэлгэрэнгүй танилцуулав.

*Хүснэгт 2-1. Судалгааны бүтэц, аргачлал*

| Зорилтот бүлэг | Хэрэгжих хугацаа | Үндсэн үзүүлэлт | Дэд үзүүлэлт | Аргачлал |
|---|---|---|---|---|
| Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комисс” | 2018.10 | Ерөнхий мэдээлэл | • Салбар комисст гүйцэтгэж буй ажил үүргийн талаарх ойлголт<br>• Ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад сууж байсан эсэх | Асуулгын хуудас |
| | | Ажлын туршлага | • Ээлжит хуралдаанаар хэлэлцсэн хүүхдийн тоо<br>• Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа<br>• Комиссын талаарх мэдлэг ойлголт, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүмүүсийн тоо | Асуулгын хуудас |
| | | Мэдлэг, ур чадвар | • Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт | Асуулгын хуудас |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 2018.10, 12 | | • Хөгжлийн үнэлгээ хийх чадвар<br>• Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар<br>• Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар | Ярилцлага |
| Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд | 2018.10 | Ерөнхий мэдээлэл | • Ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад сууж байсан эсэх | Асуулгын хуудас |
| | | Ажлын туршлага | • ЭХЭМД ашиглах арга зүй<br>• Эрүүл мэндийн үзлэг хийдэг эсэх<br>• Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа<br>• Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг ойлголт, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүмүүсийн тоо | Асуулгын хуудас |
| | | Мэдлэг, ур чадвар | • Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт (Тест) | Асуулгын хуудас |
| | 2018.11 | | • (Зөвхөн сургагч багш нар[2]) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц | Ярилцлага<br>Асуулгын хуудас |
| Туршилтын тусгай болон ердийн сургуулиуд, туршилтын аймаг, дүүргийн сургуулиуд | 2018.10-11 | Ерөнхий мэдээлэл | • Суралцагч, багш, ээлжийн тоо<br>• Хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо<br>• Бусад сургууль руу шилжсэн, гарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | Асуулгын хуудас |
| | | Тохируулгат орчноор[3] хангах | • Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах<br>• Үнэлгээний аргачлал<br>• Багшийн нэмэлт цалин, урамшуулал<br>• Сургуулийн орчин<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авах хандлага<br>• Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа<br>• Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүмүүсийн тоо | Асуулгын хуудас |
| | 2018.10-11 | Ерөнхий мэдээлэл | Ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад сууж байсан эсэх | Асуулгын хуудас |

[2] Төслийн хүрээнд ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах зорилгоор эмч нарт зориулан зохион байгуулсан сургалтад Баянгол дүүргийн 6 эмч, Хөвсгөл аймгийн 8 эмч тус тус хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн.

[3] Тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ. (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, 2 дугаар зүйл)

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ажлын туршлага | • Хичээл зааж байсан туршлага<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авах хандлага<br>• Багшлах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх байдал | Асуулгын хуудас |
| | | Мэдлэг, ур чадвар | • Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт (Тест) | Асуулгын хуудас |
| Туршилтын сургуулиудын багш нар | 2018.08, 09 | | (Зөвхөн туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэг[4])<br>• Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний харьцуулалт<br>• Хичээлийн харьцуулалт<br>• Ердийн сургуульд үзүүлж буй зөвлөн туслах үйл ажиллагаа | Ярилцлага |
| | 2018.10-12 | | (Зөвхөн туршилтын ердийн сургуулийн ажлын хэсэг [5])<br>Тохируулгат орчноор хангах | Ярилцлага |

Хүснэгт 2-2-т Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй дахь шалгуур үзүүлэлт тус бүртэй холбоотой судалгааны мэдээллийг харуулав.

2016 оны 03- 04 дүгээр сар болон 2017 оны 01 дүгээр сард тус тус хийсэн суурь судалгааны үр дүнг эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнтэй харьцуулах замаар төсөл хэрэгжихээс өмнөх, хойших үеийн байдал, туршилтын сургууль болон туршилтын аймаг, дүүрэг дэх сургуулиудыг харьцуулан судалж төслийн үр дүнг баталгаажуулсан болно. Шилжилт хөдөлгөөний улмаас суурь судалгаанд хамрагдсан хүмүүсийг эцсийн төлөв байдлын судалгаанд хамруулах боломжгүй байсан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдсан зэрэг төслийн хугацаанд болж өнгөрсөн зарим үйл явдлууд нөлөөлсөн байж болзошгүйг онцлох нь зүйтэй.

Дараагийн бүлэгт төслийн Эрхэм зорилго, Зорилт 1, Зорилт 2-ын хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагаанд хийсэн эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулах болно.

[4] Туршилтын бүх тусгай сургуулиуд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 10 орчим багштай ажлын хэсэг байгуулагдсан.
[5] Туршилтын ердийн сургуулиуд мөн адил.

*Хүснэгт 2-2 Төслийн хүрэх үр дүнгийн хураангуй болон цуглуулсан мэдээлэл хоорондын харилцан хамаарал*

| Эрхэм зорилго | Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл | Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо | Тус тайланд тэмдэглэсэн хэсэг |
|---|---|---|---|---|
| Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэх. | Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ. | • Туршилтын сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | • Туршилтын 14 сургуулийн удирдах ажилтан: 14 хүн<br>• Баянгол дүүргийн туршилтын бус 13 сургуулийн [6]удирдах ажилтан: 13 хүн<br>• Хөвсгөл аймгийн туршилтын бус 30 сургуулийн [7]удирдах ажилтан: 30 хүн | Бүлэг 3<br>1-1 |
| | (Нэмэлт) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанаар [8] орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ. | • Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын ээлжит хуралдаанаар хэлэлцсэн хүүхдийн тоо | • Баянгол дүүргийн Салбар комиссын нарийн бичгийн дарга 1 хүн<br>• Хөвсгөл аймгийн Салбар комиссын нарийн бичгийн дарга 1 хүн | Бүлэг 3<br>1-2 |
| | (Нэмэлт) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ. | • Туршилтын сургуулиуд дээр боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиуд дээр боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо | • Туршилтын 14 сургуулийн удирдах ажилтан: 14 хүн<br>• Баянгол дүүргийн туршилтын бус 13 сургуулийн удирдах ажилтан: 13 хүн<br>• Хөвсгөл аймгийн туршилтын бус 30 сургуулийн удирдах ажилтан: 30 хүн | Бүлэг 3<br>1-3 |

---

[6] Баянгол дүүрэгт байрлах төрийн өмчийн сургуулиудаас асуулгын хуудсыг бөглөсөн 13 сургууль (13, 20, 38, 40, 47, 51, 73, 93-р сургуулиуд, Эрдмийн Ундраа, Эрдмийн Өргөө, Оюуны Ундраа, Монгени цогцолбор сургуулиуд)

[7] Хөвсгөл аймаг дахь төрийн өмчийн сургуулиудаас асуулгын хуудсыг бөглөсөн 30 сургууль (Аваргууд, Авьяас YIII, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Бүрэнтогтох, Бүрэнхаан, Галт, Сод-Эрдэм, Дэлгэрмөрөн, Жаргалант, Зүрх, Их-Уул, Гурван-Эрдэнэ, Могой, Рашаант, Рэнчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Улаан-Уул, Ханх, Цагааннуур, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдмийн Далай, Эрдэнэбулган)

[8] Энэ нь 16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр үзүүлэх дэмжлэгийн төлөвлөгөөг боловсруулан зөвлөгөө өгөхийн зэрэгцээ тэтгэмж олгох шийдвэр гаргадаг хурал юм.

| Төслийн зорилго | Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл | Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо | Тус тайланд тэмдэглэсэн хэсэг |
|---|---|---|---|---|
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох. | Төслийн үйл ажиллагааны явцад боловсруулсан хэрэглэгдэхүүн нь (Заавар, журам, хөтөлбөр, удирдамж, хичээл г.м) БСШУСЯ болон ХНХЯ-аар батлагдана. | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |
| **Зорилт 1** | **Үзүүлэлт** | **Цуглуулсан мэдээлэл** | **Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо** | **Тус тайланд тэмдэглэсэн хэсэг** |
| Туршилтын аймаг, дүүрэг дэх холбогдох байгууллагуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийг хэрэгжүүлэх чадавх бэхжинэ. | 1. Үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирна. | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |
| | 2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс” буюу Комисс, Салбар комиссын чадавх бэхжинэ. | • Салбар комисст гүйцэтгэж буй ажил үүргийн талаарх ойлголт<br>• Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын хөгжлийн үнэлгээ хийх чадвар, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд болон Салбар комисс хоорондын уялдаа холбоо<br>• Туршилтын сургуулиуд, Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиудын | • Баянгол дүүргийн Салбар комисс: Суурь судалгаанд 7 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 7 хүн<br>• Хөвсгөл аймгийн Салбар комисс: Суурь судалгаанд 6 хүн、Эцсийн төлөв байдлын судалгаанд 7 хүн | Бүлэг 3<br>2-1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | удирдах ажилтны Салбар комиссын талаарх мэдлэг ойлголт, хамтын ажиллагаа | | |
| | (Нэмэлт) Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжинэ. | • ЭХЭМД ашиглах арга зүй<br>• Эрүүл мэндийн үзлэг хийдэг эсэх<br>• Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц | • Баянгол дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд: Суурь судалгаанд 26 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 26 хүн<br>• Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд: Суурь судалгаанд 28 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 23 хүн | Бүлэг 3<br>2-2 |
| | (Нэмэлт) Сэтгэл зүйч, эмч, багш, мэргэжилтнүүд болон Портеж эрт боловсролын хөтөлбөрийн багш нарын хөгжлийн үнэлгээ хийх чадавх бэхжинэ. | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |
| | (Нэмэлт) Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр болон Портеж эрт боловсролын хөтөлбөрийн багш нарын хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ. | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |
| Зорилт 2 | Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл | Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо | Тус тайланд тэмдэглэсэн хэсэг |
| Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын | 1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний боловсруулах гарын авлага боловсруулагдана.<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ. | хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө сайжирна.<br>3. Хөгжлийн үнэлгээний хэрэглэгдэхүүн шинэчлэгдэнэ.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сайн хичээл, сайн туршлагын эмхэтгэл боловсруулагдана. | | | |
| | (Нэмэлт) Туршилтын тусгай сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ. | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авах хандлага<br>• Багшлах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх байдал<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний харьцуулалт<br>• Хичээлийн харьцуулалт<br>• Ердийн сургуульд үзүүлж буй зөвлөн туслах үйл ажиллагаа | • Туршилтын тусгай сургуулиудын багш нар: Суурь судалгаанд 176 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 197 хүн | Бүлэг 3<br>3-1 |
| | (Нэмэлт) Туршилтын ердийн сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ. | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авах хандлага<br>• Багшлах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх байдал<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Тохируулгат орчноор хангах | • Баянгол дүүргийн туршилтын ердийн сургуулиудын багш нар: Суурь судалгаанд 552 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 532 хүн<br>• Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулиудын багш нар: Суурь судалгаанд 51 хүн, Эцсийн төлөв байдлын судалгаанд 106 хүн | Бүлэг 3<br>3-2 |
| Зорилт 3 | Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл | Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо | Тус тайланд тэмдэглэсэн хэсэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бичил төслөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн олон төрлийн боловсролын үйлчилгээний хэлбэр, загвар, түүний үр дүн батлагдана. | Бичил төслийн үнэлгээ | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |
| Зорилт 4 | Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл | Судалгаанд хамрагдсан хүмүүс, тоо | Тус тайланд тэмдэглэсэн хэсэг |
| Зорилт 1-3-ын холбогдох хүмүүсийн туршлагыг хуваалцан, үндэсний бодлого тогтолцоонд тусгасан байна. | 1. БМДИ-ийн үндсэн сургалтын чанар сайжирна.<br>2. Багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөр сайжирна.<br>3. Тусгай сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр сайжирна.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан аян хэрэгжинэ. | Эцсийн төлөв байдлын судалгаагаар тандахгүй. | - | - |

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ДАХЬ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

## 1. Эрхэм зорилго

| |
|---|
| Эрхэм зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэх. |

Эрхэм зорилгын "Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ" хэмээх шалгуур үзүүлэлтийн дагуу эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын сургуулиуд (Тусгай сургуулиуд, ердийн сургуулиуд) болон туршилтын бус сургуулиудад (Туршилтын аймаг, дүүрэг дэх төрийн өмчийн ердийн сургуулиудаас Баянгол дүүргийн 13 сургууль, Хөвсгөл аймгийн 30 сургууль асуулгын хуудас бөглөн, хариулт ирүүлсэн) суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог судлав.

Мөн "Хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авч чадаж байгаа" эсэхийг "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанд орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ" болон "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ" гэсэн 2 үзүүлэлтээр судалж үзэв. Үүнд: туршилтын сургуулиуд болон туршилтын аймаг, дүүрэг дэх сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, Салбар комиссын ээлжит хуралдаанаар хэлэлцсэн хүүхэд, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна. Харин туршилтын бус сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өсөөгүй байна. Эндээс "Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг хүртэх" гэсэн эрхэм зорилгод хүрэхийн тулд улам илүү дэмжлэг, оролцоо чухал байгаа нь харагдаж байна.

*Хүснэгт 3-1. Эрхэм зорилгын шалгуур үзүүлэлт болон цуглуулсан мэдээлэл*

| Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл |
|---|---|
| Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна. | • Туршилтын сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиудад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо |
| (Нэмэлт) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанаар | • Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанаар хэлэлцсэн хүүхдийн тоо |

| | |
|---|---|
| орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ. | |
| (Нэмэлт) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ.. | • Туршилтын сургуулиуд дээр боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиуд дээр боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо |

**1-1 Шалгуур үзүүлэлт: Сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна.**

Эрхэм зорилгыг хангахад чиглэсэн үйл явцыг хянах зорилгоор асуулгын хуудсаар дамжуулж туршилтын болон туршилтын бус нийт 57 сургуулийн тус бүр 1 удирдах ажилтнаас тухайн сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон мэдээллийг авсан. Эндээс төсөл хэрэгжиж эхэлснээс хойш туршилтын сургуулиуд дахь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хамрагдалт нэмэгдсэн бол туршилтын бус сургуулиудын хувьд нөхцөл байдал сайжраагүй байгаа нь тодорхой харагдаж байв.

Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнөх (Суурь судалгааг явуулсан үе) болон дараах үеийн (Эцсийн төлөв байдлын судалгаа явуулсан үе) туршилтын сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон үзүүлэлтийг График 3-1-д харьцуулан харуулав. Үүнээс харахад туршилтын тусгай сургуулиудад хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нийт 1136-аас 1283 (Ойролцоогоор 1.13 дахин), Нийслэл дэх туршилтын ердийн сургуулиудад 76-аас 100 (Ойролцоогоор 1.32 дахин), Хөвсгөл аймаг дахь туршилтын ердийн сургуулиудад 53-аас 62 (Ойролцоогоор 1.17 дахин) болж нэмэгдсэн байна.







*График 3-1 Туршилтын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо*

Төслөөс дэмжлэг оролцоо үзүүлсэн (Туршилтын сургууль) болон үзүүлээгүй сургуульд (Туршилтын бус сургуулиуд) хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн тоон харьцуулсан үзүүлэлтийг График 3-2-т харуулав. Төсөл хэрэгжсэн туршилтын сургуулиудад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өссөн (1265-аас 1445) бол туршилтын бус сургуулиудын тухайд буурсан (583-аас 477) үзүүлэлттэй байна.




*График 3-2 Туршилтын болон туршилтын бус сургуулиудад хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо*

**1-2 (Нэмэлт) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанаар орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хуралдаанаар орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн эсэхийг тогтоох зорилгоор Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссоор хэлэлцсэн хүүхдийн тоог үзэхэд төсөл хэрэгжиж эхлэснээс хойш ээлжит хуралдаанаар хэлэлцэж, зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссоор хэлэлцэж, шийдвэр гаргуулсан хүүхдийн тоо төслөөс дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (2015 он) болон хойших үед (2018 он) хэрхэн өөрчлөгдсөнийг График 3-3-т үзүүлэв. Үүнээс харахад төсөл хэрэгжиж эхэлснээс хойш эрс өссөн үзүүлэлттэй байна.




*График 3-3 Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссоор хэлэлцсэн хүүхдийн тоо*

2018 оны байдлаар хуралдаанаар хэлэлцсэн хүүхдийн тоо өссөн нь Салбар комиссын үйл ажиллагаа 2015 онтой харьцуулахад тогтмолжсонтой холбоотой хэмээн таамаглаж болох ба төслөөс зохион байгуулж ирсэн Салбар комиссыг чадавхжуулахад чиглэсэн үйл ажиллагаанууд нөлөөлсөн гэж үзэж байна.

**1-3 (Нэмэлт) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэнэ.**

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өссөн эсэхийг тандах зорилгоор туршилтын болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоог тодруулсан. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо эрс өссөн бол туршилтын бус сургуулиудад яльгүй өссөн үзүүлэлттэй байна.

Төсөл эхлэхээс өмнөх (Суурь судалгаа) болон төсөл хэрэгжиж эхлэснээс хойших (Эцсийн төлөв байдлын судалгаа) туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоог График 3-4-т харьцуулан үзүүлэв. Туршилтын тусгай болон ердийн сургуулиудын хоёуланд илт өссөн үзүүлэлттэй байна. Туршилтын тусгай сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэдэг хүүхдийн тоо 76-аас 321 (Ойролцоогоор 4.2 дахин), туршилтын ердийн сургуулиудын тухайд нийслэлд 1-ээс 27, Хөвсгөл аймагт 1-ээс 31 болж нэмэгдсэн байна.







*График 3-4. Туршилтын сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо*

Туршилтын болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоон үзүүлэлтийг харьцуулан График 3-5-д харуулав. Үүнээс үзэхэд туршилтын бус сургуулиудаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа нь Баянгол дүүрэгт 13-0, Хөвсгөл аймагт 30-10 сургууль байгаа ба тус 10 сургуулийн 4 нь төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад хамрагдсан сургууль юм.




*График 3-5 Туршилтын сургууль болон туршилтын бус сургуулиудад боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо*

Төслийн хүрээнд туршилтын тусгай сургуультай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, аргачлалыг боловсруулсан ба Боловсролын хүрээлэнгээр дамжуулан БСШУСЯ-д танилцуулсны үр дүнд 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Боловсролын сайдын А/155 тоот тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал” батлагдаж, ерөнхий

боловсролын бүх сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан ашиглах боломж бүрдсэн. Туршилтын тусгай сургуульд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах шийдвэр гарсан нь уг төлөвлөгөөгөөр хичээллэх хүүхдийн тоо өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна.

Туршилтын ердийн сургуулийн хувьд туршилтын тусгай сургуулиас үзүүлдэг зөвлөн туслах үйл ажиллагаа болон төслийн хүрээнд зохион байгуулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, судалгаат хичээл зохион байгуулах зэрэг ажлууд нөлөөлөх томоохон шалтгаан болсон гэж хэлж болно. Харин туршилтын бус сургуулиудад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хараахан нэвтрээгүй байгаа нь тогтоогдсон. Цаашид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний ашиглалтыг сайжруулах, өргөжүүлэхэд туршилтын сургуулиар зогсохгүй бүх сургуульд сайдын тушаалын талаар мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

## 2. Зорилт 1

| |
|---|
| Зорилт 1: Туршилтын аймаг, дүүрэг дэх холбогдох байгууллагуудын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийг хэрэгжүүлэх чадавх бэхжинэ. |

Зорилт 1 нь "Үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирна" болон "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс" буюу Комисс, Салбар комиссын чадавх бэхжинэ" гэсэн үзүүлэлтүүдтэй. "Холбогдох хүмүүсийн чадавх бэхжинэ" гэсэн зорилтот үр дүнгээс төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд зөвхөн Комисс болон Салбар комиссын чадавх бэхжинэ гэдэг үзүүлэлт тусгагдсан. Ингэхдээ Комисс, Салбар комиссыг хамруулсан нийт холбогдох байгууллагын бэхжүүлвэл зохих чадавхыг "Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх мэдлэг, чадвар", "Хөгжлийн үнэлгээ хийх мэдлэг, чадвар", "Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар" гэсэн 4 бүлэгт ангилсан ба эцсийн төлөв байдлын судалгаагаар Салбар комиссын "Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар" болон холбогдох эмч, мэргэжилтнүүдийн "Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх мэдлэг, чадвар" дээшилсэн эсэхийг тандсан. Комиссын хувьд Эцсийн төлөв байдлын судалгаа явуулах тухайн үед идэвхтэй ажиллаж байгаа нэг мэргэжилтэн байсан тул хувь хүний хариулт, мэдээллийг таниулахгүйн үүднээс асуумж, ярилцлага аваагүй болно.

*Хүснэгт 3-2. Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт, цуглуулсан мэдээлэл*

| Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл |
|---|---|
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс" буюу Комисс, Салбар комиссын чадавх бэхжинэ. | • Салбар комисст гүйцэтгэж буй ажил үүргийн талаарх ойлголт<br>• Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын хөгжлийн үнэлгээ хийх чадвар, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар<br>• Баянгол дүүрэг, Хөвсгөл аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд болон Салбар комисс хоорондын уялдаа холбоо<br>• Туршилтын сургуулиуд, Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиудын удирдах ажилтны Салбар комиссын талаарх мэдлэг ойлголт, хамтын ажиллагаа |
| (Санал) Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжинэ. | • ЭХЭМД ашиглах арга зүй<br>• Эрүүл мэндийн үзлэг хийдэг эсэх<br>• Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц |

**2-1 Шалгуур үзүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс" буюу Комисс, Салбар комиссын чадавх бэхжинэ.**

Эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнд, Салбар комиссын гишүүдийн ажил үүргийн тухай ойлголт, хөгжлийн бэрхшээлийн тухай ерөнхий мэдлэг ойлголт, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар сайжирсан байна. Мөн Салбар комисс, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд болон сургуулийн удирдах ажилтнуудын хамтын ажиллагаа сайжирсан байгаа нь Салбар комиссын талаарх мэдлэг, ойлголт дээшлэх шалтгаан болсон байна.

**1) Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт**

Суурь судалгааны үеэр буюу 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалд заасан Салбар комиссын үүрэг, болон Эцсийн төлөв байдлын судалгааны үеэр буюу 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Засгийн газрын 200 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-д заасан Салбар комиссын чиг үүргийн талаарх мэдлэг шалгах сорилыг Баянгол дүүрэг (Суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгаанд тус тус 7 хүн), Хөвсгөл аймгийн Салбар комиссын гишүүдээс (Суурь судалгаанд 6 хүн, эцсийн төлөв байдлын судалгаанд 7 хүн) авсан. Суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгааны сорилын

хариуг График 3-6-д харьцуулан үзүүлэв. Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын гишүүдийн гүйцэтгэлээс харахад Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт, мэдлэг сайжирсан байна. Харин Хөвсгөл аймгийн Салбар комиссын тухайд Комисс, Салбар комиссын үүргийг андуурч ойлгосон хариулт байсан тул гүйцэтгэл 70%-тай байв.




*График 3-6 Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт*
*(Суурь судалгаа N=13, Эцсийн төлөв байдлын судалгаа N=14)*

Салбар комиссын чиг үүргийн талаар хоёр Салбар комиссын гишүүд тайлбарлаж бичихдээ бусад холбогдох байгууллагуудтай хамтарч ажилладаг тухайгаа онцолж бичсэн байв. Энэ нь Салбар комиссын үүрэг болох "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх" талаар нилээд ойлголт, мэдлэгтэй болсныг илтгэж байна.

**2) Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа**

Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (Суурь судалгаа) болон төсөл хэрэгжиж эхэлснээс хойш (Эцсийн төлөв байдлын судалгаа) Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын хамтран ажиллаж байгаа байгууллагууд, хамтарч хийсэн ажлуудыг харьцуулан үзэхэд, Баянгол дүүргийн Салбар комиссын хувьд дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Дүүргийн Боловсролын хэлтэс, цэцэрлэг, тусгай сургууль, ердийн сургуулиуд уялдаа хамтын ажиллагаандаа сургуульд хамрагдалтыг дэмжих тухай тусгах болсон.
- Эцэг эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийг дэмжихийн тулд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй уялдаатай ажилладаг болсон.
- Зорилтот хүүхдийн бодит байдлыг судалж мэдэх, хөгжлийн үнэлгээ хийх, хэрэгцээнд нь нийцсэн хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулахдаа

хорооны нийгмийн ажилтантай уялдаатай ажилладаг болсон.

- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, ээлжит хуралдаан зохион байгуулахдаа өрхийн эмч нартайгаа уялдаатай ажилладаг болсон.

Хөвсгөл аймгийн хувьд ч "Аймгийнхаа Боловсрол, соёл, урлагийн газартай уялдаатай ажиллаж байна" гэсэн хариултын тоо өсөж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах сургуулийн шийдвэр болон хамруулсны дараа ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэх вэ гэдэг нь гол тулгамдсан асуудал гэж ойлгодог болсон нь харагдаж байна.

Дээрх ахиц, өөрчлөлт гарсан шалтгаан нь төслийн хүрээнд хэрэгжүүлсэн дараах үйл ажиллагаа, оролцоотой холбоотой гэж үзэж байна. Төслийн зүгээс дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй хүүхдийг сонгон хэлэлцэж, ДЭМБ-аас боловсруулсан Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалд (ICF) суурилсан үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг "Кэйс хэлэлцүүлэг"-ийг зохион байгуулан, Салбар комиссын цогц хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх бэхжүүлэхэд анхаарсан. Кэйс хэлэлцүүлэг зохион байгуулах, дэмжлэгийн дараах хяналтын үйл ажиллагаагаар холбогдох хүмүүстэй холбоотой байх шаардлагатай байдаг тул бусад байгууллагууд, салбар дундын уялдаа холбоо сайжирсан гэж үзэж байна.

*Хүснэгт 3-3 Бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн жишээ*

| |
|---|
| Кэйс хэлэлцүүлгээр дэмжлэг үзүүлсэн хүүхдүүдээс Баянгол дүүргийн гэр хороолold амьдардаг 7 настай хүүгийн жишээг танилцуулахад, гэр бүл нь Чингэлтэй дүүрэг рүү нүүсэн тул Баянгол дүүрэгт дэмжлэг авах боломжгүй болсон байсан учраас Чингэлтэй дүүргийн Салбар комиссд шилжүүлэн, дэмжлэг авах боломжийг бүрдүүлсэн. Түүний үр дүнд зорилтот хүүхэд Чингэлтэй дүүргийн ЕБС-д элсэж, дүү нь мөн тус дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдсан. Хяналтын үйл ажиллагаар дамжуулан ээж ажил эрхлэх боломжтой болсон тухай мэдсэн. |

### 3) Мэдлэг, ойлголт

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын гишүүдийн "Хөгжлийн бэрхшээл"-ийн талаарх мэдлэг, ойлголтын түвшинг илрүүлэх зорилгоор (суурь судалгаанд 13 хүн, эцсийн төлөв байдлын судалгаанд 14 хүн) "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, оролцоо", "Хүүхдийн хөгжил", "Хөгжлийн бэрхшээлийн ангилал", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө", "Багшлах арга зүй" гэсэн 6 үндсэн сэдвийн 22 асуулттай тест (Асуулт тус бүр 4 сонголттой) ашигласан. Суурь болон эцсийн төлөв байдлын судалгааны сорилын үнэн зөв хариулсан ерөнхий дунджийг (Хүчингүй хариултыг алдсанд тооцож, зөв

гүйцэтгэлийг дүгнэсэн) харьцуулсан үзүүлэлтийг Хүснэгт 3-7-д харуулав.

Эцсийн төлөв байдлын судалгаанд Баянгол дүүргийн салбар комиссын "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, оролцоо", "Хөгжлийн бэрхшээлийн ангилал", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө" сэдэвт сорилын гүйцэтгэлийн хувь нь суурь судалгааны үеийнхээс өндөр үзүүлэлттэй байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн шат дараалсан үйл ажиллагаануудаар дамжуулан Салбар комиссын суурь мэдлэг гүнзгийрсэн болох нь тогтоогдов.




*График 3-7 Мэдлэг, ойлголт (Суурь судалгаа N=13, Эцсийн төлөв байдлын судалгаа N=14)*

### 4) Салбар комиссын талаарх ойлголт, хамтын ажиллагаа

Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд, (Суурь судалгаа 54 хүн, эцсийн төлөв байдлын судалгаа 49 хүн), туршилтын болон туршилтын бус сургуулиудын удирдах ажилтнаас (Суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгааны аль алинд 57 хүн) Салбар комиссын талаарх ойлголтын түвшинг тогтоох зорилгоор Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагааны талаар тодруулсан. Суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгааны асуулгын хуудсанд тэмдэглэсэн хариултыг харьцуулан График 3-8-д үзүүлэв.

Суурь судалгаанд "Салбар комиссын тухай мэдэхгүй" гэж хариулсан 28 эмч, мэргэжилтэн байсан бол, эцсийн төлөв байдлын судалгаанд энэ үзүүлэлт 17 болж буурсан байна. Мөн ялгаагүй "Мэдэхгүй" гэж хариулсан сургуулийн удирдах ажилтны тоо 31-ээс 18 болж буурсан үзүүлэлттэй байна.




*График 3-8 Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагаа (Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд: Суурь судалгаа N=54, Эцсийн төлөв байдлын судалгаа N=49, Сургуулийн удирдах ажилтнууд: Суурь судалгаа, Эцсийн төлөв байдлын судалгаа N=57)*

**2-2 (Нэмэлт) Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжинэ.**

9 дүүргийн бүх хороонд ӨЭМТ, 21 аймгийн бүх сумдад СЭМТ ажилладаг бөгөөд тэдгээр нь Дүүргийн ЭМТ эсвэл аймгийн ЭМГ-т харьяалагддаг. Баянгол дүүргийн ЭМТ болон 23 хорооны ӨЭМТ, аймгийн ЭМГ болон СЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулан судалгаа явуулахад ажлын чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдсан үзүүлэлт өсөж, ЭХЭМД-ийн ашиглалт сайжран, 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг идэвхтэй зохион байгуулдаг болсон байна. Түүнчлэн салбар дундын уялдаа холбоо сайжирч, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлсний дараа тодорхой хөгжлийн дэмжлэгт холбон ажиллаж байгааг тодруууллаа.

**1) Ажлын чиг, үүргийн хүрээнд сургалтад хамрагдсан байдал**

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн ажил үүргийн хүрээнд сургалтад хамрагдсан байдлыг төсөл эхлэхийн өмнө (Суурь судалгаа) болон төсөл хэрэгжиж эхэлснээс хойш (Эцсийн төлөв байдлын судалгаа) хэрхэн өөрчлөгдсөнийг График 3-9-д харуулав. Эндээс төсөл хэрэгжиж эхлэснээс хойш эмч, мэргэжилтнүүдийн сургалтад илүү их

хамрагдах болсон нь харагдаж байна. Асуулгад хариулсан хүмүүсийн зарим нь төслийн хүрээнд зохион байгуулсан ЭХЭМД болон 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгтэй холбоотой сургалтуудад оролцсон ба энэ төрлийн сургалтууд нь эмч, мэргэжилтнүүдийн хувьд суралцах, мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж болсон гэж дүгнэж байна.




*График 3-9 Сургалтад хамрагдсан байдал (Баянгол дүүрэг: Суурь судалгаа N=26, Эцсийн төлөв байдлын судалгаа N=26, Хөвсгөл аймаг: Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

### 2) Байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймагт төсөл эхлэхээс өмнө (Суурь судалгаа) болон төсөл хэрэгжиж эхэлснээс хойш (Эцсийн төлөв байдлын судалгаа) эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд нь ямар байгууллагуудтай ямар зорилгоор хамтарч ажилласныг харьцуулан авч үзэв. Баянгол дүүрэг дэх эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд дараах ахиц, өөрчлөлт гарсан байгаа нь тогтоогдлоо.

- Суурь судалгаанд "Цэцэрлэгтэй уялдаатай ажилладаг" гэж хариулсан эрүүл мэндийн ажилтан зөвхөн 1 байсан бол энэ тоо эцсийн шатны судалгаагаар 10 болж өссөн.
- Суурь судалгаанд ердийн сургуультай уялдаатай ажилладаг эрүүл мэндийн ажилтан нэг ч гараагүй. Харин эцсийн шатны судалгаанд 8 хүн "Ердийн сургуультай уялдаатай ажилладаг" гэж хариулжээ.
- Уялдаа холбооны гол агуулга: 18 сартай хүүхэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг, Салбар комиссын ээлжит хуралдаан, Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр зэргээр төслийн хүрээнд шинээр нэвтрүүлсэн үйл ажиллагаануудыг дурдсан.

Суурь судалгаагаар Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн өгсөн хариултыг харьцуулж үзэхэд, эцсийн төлөв байдлын

судалгаагаар аймгийнхаа Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтарсан ажлын төлөвлөгөө боловсруулах, аймгийн БСУГ тай хамтарч сургалт зохион байгуулан ажилладаг болсон байна. Мөн цэцэрлэгүүдтэй уялдаатай ажиллах болж, хөгжлийн дэмжлэг болон цэцэрлэгт хамруулахад үзүүлэх дэмжлэгийг ердийн сургуультайгаа уялдуулан сургуульд хамрагдалтыг дэмжих, сургалтын орчин нөхцлийг бүрдүүлэх болсон. Эдгээр үр дүн нь төслийн хүрээнд Салбар комиссын ээлжит хуралдаанд дэмжлэг үзүүлэн, Кэйс хэлэлцүүлэг, Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг нэвтрүүлж, салбар дундын уялдаа холбоог сайжруулахад анхаарч ирсэнтэй холбоотой гэж үзэж байна. Үүний үр дүнд хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрсний дараа тодорхой хөгжлийн дэмжлэгт холбодог болох нь тогтоогдсон.

### 3) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

Эцсийн төлөв байдлын судалгаагаар ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулахад гол үүрэг гүйцэтгэх сургагч багш нараас (Баянгол дүүргээс 3 хүн, Хөвсгөл аймгаас 5 хүн) бүлгийн ярилцлага, асуумжаар судалгаа авсан. Энэ сургалтанд оролцсон эмч нар нь сургагч багш бэлтгэх сургалтын үеэр цаашид хийх ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг ярилцлагаар тодруулсныг доор дурдав.

- Үйл ажиллагааны график төлөвлөгөөнд тусгасан 7 үйл ажиллагаа (ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах, 18 сартай хүүхэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх зэрэг) бүгд хэрэгжсэн, эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн сургалтад хамрагдсаны дараа өөрийнхөө хэрхэн өөрчлөгдсөн талаар "Хамт ажилладаг хүмүүстээ зөвлөгөө өгч чадахуйц болсон" гэж дүгнэжээ.
- Харин Хөвсгөл сургагч багш нарын үйл ажиллагааны график төлөвлөгөөнд тусгасан 7 үйл ажиллагаа (ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах, 18 сартай хүүхэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх зэрэг) бүгд хэрэгжсэн, эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Мөн сургалтад хамрагдсаны дараа өөрийнхөө хэрхэн өөрчлөгдсөн тухай "Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх мэдлэгтэй болж, сургагч багш нар багаар ажилладаг болсон" гэж дүгнэсэн.

## 3. Зорилт 2

| |
|---|
| Зорилт 2: Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ. |

Зорилт 2 нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах гарын авлага боловсруулагдана", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө сайжирна", "Хөгжил үнэлгээний хэрэглэгдэхүүн сайжирна",

"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сайн хичээл, сайн туршлагын эмхэтгэл боловсруулагдана" гэсэн шалгуур үзүүлэлтүүдтэй. Үүний үр дүн нь "Туршилтын сургуулийн чадавхыг бэхжүүлэх" бөгөөд хэрэглэгдэхүүн боловсруулах замаар төсөлд холбогдох хүмүүсийн чадавхыг бэхжүүлнэ гэж төлөвлөн төслийн хүрэх үр дүнгийн хураангуйд хэрэглэгдэхүүн боловсруулах үзүүлэлтийг тусгасан. Энэ удаагийн эцсийн төлөв байдлын судалгаагаар туршилтын тусгай сургуулийн заавал сайжруулах шаардлагатай чадварыг "Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийх чадвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлж заах ур чадвар", "Тусгай сургуулийн зүгээс ердийн сургуульд дэмжлэг үзүүлэх чадвар", туршилтын ердийн сургуулийн бэхжүүлэх ёстой чадварыг "Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийх чадвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлж заах ур чадвар", "Ердийн сургуульд тохируулгат орчин бүрдүүлэх чадвар" гэж бүлэглэн чадавх бэхжсэн эсэхийг тодруулахыг зорьсон.

*Хүснэгт 3-4 Зорилт 2-ын Үзүүлэлт болон цуглуулсан мэдээлэл*

| Үзүүлэлт | Цуглуулсан мэдээлэл |
|---|---|
| (Нэмэлт) Туршилтын тусгай сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ. | • ХБХ-ийг хүлээж авч буй байдал<br>• Багшлах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх байдал<br>• Боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний харьцуулалт<br>• Хичээлийн харьцуулалт<br>• Ердийн сургуульд үзүүлэх дэмжлэг |
| (Нэмэлт) Туршилтын ердийн сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ. | • ХБХ-ийг хүлээж авч буй байдал<br>• Багшлах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх байдал<br>• Боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо<br>• Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт<br>• Тохируулгат орчноор хангах |

### 3-1 (Нэмэлт) Туршилтын тусгай сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ.

Туршилтын тусгай сургуулиудын багш нарын "Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийх чадвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлж заах ур чадвар", "Тусгай сургуулийн зүгээс ердийн сургуульд зөвлөн туслах чадвар"-ууд жигд сайжирсан болох нь тогтоогдсон.

#### 1) Хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийх чадвар

Туршилтын тусгай сургуулиудын багш нараас "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт", "Хүүхдийн хөгжил", "Хөгжлийн бэрхшээлийн ангилал", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө", "Багшлах арга зүй" гэсэн 6 үндсэн сэдвийн 22 асуулт бүхий сорил

авсан (Тус бүр 4 сонголттой). Суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгааны сорилын гүйцэтгэлийг График 3-10-т харьцуулан харуулав. Эцсийн төлөв байдлын судалгаагаагаар нийт хамрагдсан хүмүүс болон зөвхөн ажлын хэсгийн гишүүдийн хариултад дүн шинжилгээ хийсэн.

Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн (197 хүн) хариултаас харахад "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт", "Хүүхдийн хөгжил" гэсэн 3 сэдвээр авсан сорилын гүйцэтгэл, ажлын хэсгийн (36 хүн) "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-г хасаад 5 сэдвийн сорилын гүйцэтгэл нь суурь судалгаанаас өндөр үзүүлэлттэй гарсан ба багш нарын хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар дээшилсэн байгаа нь харагдаж байна.




*График 3-10 Туршилтын тусгай сургуулиудын багш нарын мэдлэг, ойлголт (Суурь судалгаа N=176, Эцсийн төлөв байдлын судалгаа : Нийт судалгаанд хамрагдсан N=197, ажлын хэсэг N=36)*

Төсөл эхлэхээс өмнө боловсруулж байсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон төслийн дэмжлэгтэйгээр шинэчлэгдсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн өөрчлөгдсөн тухай, хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадварт ямар ахиц гарсан талаар сургуулийн ажлын хэсэгтэй ярилцав. "Хүүхдийн бодит байдлыг үнэлдэг болсон", "Ар гэрийнхэнтэй нь ярилцдаг болсон" зэрэг хариултуудаас ажлын хэсгийнхэний хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадварт бодитой өөрчлөлт гарсан гэж дүгнэлээ.

*Хүснэгт 3-5 Ажлын хэсэгтэй хийсэн бүлгийн ярилцлагаар өгсөн санал, сэтгэгдлүүд*

| |
|---|
| • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бодит байдалд үнэлгээ хийн, хөгжил нь аль үе шатандаа байгаа болон дараагийн алхам руу шилжихэд нь хэрхэн дэмжлэг үзүүлж, зааж сургахад анхаарах талаар сайн боддог болсон. (63-р тусгай сургууль) |

- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн хүүхдийн бодит байдлыг тодорхойлж үнэлсэний үндсэн дээр ай тус бүрээр зорилтоо тодорхойлдог. Энэ ч утгаараа хүүхэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь нэгэн төрлийн хүүхэд хөгжүүлэх хэрэглэглэхүүн болсон гэж үзэж байгаа. Мөн бид гэр бүл, сургууль 2-ыг холбох харилцааны хэрэглэгдэхүүн болгон ашигладаг болсон. Эцэг эх, асран хамгаалагчаас хүүхдийн бодит байдлыг тодруулан асуудаг болж өмнө нь мэддэггүй байсан ар гэрийн байдлын талаар ойлголт мэдээлэлтэй болсон. (70-р тусгай сургууль)

Төсөл хэрэгжиж эхэлснээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар боловсруулагдаж, хүүхдийн бодит байдлыг дэлгэрэнгүйгээр тэмдэглэх хэсэгтэй болсон нь хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар бэхжихэд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

### 2) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар

Өмнө дурдсанчлан суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгаагаар тандсан туршилтын тусгай сургуульд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн хүүхдийн тоог харьцуулж үзвэл эцсийн төлөв байдлын судалгаа буюу төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 76-аас 321 (Ойролцоогоор 4.2 дахин) болж өссөн байна. Туршилтын тусгай сургуулиудын багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж эхэлсэн хугацааг График 3-11-д үзүүлэв. Төслөөс дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (2014/2015 оноос өмнө) 25-р тусгай сургуулийн багш нарын тэн хагас нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байсан. Харин бусад 3 тусгай сургуулийн хувьд “Боловсруулж үзээгүй”, “2014-2015 оны хичээлийн жилээс өмнө ч боловсруулж байсан” гэсэн хариултаас “Төслөөс дэмжлэг үзүүлж эхлэснээс хойш (2015-2016 оны хичээлийн жилээс хойш) боловсруулдаг болсон” гэж хариулсан багш нарын тоо харьцангүй олон байсан.




*График 3-11 Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах болсон хугацаа (N=197)*

Төслөөс дэмжлэг үзүүлэхээс өмнөх болон хожим шинэчилэн боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг харьцуулах замаар хувь хүний ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадварт хэрхэн ахиц, өөрчлөлт гарсан талаар сургуулийн ажлын хэсэгтэй ярилцсан. "Тодорхой урт хугацааны зорилт, богино хугацааны зорилт, заах агуулгаа төлөвлөж чаддаг болсон", "Багш нарын хамтын ажиллагаа сайжирч, өөр хоорондоо мэдээллээ хуваалцдаг болсон" зэрэг хариултууд нь ажлын хэсгийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадварт бодитой ахиц гарсан байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 3-6 Ажлын хэсэгтэй хийсэн бүлгийн ярилцлагаар өгсөн санал, сэтгэгдлүүд*

| |
|---|
| • Бусад хичээлийн багш нар ч ямар агуулгыг зааж, зорилтоо хэрхэн тодорхойлохоо ярилцаж, өөр хоорондоо мэдээллээ солилцдог болсон. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахын тулд хэд хэдэн багш нар баг болж ажиллах нь хүүхдийн ахиц, амжилтад ихээхэн нөлөөлдөг гэдгийг ойлгосон. (25-р тусгай сургууль)<br>• Шинэчилсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар нь зорилт, дэмжлэгийн агуулгыг хичээл тус бүр дээр бичих боломжтойгоор боловсруулагдсан. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн агуулга ч илүү тодорхой болж, ангийн бүх хүүхэд боловсролд тэгш хамрагдах боломжтой болсон. Өмнө нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хичээлд бусад хүүхдүүдээс тусдаа өөр зүйл хийж байсан бол ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулдаг болсноор хичээлийн үйл ажиллагаанд бусад хүүхдүүдийн хамт оролцох боломжтой болсон. (55-р тусгай сургууль) |

Туршилтын тусгай сургуулиудын багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадавх бэхжсэн нь төслийн арга зүйн дэмжлэгтэйгээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг боловсруулж, түүнийг боловсруулах дадлага ажлуудыг зохион байгуулж ирсний үр дүн гэж үзэж байна.

### 3) Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар

Эцсийн төлөв байдлын судалгаагаар төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнөх (2016 он) болон төсөл хэрэгжиж эхлэснээс хойших (2018 он) хичээлийн видеог 20 мин орчим үзүүлсэн ба ажлын хэсгийнхэн хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар хэрхэн өөрчлөгдсөн байгаа талаар харьцуулан ярив. Судалгаанд өгсөн хариултаас дүгнэхэд ажлын хэсэг хүүхдийн хэрэгцээнд тохируулан сургалт явуулж чаддаг болсон гэж үзэж байгаа нь тогтоогдлоо.

*Хүснэгт 3-7 Ажлын хэсэгтэй хийсэн бүлгийн ярилцлагаар өгсөн санал, сэтгэгдлүүд*

| |
|---|
| • 2016 оны хичээлийн тухайд, багш зөвхөн өөрийн зааж буй зүйлд анхаарлаа хандуулж, хичээл заалгаж байгаа хүүхдүүдийн хариу үйлдлийг бараг анзаарахгүй байсан. Хүүхдүүдийг |

| |
|---|
| цөөхөн магтаж сайшаасан төдийгүй, сургалтын олон арга хэлбэрүүд ажиглагдаагүй. 2018 оны хичээлд, бүх хүүхдийг хичээлд идэвхтэй оролцуулахад анхааран, туслах багшийн үүрэг, хүүхэдтэй ажиллах арга өөр болсон байв. Өмнө нь суудлын хуваарийг төдийлөн анхаардаггүй байсан бол, 2018 оны хичээлийн видеог харахад, багш нь хүүхдүүдийн хариу үйлдэл болон хариултыг хүлээдэг болжээ. Ийнхүү аажим аажмаар хүүхдийн хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлдэг болж байна гэхэд болно (63-р тусгай сургууль) <br>• 2018 онд ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулснаар хичээлийн агуулга, заах арга зүй илүү тодорхой, ойлгомжтой болж сайжирсан. (70-р тусгай сургууль) |

Төслөөр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг бодит сургалтад тусгаж хэрэгжүүлэх зорилгоор сургууль бүр дээр 3 удаа судалгаат хичээлийг зохион байгуулсан. Туршилтын тусгай сургууль хичээлийн сэдвээ (Жишээ нь бие эрхтний бэрхшээлтэй харилцааны чадвар сул хүүхдэд зориулсан заах арга барил) сонгож, төслийн баг хэрхэн бодит байдлын судалгаа хийх, хүүхдийн онцлогт тохируулан дэмжлэг, заах арга зүйгээ сонгон тохируулах талаар сургалт явуулсны дараа ажлын хэсэг ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, судалгаат хичээлийг зохион байгуулсан. 55, 63, 70-р тусгай сургуулиуд бүлгийн ярилцлагадаа судалгаат хичээлээр боловсруулсан ээлжит хичээлийн хөтөлбөрийн тухай онцолж байсан ба тус үйл ажиллагаагаар дамжуулан туршилтын тусгай сургуулиудын багш нарын хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар бэхжсэн гэж үзэж байна.

### 4) Ердийн сургуульд дэмжлэг үзүүлэх чадвар

Тусгай сургууль болон ердийн сургуулийн уялдаа холбоог сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах боломжийг ердийн сургуулиар тэлэх зорилгын хүрээнд төсөл туршилтын тусгай сургууль бүрийг туршилтын 2 ердийн сургуулиудтай тус тус хамтран ажиллахаар зохицуулж, тусгай сургуулиудын багш нараас ердийн сургуулиудын багш нарт үзүүлэх зөвлөн туслах үйл ажиллагааг дэмжин ажилласан. Зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан ажлын хэсгийн гишүүдээс уг ажлын талаар тодруулахад ердийн сургуулийн багш нарыг чадавхжуулж, зөв ойлголттой болоход нь нөлөөлж чадсан гэж үзэж байгаа нь харагдлаа.

*Хүснэгт 3-8 Ажлын хэсэгтэй хийсэн бүлгийн ярилцлагаар өгсөн санал, сэтгэгдлүүд*

| |
|---|
| Туршилтын ердийн сургуулиудад эцэг эхчүүдэ зориулсан сургалтуудыг зохион байгуулахад эцэг эх, асран хамгаалагч нар сургалтын материал, хэрэглэгдэхүүнд анхаарлаа хандуулж байсан. Өөрийн мэргэжлийнхээ дагуу яриа хийж, мэдээлэл өгч чадсандаа баяртай байгаа. Багш нар ч их өөрчлөгдсөн. Зөвлөн туслах үйл ажиллагаагаа нь өөрийн туршлагаа эргэж харах, давхар өөрөө суралцах боломж олгосон. (55-р тусгай сургууль) |

**3-2 (Нэмэлт) Туршилтын ердийн сургуулиудын багш нарын чадавх бэхжинэ.**

Судалгаагаар туршилтын ердийн сургуулиудын багш нарын "Хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар", "Тохируулгат орчноор хангах чадвар"-ууд жигд дээшилсэн болохыг тогтоов. Харин багш нарын хувьд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт, багшлах идэвх санаачлага, өөртөө итгэх байдал нь харилцан адилгүй байна. Цаашид илүү олон багш нарыг хамруулан чадавхжуулах шаардлагатай байна.

**1) Хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар**

Туршилтын ердийн сургуулиудын багш нарыг ойлголт, мэдлэгийн түвшинг (Суурь судалгаанд 603 хүн, эцсийн төлөв байдлын судалгаа 632 хүн) "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт", "Хүүхдийн хөгжил", "Хөгжлийн бэрхшээлийн ангилал", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө", "Багшлах арга зүй" гэсэн 6 үндсэн сэдвийн 22 асуулттай тестээр (Тус бүр 4 сонголтоос зөв хариултыг сонгох асуулттай) шалгасан. Суурь болон Эцсийн төлөв байдлын судалгааны тестийн гүйцэтгэлийг (Хүчингүй хариултыг алдсанд тооцож, зөв гүйцэтгэлийг дүгнэсэн) График 3-12-т харьцуулан үзүүлэв.

"Багшлах арга зүй"-г хасаад "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Хүүхдийн хөгжил", "Хөгжлийн бэрхшээлийн ангилал" сэдвийн тестийн гүйцэтгэл суурь судалгаанаас өндөр үзүүлэлттэй гарсан бөгөөд ердийн сургуулийн багш нарын хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар дээшилсэн байгаа нь тодорхой харагдаж байна.




*График 3-12 Туршилтын ердийн сургуулиудын багш нарын мэдлэг, ойлголт*

*(Суурь судалгаа N=603, Эцсийн төлөв байдлын судалгаа N=638)*

## 2) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар

График 3-4-т үзүүлсэнчлэн суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнг харьцуулан авч үзвэл туршилтын ердийн сургуульд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн тоо Нийслэлд 1-ээс 27, Хөвсгөл аймагт 1-ээс 31 болж өссөн байна. Туршилтын ердийн сургуулийн багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж эхэлсэн хугацааг График 3-13-т харуулсан ба төсөл хэрэгжиж эхлэснээс хойш (2015-2017 оны хичээлийн жилээс хойш) боловсруулж ажиллаж байгаа гэж хариулсан багш нарын тоо 73-д хүрсэн байна.




*График 3-13 Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж эхэлсэн хугацаа (N=638)*

Ердийн сургуулийн бүх ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байгаа гэвэл өрөөсгөл ойлголт болно. Төслийн хүрээнд сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тулж ажилладаг багш нарт зориулж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах болон хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж ирсэн бөгөөд эдгээр дэмжлэг, оролцоо нь багш нарын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадварыг дээшлүүлэхэд нөлөөлсөн гэж үзэж байна.

Гэхдээ асуулгын хуудсаар хариулсан хүний 70-аас дээш хувь нь “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж үзээгүй” гэж хариулсан. Цаашид нийт сургуулийн хэмжээнд тэгш хамруулан сургах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор эдгээр багш нарт чиглэсэн сургалтуудыг зохион байгуулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах боломжийг бүрдүүлэн тогтмол чадавхжуулах шаардлагатай байна.

## 3) Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар

Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (2014-2015 оны хичээлийн жилээс өмнө) болон төсөл хэрэгжиж эхлэснээс хойш (Одоо үе) хүүхэд бүрийн хэрэгцээнд

нийцүүлэн заах ур чадвар хэрхэн өөрчлөгдсөнийг тандах зорилготой "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхолтой эсэх", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа итгэлтэй байгаа эсэх" гэсэн асуултад туршилтын ердийн сургуулийн 638 багш нарын өгсөн хариултыг График 3-14, 3-15-д харьцуулан харуулав. Эцсийн төлөв байдлын судалгаанд "Бага зэрэг ажиллаж үзмээр байна", "Маш их ажиллаж үзмээр байна", "Бага зэрэг итгэлтэй байна", "Итгэлтэй байна", Маш их итгэлтэй байна" гэж хариулсан багш нарын тоо өмнөх суурь судалгааны үеийнхээс харьцангуй өссөн байна. Эсрэгээр "Ажилламааргүй байна", "Итгэлгүй байна" гэж хариулсан багш нарын тоо төсөл хэрэгжиж эхэлснээс хойш даруй 2 дахин буурч төслөөс үзүүлсэн дэмжлэг илэрхий үр дүнтэй байгааг харуулж байна.

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн сургалт болон бусад үйл ажиллагаа, дэмжлэгийн нөлөөгөөр туршилтын ердийн сургуулиудын багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах идэвх санаачлага, өөртөө итгэх итгэл нэмэгдсэн болох нь тогтоогдлоо.




*График 3-14 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхолтой эсэх (N=638)*




*График 3-15 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах итгэлтэй байгаа эсэх (N=638)*

### 4) Тохируулгат орчноор хангах чадвар

Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө (2014-2015 оны хичээлийн жилээс өмнө) болон төсөл хэрэгжиж эхэлснээс хойш (Одоо үе) туршилтын ердийн сургуулийн тохируулгат орчин бүрдүүлэх чадварт ахиц өөрчлөлт гарсан эсэхийг тандах зорилгоор туршилтын ердийн сургуулиудын 638 багш нараас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авахад бэлэн эсэхийг тодруулж, асуумжийн хариултыг График 3-16-д харьцуулан үзүүлэв.

Тус судалгаанд (Одоо үе) нь “Бага зэрэг ”, “Бэлтгэл хангагдсан”, “Маш сайн бэлтгэл хангагдсан” гэж хариулсан багш нарын тоо суурь судалгааны үеийнхээс өссөн байна.




*График 3-16 Сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээж авах бэлтгэл хангасан байдал (N=638)*

Дээрхтэй адил зорилгоор төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө болон хойш туршилтын ердийн сургуулийн ажлын хэсгийн тохируулгат орчноор хангах чадварт ямар өөрчлөлт гарсан талаар ярилцахад аль ч сургуулийн хувьд ихэнх багш нар төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтууд, Япон дахь сургалтаар дамжуулан тохируулгат орчны тухай ойлголттой болж, үүний ач холбогдлыг бодитоор мэдэрч байгаа учраас цаашид ч энэ тал дээр анхаарч үргэлжлүүлэн ажиллана гэж хариулсан байна.

*Хүснэгт 3-9 Ажлын хэсэгтэй хийсэн бүлгийн ярилцлагаар өгсөн санал, сэтгэгдлүүд*

| |
|---|
| • Бүх багш нар хүүхдүүдийнхээ ойлголтын түвшинд нийцүүлэн сургалтын агуулгаа өөрчилдөг. Зурган карт, бодит зүйл ч ашигладаг. Өдөр болгоны хичээлийн хуваарийг хүүхдэд ойлгомжтой болгохын тулд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зураг ашигладаг. “Хүүхдэд өгөх заавраа ойлгомжтой болгох” гэдгийг бүх багш нар ойлгож байгаа. (28-р сургууль) |

- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдэд хичээлийн агуулгыг тохируулан өөрчилж байгаа. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллээгүй хүүхдэд ч ялангуяа бага ангийн сурагчдад цагийн хуваарийг зураг ашиглан ойлгомжтойгоор үзүүлэх зэргээр санаачлан ажиллаж байна. Анги даасан багш нарт хэрэглэгдэхүүн болгон ашиглах зураг тарааж өгсөн. (79-р сургууль)
- Сар бүр зохион байгуулдаг эцэг эхийн хурал дээр анги даасан багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар тайлбарлаж ойлгуулдаг. Хүүхдүүдийг ч энэ талын зөв ойлголттой болгох нь анги даасан багшийн үүрэг юм. (79-р сургууль)
- Тохируулгат орчин бүрдүүлэхийн ач холбогдолыг ойлгодог болсон учир тасралтгүй хэрэгжүүлж байна. Хүүхэд, сурагчдад төдийгүй, багш нарт ч амар болсон. (111-р сургууль)

Төслийн хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн туршилтын ердийн сургуульд тохируулгат орчин бий болгох төлөвлөгөө боловсруулж байгаа ба энэ нь тохируулгат орчноор хангах чадавх бэхжихэд мэдэгдэхүйц нөлөөлсөн гэж үзэж байна.

## БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

Энэхүү эцсийн төлөв байдлын судалгааг 2015 оны 08 дугаар сараас эхлэн 4 жилийн хугацаанд хэрэгжсэн "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн үр дүнг үнэлэхийн сацуу цаашид төслөөс гарсан үр дүнг тогтвортой хэрэгжүүлэхэд ашиглах гарын авлага болгох зорилгоор зохион байгуулав. Энэ бүлэгт эцсийн төлөв байдлын судалгаагаар Эрхэм зорилго, Зорилт 1, Зорилт 2-ын хэрэгжилтийг дүгнэхийн зэрэцээ цаашид анхаарвал зохих асуудлыг хөндөнө.

### 4-1 Эрхэм зорилго

"Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг авдаг болох" Эрхэм зорилгын "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт дээшилсэн байна" гэсэн шалгуур үзүүлэлт нь туршилтын тусгай болон ердийн сургуулиудад нэмэгдсэн боловч, туршилтын аймаг, дүүргийн туршилтын бус сургуульд бага зэрэг буурсан.

"Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлдэг болсон уу" гэсэн асуултын хариу болт болгож, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын ээлжит хурлаар орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн" тухайд, зөвхөн туршилтын БГД, Хөвсгөл аймгийн Салбар комисс дээр авч үзвэл аль аль нь нилээд нэмэгдсэн.

"ГСТ боловсруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн" тухайд, туршилтын тусгай болон ердийн сургуульд огцом нэмэгдсэн боловч, туршилтын аймаг, дүүрэг дэх туршилтын бус сургуульд бага зэрэг л нэмэгдсэн.

Дээрх мэдээллээс харахад туршилтын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамруулсан байдал, үзүүлж буй боловсролын үйлчилгээ сайжирсан боловч нөгөөтэйгүүр туршилтын бус сургуулийн хамруулалт, боловсролын үйлчилгээнд БМДИ болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн зөвлөгөө өгөх дэмжлэг, оролцоо түлхүү шаардлагатай байгаа нь харагдаж байна. БСШУС-ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ний А/155 дугаар тушаалаар баталсан "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар болон түүнийг боловсруулах аргачлал" болон БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 14-ний А/292 дугаар тушаалаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам" зэрэг нь төслийн үр дүн, тогтолцоонд тусгагдсан. Гэвч эдгээр тушаалуудын агуулгын талаарх мэдээлэл ойлголт, туршилтын бус сургуулиудад

хангалтгүй байгаа тул энэ байдалд дүгнэлт хийн үр дүн нь батлагдсан эдгээр үйл ажиллагааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх шаардлагатай юм.

**4-2 Зорилт 1**

**1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комисс**

"Туршилтын аймаг, дүүрэгт холбогдох байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжинэ." гэсэн Зорилт 1-ийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс болон Салбар комиссын чадавх бэхжинэ." гэсэн шалгуур үзүүлэлтийн хувьд, БГД болон Хөвсгөл аймгийн Салбар комисс ямар чиг үүрэг гүйцэтгэх ёстойгоо ойлгосон, суурь мэдлэг, ойлголтоо дээшлүүлсэн, ялангуяа "Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах ур чадвар" нь дээшилсэн. Харин Комиссын тухайд эцсийн төлөв байдлын судалгааны үед зөвхөн 1 гишүүн ажиллаж байсан учир хувь хүний хариулт, мэдээллийг таниулахгүйн үүднээс асуумж болон ярилцлага аваагүй болно.

Төслийн багийн туршилтын аймаг, дүүрэгт кэйс хэлэлцүүлэг зохион байгуулсан явдал нь Салбар комиссын чадавхийг бэхжүүэхэд хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Цаашдаа ч кэйс хэлэлцүүлгийг тогтвортой зохион байгуулах шаардлагатай. Одоогоор уг хэлэцүүлэг Салбар комиссын ажил үүргийн тодорхойлолтод тусгагдаагүй бөгөөд гишүүдэд урамшуулал олгох үйл ажиллагаанд тооцогдохгүй байгаа. Цаашид, төслийн хүрээнд нэвтрүүлсэн үйл ажиллагааг хэвшүүлэхийн тулд ийм хэлэлцүүлэг зохион байгуулж байхыг Салбар комиссын чиг үүрэгт тусгах шаардлага харагдаж байна

**2) Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд**

Дээр дурдсан зорилтын хүрээнд "Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжинэ" гэсэн шалгуур үзүүлэлтэд тандалт хийхэд эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн ажил үүрэгтэй холбоотой мэдлэг туршлага нь дээшилж, ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах, 18 сартай хүүхэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт идэвхтэй оролцож байгаа нь харагдсан. Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх ур чадвар дээшилсэн, түүнчлэн бусад байгууллагуудтайгаа уялдаатай ажиллаж хөгжлийн дэмжлэгт холбож байна.

ӨЭМТ-ийн эмч нар 2, 3 жил ажиллаад өөр тийшээ шилждэг байдал түгээмэл байгаа зэргээс шалтгаалан, ЭХЭМД-ийн ашиглалт, 18 сартай хүүхдийн эрүүл мэнд,

хөгжлийн цогц үзлэг, эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн зөвлөгөөний талаар тогтмол сургалт зохион байгуулж байх шаардлага харагдаж байна. ЭХЭМД-ийн ашиглалт болон 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулах тухай 2017 оны 12 дугаар сарын Засгийн газрын 321 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийн дэмжих үндэсний хөтөлбөр"-т заасан. Төслөөс боловсруулсан "ЭХЭМД ашиглах гарын авлага", "ЭХЭМД ашиглалтын сургагч багш бэлтгэх сургалтын модул", "18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх гарын авлага (Үзлэгийн маягттай)"-ыг ЭМЯ дэмжсэн бөгөөд цаашид үндэсний хэмжээнд ашиглаглах боломжтой гэдэгт итгэлтэй байна.

**4-3 Зорилт 2**

"Туршилтын сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өндөр чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ" гэсэн зорилтын хэрэгжилтийн явцыг үнэлэх зорилгоор туршилтын сургуулийн бэхжүүлвэл зохих чадварыг "Хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар", "Хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар", "Тусгай сургуулиас ердийн сургуульд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чадвар, "Ердийн сургуульд тохируулгат орчноор хангах чадвар" гэсэн 5 бүлэгт ангилан авч үзэв.

**1) Туршилтын тусгай сургууль**

Туршилтын тусгай сургуульд төсөл эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах тогтолцоо бүрдсэн ба багш нар ч идэвх санаачлагатай хичээлээ заадаг болсон. Төсөл дэмжлэг үзүүлснээр хичээлийн хэрэглэгдэхүүн, заах арга зүй сайжирч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл заахдаа итгэлтэй болсон нь харагдсан. "Хөгжлийн бэрхшээл"-ийн талаарх ажлын хэсгийнхний мэдлэг, ойлголт ч дээшилсэн байна. Хүүхдийн бодит байдлыг үнэлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах, ердийн сургуульд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх чадварууд эрс сайжирсан байна. Багш нар өөрсдөө ч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах болон хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн хичээл зохион байгуулах, ердийн сургуульд дэмжлэг үзүүлэхийн ач холбогдолыг ойлгодог болсон.

Цаашид төслийн хүрээнд нэвтрүүлсэн үйл ажиллагааг хэвшүүлэхийн тулд, туршилтын тусгай сургуулийн багш нар нөөц сургагчийн үүрэг гүйцэтгэн ердийн сургуульд чиглэсэн сургалтад сургагч багшаар ажиллах зэргээр Нийслэлийн ердийн сургуулиуд болон аймгуудын төвийн сургуулиудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тогтолцоог бий болгох нь зүйтэй.

**2) Туршилтын ердийн сургууль**

Судалгаанаас үзэхэд төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдсээр байна. Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах буюу тохируулгат орчин бүрдүүлэх ур чадвар нь ч дээшилж байна. Багш нар өөрсдөө ч тохируулгат орчин бүрдүүлэхийн ач холбогдолыг сайн ойлгодог болсон.

Гэвч "Хөгжлийн бэрхшээл"-ийн тухай мэдлэг ойлголт болон арга зүйгээ сайжруулах идэвх чармайлт, өөртөө итгэх итгэлийн тал дээр сургуулиуд харилцан адилгүй байгаагийн зэрэгцээ, багш нарт ч ялгаатай байдал харагдаж байна. Багшлах арга зүйдээ итгэлгүй байна гэж хариулсан багш нар, итгэлтэй байж чадахгүй байгаа шалтгаанаа "Сургалтад сууж байгаагүй учраас багшлах арга зүй, хүүхэдтэй ажиллах аргаа сайн мэддэггүй", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл зааж байгаагүй" зэргээр тайлбарласан.

Цаашид төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд ердийн сургуульд сургалт, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх нөөц боловсон хүчин шаардлагатай тул дээр дурдсанчлан Нийслэлд туршилтын тусгай сургуулиуд лавлагаа төвийн үүргийг гүйцэтгэнэ гэдэг хүлээлттэй байна. Харин хөдөө, орон нутгийн хувьд БСШУСЯ нь одоогоор аймаг тус бүрт 3 сургуулийг "Түшиц сургууль" байхаар бэлдэж, аймгийн бусад сургуулиуддаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдтэй ажиллах мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоог бий болгохоор төлөвлөж байна. Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.

Түүнчлэн нийт сургуулийн хэмжээнд тэгш хамруулан сургах тогтолцоог бүрдүүлэхэд дорвитой анхаарал хандуулах шаардлагатай байна. Төслийн хүрээнд туршилтын ердийн сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх шаардлагатай дэмжлэгийг багш нар төлөвлөх зорилго бүхий "Сургуулийн дэмжлэгийн баг" гэдэг бүтцийг нэвтрүүлсэн. Энэхүү бүтцийг 2019 оны 05 дугаар сарын 14 өдрийн БСШУС-ын сайдын А/292 дугаар тушаалд бүх ЕБС-д байгуулан ажиллахыг заасан бөгөөд энэ ажил амжилттай хэрэгжиж, тогтвортой үргэлжилнэ гэдэгт итгэж байна.

Ийнхүү эцсийн төлөв байдлын судалгааны ерөнхий зорилгын хүрээнд зорилтот 4 бүлгийн судалгааны үр дүнд суурилсан үндсэн асуудлыг тэмдэглэж тус тайланг боловсруулав. Харин уг судалгааны нэгдсэн мэдээлэл дээр тулгуурлан хийсэн төслийн үнэлгээг Хавсралт "Үйл ажиллагааны эцсийн тайлан"-д тэмдэглэсэн тул энэхүү тайлан нь цуглуулсан мэдээлэл болон түүний дүн шинжилгээний үр дүнг нэгтгэсэн тайлан болно.

# ХАВСРАЛТ

## СУДАЛГААНЫ ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД ДЭЭР ХИЙСЭН ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИСС

Энэ бүлэгт Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн Салбар комиссыг хамруулан 2016 оны 03 дугаар сараас 04 дүгээр сар (Баянгол дүүрэг), 2017 оны 01 дүгээр сард (Хөвсгөл аймаг) тус тус зохион байгуулсан суурь судалгаа үр дүн болон 2018 оны 10 дугаар сард явуулсан эцсийн төлөв байдлын судалгаа үр дүнг харьцуулан авч үзнэ. Харьцуулсан үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 1-1 Харьцуулах үзүүлэлтүүд*

| Үндсэн үзүүлэлт | Дэд үзүүлэлт | Аргачлал |
|---|---|---|
| Ерөнхий мэдээлэл | • Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт<br>• Ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал | Асуулгын хуудас |
| Ажлын туршлага | • Ажилласан хүүхдийн тоо<br>• Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Комиссын талаарх ойлголт, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүний тоо | Асуулгын хуудас |
| Чадвар | • Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт | Асуулгын хуудас |
| | • Хөгжлийн үнэлгээ<br>• Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах<br>• Хөгжлийн дэмжлэг үзүүлэх | Бүлгийн ярилцлага |

## 1. Ерөнхий мэдээлэл

### 1-1 Судалгааны зорилтот бүлэг

Судалгаанд хамрагдсан Салбар комиссын гишүүдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулав. Хүснэгтээс Баянгол дүүрэгт төсөл хэрэгжих хугацаанд 3 гишүүн, Хөвсгөл аймагт 1 гишүүн солигдсон болохыг харж болно.

*Хүснэгт 1-2 Баянгол дүүргийн Салбар комисс*

| Харьяалагдах байгууллага (Салбар комисст гүйцэтгэх үүрэг) | Суурь судалгаанд хамрагдсан эсэх | Эцсийн төлөв байдлын судалгаанд хамрагдсан эсэх |
|---|---|---|
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, хэлтсийн дарга (Салбар комиссын дарга) | ✓ | ✓ |
| Дүүргийн Нийгмийн хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэс, мэргэжилтэн (Нарийн бичгийн дарга) | ✓ | ✓ |
| 70 дугаар тусгай сургууль, хэл засалч (Согог зүйч) | ✓ | ✓ |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, мэргэжилтэн | ✓ | |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, мэргэжилтэн | | ✓ |
| ДЭМТ, сэтгэл зүйч | ✓ | |
| ДЭМТ, мэдрэлийн эмч | | ✓ |

| | | |
|---|---|---|
| 113 дугаар сургууль, багш | ✓ | |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, ахлах мэргэжилтэн | | ✓ |
| ДЭМТ, хүүхдийн эмч | ✓ | ✓ |

*Хүснэгт 1-3 Хөвсгөл аймгийн Салбар комисс*

| Харьяалагдах байгууллага (Салбар комисст гүйцэтгэх үүрэг) | Суурь судалгаанд хамрагдсан эсэх | Эцсийн төлөв байдлын судалгаанд хамрагдсан эсэх |
|---|---|---|
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, хэлтсийн дарга (Салбар комиссын дарга) | ✓ | ✓ |
| Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, мэргэжилтэн (Нарийн бичгийн дарга) | ✓ | ✓ |
| Аймгийн БСУГ, Насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн | ✓ | ✓ |
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн | ✓ | |
| Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс, хүүхэд хамгааллын мэргэжилтэн | | ✓ |
| Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүртгэл мэдээллийн тасаг, Тасгийн дарга (Эмч) | ✓ | ✓ |
| Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн (Эмч) | ✓ | ✓ |
| "Өвгөд" төв ТББ, багш | * | ✓ |

*Суурь судалгааны үеэр байхгүй байсан тул мэдээлэл авах боломжгүй байсан.

## 1-2 Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт

Судалгааны эхэнд Салбар комиссын талаарх ойлголтыг тандах зорилгоор суурь судалгаанд 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан ХАХНХ-ын сайд, БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаалд заасан Салбар комиссын үүргийг, эцсийн төлөв байдлын судалгаанд 2016 оны 12 дугар сарын 21-ний өдөр баталсан засгийн газрын 200 дугаар тушаал "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын дүрэм"-д заасан Салбар комиссын үүргийг олон хувилбараас зөвийг сонгох тестийн аргаар шалгасан. Тус бүрийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 1-4 Салбар комиссын чиг үүргийн талаарх тестийн гүйцэтгэл*

*(Суурь судалгаа N=13, Эцсийн төлөв байдлын судалгаа N=14)*

| | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|---|
| Баянгол дүүргийн Салбар комисс | 69.4% | 93.9% |
| Хөвсгөл аймгийн Салбар комисс | 64.8% | 79.6% |

Нийт гишүүдийн Салбар комиссын талаарх тайлбарлаж тэмдэглэсэн хариултыг Хүснэгт 1-5, 1-6-д нэгтгэн үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд ялангуяа Баянгол дүүргийн Салбар комиссын гишүүд Салбар комиссын үүргийг суурь судалгааны үеийнхээс

илүү тодорхой бичсэн байна. Түүнчлэн бусад байгууллагуудтай хамтарч ажилласан тухай дурдсан гишүүдийн тоо өссөн байна. Эцсийн төлөв байдлын судалгааны эдгээр үзүүлэлтүүдээс харахад Салбар комиссын үүрэг нь хүүхдүүдэд цогц дэмжлэг үзүүлэх гэдгийг аль аль Салбар комиссын гишүүд суурь судалгааны үеийнхээс илүү сайн ойлгодог болсон нь мэдэгдэж байна.

1-3 Ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал

Салбар комиссын гишүүдийн ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдлыг Хүснэгт 1-5, 1-6-д үзүүлэв. Хөвсгөл аймгийн Салбар комиссын гишүүдийн ихэнх нь суурь судалгаанд "Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт"-д хамрагдсан гэж хариулж байсан бол эцсийн төлөв байдлын судалгаанд "Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт"-д хамрагдсан гэсэн хариулт өссөн байв. Төсөл хэрэгжиж, дэмжлэг үзүүлсэн нь ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдаж, мэдлэг арга зүйгээ дээшлүүлэх томоохон боломж болсон гэж үзэж байна.

*Хүснэгт 1-5 Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт, ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал*

*(Баянгол дүүрэг)*

| Албан тушаал (Хариуцаж буй ажил) | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Салбар комисст гүйцэтгэж буй үүрэг | Энэ чиглэлээр сургалтад хамрагдсан байдал | Салбар комисст гүйцэтгэж буй үүрэг | Энэ чиглэлээр сургалтад хамрагдсан байдал |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга (Салбар комиссын дарга) | Бүх талын үүргийг хүлээнэ. | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт | Салбар комиссын гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх болон хяналт удирдлагаар хангадаг. Баянгол дүүрэгтээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлдэг. | • Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт<br>• Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |
| Дүүргийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн (Нарийн бичгийн дарга) | Нийгмийн хамгааллын хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлнэ. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Бүртгэл, мэдээлэл хариуцах, тайлан боловсруулах, Салбар комиссын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, ерөнхий болон тусгай үйл ажиллагаа зохион байгуулдаг. | Энэ чиглэлээр их сургуульд боловсрол эзэмшсэн. |
| 70 дугаар тусгай сургуулийн хэл засалч, согог зүйч | Багшлах арга зүйн талаар судалгаа шинжилгээ хийж, боловсролын үйлчилгээ үзүүлнэ. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Боловсролын үнэлгээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахтай холбоотойгоор байгууллагуудтай хамтарч ажилладаг. Багшлах арга зүйг сайжруулах зорилгоор зөвлөн туслах үйл ажиллагаа явуулдаг. | • Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт<br>• Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн | Бүх талын шаардлагатай үйл ажиллагаа явуулна. | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт | | |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдын адил | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нийгмийн амьдралд тэгш оролцож, боловсролыг үйлчилгээнд тэгш хамрагдах эрхийг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. | |
| ДЭМТ-ийн сэтгэл зүйч | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө. Мөн тэднийг оролцоог сайжруулж, дэмжлэгийн багийг байгуулна. | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт | | |
| ДЭМТ-ийн мэдрэлийн эмч | | | Эрүүл мэндийн боловсрол олгох, хамтран ажиллах,зөвлөгөө өгөх, багшлах арга зүйг дээшлүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлдэг. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт |
| 113 дугаар сургуулийн багш | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил болон бусад чадварыг үнэлнэ. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд чиглэсэн сургалт зохион байгуулна. | • Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт<br>• Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | | |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зохицуулалт хийдэг. | • Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт<br>• Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |
| ДЭМТ-ийн хүүхдийн эмч | Сургалт зохион байгуулна. Эрүүл мэндийн талын зөвлөгөө өгнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон судалгаа гаргаж, мэдээлэл өгнө. Олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөв үнэлж, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, өрхийн эмч болон бусад эмч нарт зөвлөгөө өгөн, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн түвшинг тогтоож, хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулж ажилладаг. Комисс болон Салбар комиссын хурал, уулзалтад оролцож, сургалт зохион байгуулж мөн сургалтад хамрагддаг. | Сургалтад хамрагдаагүй. |

*Хүснэгт 1-6 Салбар комиссын чиг үүргийн талаарх ойлголт, ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал*

*(Хөвсгөл аймаг)*

| Албан тушаал (Хариуцаж буй ажил) | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Салбар комисст гүйцэтгэж буй үүрэг | Энэ чиглэлээр сургалтад хамрагдсан байдал | Салбар комисст гүйцэтгэж буй үүрэг | Салбар комисст гүйцэтгэж буй үүрэг |
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Салбар комиссын дарга) | Салбар комиссын үйл ажиллагааг хариуцах, удирдлагаар хангана. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагууд, бусад салбартай уялдаатай ажиллан, эцэг эхчүүдэд зөвлөгөө, тайлбар өгдөг. | • Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт<br>• Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт |
| Аймаг ХХҮГ-ын мэргэжилтэн (Нарийн бичгийн дарга) | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлжит хуралдаанаар хууль журмын дагуу шударга шийдвэр гаргахад анхаарч ажиллана. Салбар комиссын шийдвэрийг нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний бодлогод тулгуурлаж хэрэгжүүлнэ. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Эцэг эх, асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хууль тогтоомж болон холбогдох мэдээллээр хангадаг. Сургалт зохион байгуулж, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг. | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |
| Аймгийн БСУГ-ын Насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн арга зүйг зааж, сургууль, цэцэрлэгт дэмжлэг үзүүлнэ. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэн хамтарч ажилладаг. Салбар комиссын боловсролтой холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийдэг. | Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт |
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хуулийн тогтоомжийн хүрээнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн талаас нь дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн, тэдэнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэнэ. | Сургалтад хамрагдаагүй. | | |
| Хүүхэд, гэр бүл, | | | Нийгмийн ажилтны хувиар хүүхэд нэг бүрт | • Долоо хоног |

| | | | | |
|---|---|---|---|---|
| залуучуудын хөгжлийн хэлтсийн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн | | | үнэлгээ хийдэг. Эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх асуудал ч хариуцдаг. | хүртэлх богино хугацааны сургалт |
| Аймгийн НЭ-ийн бүртгэл мэдээллийн тасгийн дарга, (Эмч) | Хөгжлийн бэрхшээлийн оношийг нэгтгэнэ. Эмчилгээ, сувилгаа хариуцна. | • Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт<br>• Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оюун ухааны чадамжийг шалгаж, үнэлгээ хийдэг. | • Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт<br>• Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт |
| Аймгийн НЭ-ийн хүүхдийн ерөнхий мэргэжилтэн (Эмч) | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг оношилж, чадамжийг үнэлж тогтооно. Эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, эрүүл мэндийн болон боловсролын байгууллагатай холбоно. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт | Хүүхдийг оношлох болон саад бэрхшээлийг багасган, чадварыг нөхөн сэргээхэд чиглэсэн зөвлөгөө дэмжлэг үзүүлдэг. | Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт |
| “Өвгөд” төв ТББ-ын багш | | | Боловсролд хамруулж, хоцрогдлыг арилгадаг. нийгмийн оролцоог дэмжин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалахад анхаарч ажилладаг. | • Хэдэн долоо хоногоос 6 сар хүртэлх дунд хугацааны сургалт<br>• Долоо хоног хүртэлх богино хугацааны сургалт |

## 2. Ажлын туршлага

### 2-1 Дэмжлэг үзүүлэн ажилласан хүүхдийн тоо

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын тус тус зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилласан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв. Баянгол дүүрэг 2015 онд 46 хүүхдэд дэмжлэг үзүүлсэн ба энэ үзүүлэлт 2018 онд 12.8 дахин буюу 588 болж өссөн бол Хөвсгөл аймгийн хувьд 2015 оныхоос 1.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 1-7 Салбар комиссын дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо*

| | 2015 он | 2018 он | Өсөлт |
|---|---|---|---|
| Баянгол дүүрэг | 46 | 588 | 12.8 дахин |
| Хөвсгөл аймаг | 265 | 479 | 1.8 дахин |

### 2-2 Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссуудын хамтарч ажилласан байгууллага болон тухайн ажлын агуулгын талаар тэмдэглэсэн хариултын үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Суурь судалгааны үед Баянгол дүүрэгт ээлжит хуралдаан зохион байгуулагдаж эхлээгүй байсан тул Салбар комиссын гишүүдийн өдөр тутмын ажлын хамтын ажиллагааны талаарх хариулт их тэмдэглэгдсэн байсан ба Салбар комиссын хүрээнд хийж байсан ажил нь судалгаа, мэдээлэл түгээх, зөвлөгөө өгөхөөс хэтрэхгүй байсныг харж болно. Харин эцсийн төлөв байдлын судалгаанд Салбар комисс ажил үүрэгтэй шууд холбоотой хамтарч ажилладаг байгууллагууд болон ажлын агуулгын (Сургуульд хамрагдалтыг дэмжих, ээлжит хуралдааны өдрийг товлох) талаар тэмдэглэдэг болсон. Тэр дундаас дараах хариултуулыг онцлон хүргэе.

- Дүүргийн боловсролын хэлтэс, цэцэрлэг, тусгай сургууль, ердийн сургуулиудтай хамтран ажилласан агуулгад сургуульд хамрагдахад үзүүлэх дэмжлэг багтдаг болсон.
- Эцэг эх, асран хамгаалагчийн ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажилладаг болсон.
- Хүүхдийн бодит байдлыг тодорхойлох, үнэлэх, хэрэгцээнд нь нийцсэн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулахдаа хорооны нийгмийн ажилтан хамтарч ажилладаг болсон.
- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх болон ээлжит хуралдаан зохион байгуулахдаа өрхийн эмч нартай хамтарч ажилладаг болсон.

*Хүснэгт 1-8 Салбар комиссын хамтарч ажилладаг байгууллага болон гол үйл ажиллагаа (Баянгол дүүрэг) (N=7)*

| Хамтарч ажилласан байгууллагууд | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ажлын агуулга | Хариултын тоо | Ажлын агуулга | Хариултын тоо |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс | • Судалгаа явуулж, мэдээлэл солилцсон.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхтэй хамт бүтээл хийсэн. | 5/7 | • Удирдах ажилтны үүргээр<br>• Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах<br>• Салбар комиссын бичиг баримт боловсруулах | 4/7 |
| Дүүрэг халамж, үйлчилгээний хэлтэс | • Халамжийн тэтгэмж олгосон.<br>• Судалгаа, нийгмийн халамж, сургалттай холбоотойгоор хамтарч ажилласан. | 4/7 | • Мэргэжилтний үүргээр<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик мэдээг үнэлэх<br>• Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Халамжийн тэтгэмж олгох | 5/7 |
| Дүүрэг Боловсролын хэлтэс | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хамруулахад хамтарч ажилласан.<br>• Хүүхдээ хүргэж өгч, авах гээд хүлээж байгаа эцэг эх, асран хамгаалагч нарын дунд бүтээл хийх уралдаан зохион байгуулж, сургалт явуулсан. | 4/7 | • Сургуульд хамрагдалтыг дэмжих<br>• Ердийн сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалт зохион байгуулах, мэдээлэл түгээх | 4/7 |
| Цэцэрлэг | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотойгоор хамтарч ажилласан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хамруулсан.<br>• Тусламж, судалгаа, танилцуулга<br>• Хүүхдээ хүргэж өгч, авах гээд хүлээж байгаа эцэг эх, асран хамгаалагч нарын дунд бүтээл хийх уралдаан зохион байгуулж, сургалт явуулсан. | 4/7 | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг дэмжих<br>• Боловсролд тэгш хамруулах<br>• Цэцэрлэгийн эрхлэгч нарт зориулсан сургалт зохион байгуулах | 6/7 |
| Сургууль | • Сургалттай холбоотойгоор хамтарч ажилласан.<br>• Эцэг эх, багш нарт нийгмийн халамжийн хуулийн талаар мэдээлэл өгсөн.<br>• Урлагийн наадам, үзэсгэлэн зохион байгуулах, харилцах, судалгаа хийх, мэдээлэл түгээхэд хамтарсан.<br>• Хүүхдээ хүргэж өгч, авах гээд хүлээж байгаа эцэг эх, асран хамгаалагч нарын | 6/7 | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердийн сургуульд хамрагдалтыг дэмжих<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан хурал зохион байгуулах<br>• Спортын тэмцээн зохион байгуулах<br>• Сургалт зохион байгуулах | 6/7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | дунд бүтээл хийх уралдаан зохион байгуулж, сургалт явуулсан. | | | |
| Ердийн сургууль | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлсэн.<br>• Сургалт зохион байгуулсан.<br>• Урлагийн наадам, үзэсгэлэн зохион байгуулах, харилцах, судалгаа хийх, мэдээлэл түгээхэ хамтарсан.<br>• Хүүхдээ хүргэж өгч, авах гээд хүлээж байгаа эцэг эх, асран хамгаалагч нарын дунд бүтээл хийх уралдаан зохион байгуулж, сургалт явуулсан.<br>• 113 дугаар сургуулийн 2 сурагчийн эцэг эхтэй хамтарч ажилласан. | 6/7 | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердийн сургуульд хамрагдалтыг дэмжих<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт зохион байгуулах | 6/7 |
| Дүүргийн хөдөлмөрийн хэлтэс | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ажил эрхлэх боломжтой холбоотой асуудлаар хамтарч ажилласан.<br>• Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>• Хүүхдээ хүргэж өгч, авах гээд хүлээж байгаа эцэг эх, асран хамгаалагч нарын дунд бүтээл хийх уралдаан зохион байгуулж, сургалт явуулсан. | 3/7 | • Эцэг эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 2/7 |
| ДЭМТ | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлж, хөгжлийн дэмжлэг үзүүлсэн.<br>• Үзлэг<br>• Мэдээлэл солилцох, сургалт зохион байгуулсан.<br>• ӨЭМТ-ийн эмч нарт зориулсан сургалт зохион байгуулсан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан. | 6/7 | • Эрүүл мэндийн үзлэг хийх<br>• Үзлэг, шинжилгээ<br>• Онош<br>• Хөдөлгөөн засал | 4/7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хорооны нийгмийн ажилтан | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоотой холбоотой судалгаа хийсэн.<br>• Нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлсэн.<br>• Судалгаа, сургалт, мэдээлэл түгээх, санал бодлоо солилцох үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>• ӨЭМТ-ийн эмч нарт зориулсан сургалт зохион байгуулсан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан. | 5/7 | • Бодит байдлыг тодруулж үнэлгээ хийх<br>• Хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээг төлөвлөх<br>• Нийгмийн оролцоог дэмжих<br>• Гэрээр зөвлөгөө өгөх<br>• Сургалт | 6/7 |
| ӨЭМТ | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн сан үүсгэсэн.<br>• Судалгаа хийсэн.<br>• Сургалт зохион байгуулсан.<br>• ӨЭМТ-ийн эмч нарт зориулсан сургалт зохион байгуулсан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан. | 5/7 | • Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх<br>• Эмчилгээ<br>• Тодорхойлолт боловсруулах<br>• Ээлжит хуралдааны өдрийг товлох, мэдээлэл түгээх, оролцох хүүхдийг сонгох | 7/7 |
| Бусад | • ТББ-уудад зөвлөгөө өгч санал солилцсон. | 2/7 | • Хүүхдийн эмчилгээтэй холбоотой СЭМҮТ-тэй хамтарч ажиллах<br>• Хувийн хэвшлийн сургуулиуд болон ТББ-уудтай хамтарч ажиллах | 2/7 |

Хөвсгөл аймгийн Салбар комисс нь суурь судалгааны үед ээлжит хуралдаан зохион байгуулж эхэлсэн байсан ба ялангуяа нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх шийдвэр болон эрүүл мэндийн байгууллагад үйлчилгээ авахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байсан. Харин Эцсийн төлөв байдлын судалгаанд нийт Салбар комиссын гишүүд “Аймгийн БСУГ-тай хамтарч ажиллаж байгаа” гэж хариулсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хамруулах шийдвэр гаргах болон түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь зайлшгүй шаардлагатай асуудал гэдгийг ойлгодог болсон.

*Хүснэгт 1-9 Салбар комиссын хамтарч ажилладаг байгууллага болон гол үйл ажиллагаа (Хөвсгөл аймаг) (Суурь судалгаа N=6, Эцсийн төлөв байдлын судалгаа N=7)*

| Хамтарч ажилласан байгууллагууд | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ажлын агуулга | Хариултын тоо | Ажлын агуулга | Хариултын тоо |
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс | • Үйл ажиллагааг тайлагнасан: | 3/6 | • Сургалт зохион байгуулах Спортын тэмцээн зохион байгуулах<br>• Сургалт зохион байгуулах<br>• Олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах | 5/7 |
| Аймгийн Нийгмийн халамжийн газар | • 200 хүний “Хөгжлийн хоцрогдол”-той холбоотой асуудлыг шийдвэрлэсэн.<br>• 200-350 хүнд мөнгөн тусламж үзүүлсэн.<br>• Ойролцоогоор 200 хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх шийдвэр гаргасан. | 6/6 | • Сургалт зохион байгуулах<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулах<br>• Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт зэрэг шийдвэр<br>• Дэмжлэг<br>• Санал солилцох | 7/7 |
| Аймгийн БСУГ | — | 3/6 | • Хамрагдах сургуулийг шийдэх<br>• Сургалт зохион байгуулах<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулах | 7/7 |
| Цэцэрлэг | — | 1/6 | — | 2/7 |
| Сургууль | • 4 хүүхдэд 29 дүгээр тусгай сургуульд (Сонсголын бэрхшээл) элсэхэд нь дэмжлэг үзүүлсэн. | 3/6 | — | 2/7 |
| Ердийн сургууль | • Ердийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн халамж, боловсролын үйлчилгээ үзүүлэх шийдвэр гаргасан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд унааны зардал болон бусад дэмжлэг үзүүлсэн.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан анги танхим бий болгосон. | 6/6 | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч буй ердийн сургуультай хамтран ажиллах<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулах<br>• Шинэ жил, Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг угтсан үйл ажиллагаа зохион байгуулах<br>• Спорт тэмцээн зохион байгуулах | 6/7 |
| Аймгийн Хөдөлмөрийн газар | — | 1/6 | — | 0/7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Аймгийн нэгдсэн эмнэлэг | • Ойролцоогоор 280 хүнд нарийн мэргэжлийн үзлэг хийлгэх шийдвэр гаргасан.<br>• Ойролцоогоор 200 хүнд нарийн мэргэжлийн эмч үзлэг хийсэн. | 4/6 | • Эмчилгээ<br>• Сэргээн засал<br>• Спорт тэмцээн зохион байгуулах | 5/7 |
| Багийн (Сум) нийгмийн ажилтан | • Салбар комиссын шийдвэрийн дагуу нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн. | 3/6 | • Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулах<br>• Спорт тэмцээн зохион байгуулах<br>• Үйл ажиллагаа зохион байгуулах | 2/7 |
| ӨЭМТ | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл мэдээлэл хариуцсан.<br>• Ойролцоогоор 80 хүнд сэргээн засах эмчилгээ хийсэн.<br>• Бүртгэл мэдээлэл, зөвлөгөө | 4/6 | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг өгөх<br>• Спорт тэмцээн зохион байгуулах | 4/7 |
| Бусад | • Сум, орон нутгийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийг нэгтгэж, бүртгэлжүүлсэн. | 2/6 | • Монголын Улаан загалмайн Нийгэмлэгтэй хамтарч ажиллах<br>• Дэлхийн зөн ОУБ-тай хамтарч ажиллах<br>• “Өвгөд” төвтэй хамтран ажиллах<br>• Эцэг эхийн холбоотой хамтарч ажиллах | 3/7 |

**2-3 Комиссын талаарх ойлголт, хамтын ажиллагаа**

Салбар комиссын гишүүдийн Комиссын талаарх ойлголт, хамтын ажиллагааг тандах зорилготой “Комиссын талаар мэдэх үү”, “Комиссын үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ” гэсэн асуултын хариултын дүнг График 1-1, Хүснэгт 1-10-т үзүүлэв.

Суурь судалгаанд “Комисс идэвхтэй үйл ажиллагаа явуулах”, “Комиссын үйл ажиллагаа тодорхой чиглэлтэй байх” гэсэн саналууд болон Салбар комиссын үйл ажиллагаа төлөвлөгөө, оношилгооны стандарт, дэмжлэгийн жишгийг тодорхойлж өгөхийг хүссэн хариултуудыг тэмдэглэсэн байсан. Эцсийн төлөв байдлын судалгаанд дээрх хүсэлт саналууд дурдагдаагүй байснаас үзэхэд Комисс болон Салбар комиссын үйл ажиллагаа жигдэрч, тодорхой болсон нь харагдаж байна. Харин ч сурталчлан таниулах, нөлөөллийн ажил, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалтуудыг зохион байгуулах шаардлагатайг ойлгосон байлаа.




*График 1-1 “Комиссын талаар мэдэх үү” гэсэн асуултад өгсөн хариулт (Суурь судалгаа N=13, Эцсийн төлөв байдлын судалгаа N=14)*

*Хүснэгт 1-10 “Комиссын ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ” гэсэн асуултад өгсөн хариулт (Суурь судалгаа N=13, Эцсийн төлөв байдлын судалгаа N=14)*

| Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|
| **Комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт** | |
| • Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх<br>• Комисс идэвхтэй үйл ажиллагаа явуулах<br>• Комиссын үйл ажиллагаар тодорхой чиглэлтэй болгох<br>• Үнэн бодитой судалгаа хийх | • Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх дэмжлэйн тогтолцоо бүрдүүлэх<br>• Боловсрол хариуцсан мэргэжилтэнтэй болох<br>• Хөгжлийн бэрхшээлийг багасгах, тэгш хамруулан сургахад анхаарах<br>• Нөлөөллийн үйл ажиллагаа, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулж сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулах |
| **Салбар комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт** | |
| • Хэрхэн ажиллах арга зүйгээр тогтмол хангах<br>• Жилийн төлөвлөгөө гарган улирал тутамд төлөвлөгөөгөө танилцуулах<br>• Ажил үүргийн зохицуулалт хийх<br>• Оношилгооны жишиг заалтыг тодорхой болгох<br>• Халамж болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийн жишиг тогтоох | • Нарийн мэргэжлийн эмч нар, Салбар комиссын хамтарсан уулзалт зохион байгуулах<br>• Эцэг эхчүүдийг чадавхжуулах, ойлголт, хандлагыг дээшлүүлэх зорилгоор бусад байгууллагуудыг оролцуулах шаардлагатай |
| **Комиссоос хүлээж буй дэмжлэг** | |
| • Мэргэжлийн дэмжлэг үзүүлэх<br>• Комиссын тогтолцоог дахин танилцуулах<br>• Салбар комиссын гишүүдтэй санал бодлоо солилцож, зөвлөгөө өгөх<br>• Салбар комиссын хийх ажлын талаар мэдээлэл хүргэх | • Салбар комисст зориулж сургалт зохион байгуулан зөвлөгөө өгөх<br>• Салбар комиссоос хүргүүлдэг тайланд хариу, санал өгөх<br>• Салбар комиссоос зохион байгуулах нөлөөлийн ажил, сургалтад дэмжлэг үзүүлэх |
| **Цалин урамшуулалтай холбоотой хүлээлт** | |
| • Салбар комиссын гишүүдэд цалин, урамшуулал олгох | • Нэмэгдэл цалин олгох<br>• Гишүүд давхар ажил үүрэг гүйцэтгэх бус орон тооны ажилтан болох |

**2-4 Туршлага судлахаар ирсэн хүний тоо**

Төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнө болон дараах үед Салбар комиссын туршлага судлахаар ирсэн хүний тоог харьцуулж үзсэн. Баянгол дүүргийн Салбар комиссын туршлага судлахаар ирсэн хүний тоо 78-аас 21 болж буурсан байна. Энэ нь Салбар комиссын тогтолцоо нэвтэрч эхлэх тухайн үед аль хэдийн үйл ажиллагаа явуулж байсан Баянгол дүүргийн Салбар комиссын туршлагатай олон хүн танилцахаар ирсэнтэй холбоотой. Гэвч түүнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрсний дараа буюу эцсийн төлөв байдлын судалгааны үеэр бусад аймаг, дүүргийн Салбар комиссууд үйл ажиллагаа эхэлсэн тул туршлага судлахаар ирэх хүний тоо буурсан гэж үзэж байна. Харин Хөвсгөл аймгийн Салбар комиссын тухайд 2014-2015 онд туршлага судлахаар ирсэн хүний тоо 0 байсан бол 2017-2018 онд Хөвсгөл аймагт бусад газраас 38 хүн, сумдаас 24 хүн ирж үйл ажиллагаатай танилцсан байна.

*Хүснэгт 1-11 Салбар комиссын туршлагатай танилцахаар ирсэн хүний тоо*

| | 2014-2015 он | 2017-2018 он |
|---|---|---|
| Баянгол дүүргийн Салбар комисс | 9 дүүрэг, 3 аймгаас 78 хүн | 2 аймгаас 21 хүн |
| Хөвсгөл аймгийн Салбар комисс | байхгүй | 1 дүүрэг, 1аймгаас 38 хүн<br>Бүх сумдын насан туршийн боловсролын төвөөс 24 хүн |

**3. Мэдлэг, чадвар**

**3-1 Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт**

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтын түвшинг үнэлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлийн талаар асуусан ба хариултыг доорх хүснэгтэд нэгтгэв.

Баянгол дүүргийн Салбар комиссын тухайд суурь болон эцсийн төлөв байдлын судалгаа аль алинд ихэнх хариултуудад бие эрхтний үйл ажиллагаа, дэмжлэг шаардлагатай, үйл ажиллагаа болон оролцооны хязгаарлагдмал байдлын тухай онцолсон байсан. Суурь судалгаанд "Бие эрхтэн систем болон бусад саад бэрхшлээлээс улбаалан бусадтай харьцуулахад нийгмийн амьдралд оролцоход хязгаарлагдмал байгааг хөгжлийн бэрхшээл гэнэ" гэж хариулж байсан 1 хүн, эцсийн төлөв байдлын судалгаанд хүрээлэн буй орчинд байгаа саад тотгорын талаар онцолсон байлаа.

*Хүснэгт 1-12 Салбар комиссын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт (Баянгол дүүрэг) (N=7)*

| Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|
| Бие эрхтний үйл ажиллагаа: 2<br>• Бусадтай харьцуулахад нийгмийн харилцаанд орох чадвар тодорхой хэмжээгээр алдагдсан<br>• Бусадтай харьцахдаа хүндрэлтэй | Бие эрхтний үйл ажиллагаа: 2<br>• Эрүүл мэнд болон нийгмийн хүчин зүйлээс шалтгаалж үүссэн хөгжих үйл ажиллагааны өөрчлөлт<br>• Бие эрхтний үйл ажиллагаа, бүтцээс шалтгаалан үүссэн хөгжлийн хоцрогдол |

| | |
|---|---|
| <u>Дэмжлэг шаардлагатай: 2</u><br>• Бусадтай харьцуулахад нийгмийн харилцаанд ороход үргэлж хүндрэл тулгарч, сургалтын тусгай аргачлал, хэрэглэглэхүүн шаарддаг<br>• Нийгэмд бие даан амьдрахад шаардлагатай чадвар алдагдаж, бусдын дэмжлэгтэйгээр л өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд оролцох боломжтой | |
| <u>Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал: 3</u><br>• Үйл ажиллагаа хязгаарлагдсан<br>• Үйл ажиллагааны хязгаарлагдмал байдал<br>• Бие махбод, эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа, бусад саад бэрхшээлээс шалтгаалан бусадтай харьцуулахад нийгмийн амьдралд оролцох боломж хязгаарлагдсан байдал | <u>Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал: 3</u><br>• Бие махбод, эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа, бүтцийн өөрчлөлтөөс үүдэн нийгмийн оролцоо хязгаарлагдах (2 хүн)<br>• Нийгмийн амьдралын оролцоо хязгаарлагдсан байдал |
| | <u>Орчны саад тотгор: 1</u><br>Бие эрхтэн, тогтолцооны өөрчлөлт нь орчны бусад саад тотгор, хүндрэлтэй нийлснээр бусдын адил эрх тэгш нийгэмд оролцож чадахгүй байх. Өөрөөр хэлбэл нийгмийн оролцоо хязгаарлагдсан хүнийг хэлнэ. |
| | <u>Хариулаагүй: 1</u> |

Хөвсгөл аймгийн Салбар комиссын тухайд суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгаа аль алинд өгсөн зонхилох хариултууд нь бие эрхтний үйл ажиллагаа, дэмжлэг шаардлагатай, үйл ажиллагаа болон оролцооны хязгаарлагдмал байдал гэсэн байсан. Суурь судалгаанд орчны саад тотгорын талаар хариулсан 1 хүн эцсийн төлөв байдлын судалгаанд ч ижил хариулт өгсөн. Өөр 1 хүн суурь судалгаанд "Төрөлхийн болон олдмол өвчин эмгэгээс үүдэн оюун ухаан, сэтгэц, бие эрхтний үйл ажиллагаа алдагдсаныг хөгжлийн бэрхшээл гэнэ" гэж тайлбарласан ба төсөл дэмжлэг үзүүлэх хугацаанд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын тухай ойлголттой болсон байгаа нь харагдсан.

*Хүснэгт 1-13 Салбар комиссын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт (Хөвсгөл аймаг)*
*(Суурь судалгаа N=6, Эцсийн төлөв байдлын судалгаа N=7)*

| Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|
| <u>Бие эрхтний үйл ажиллагаа: 2</u><br>• Төрөлхийн болон олдмол өвчин эмгэгээс үүдэн оюун ухаан, сэтгэц, бие эрхтний үйл ажиллагаа алдагдах<br>• Эрүүл мэндийн шалтгааны улмаас нийгэмд өөрийн үзэл санаа, байр сууриа илэрхийлж чадахгүй байх | <u>Бие эрхтний үйл ажиллагаа: 3</u><br>• Хөгжлийн онцлогтой хүмүүс<br>• Тухайн хүүхдийн хөгжил өөрчлөлттэй байх. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээл гэж хэлмээргүй байна<br>• Төрөлхийн болон олдмол өвчин эмгэгээс үүдэн бие эрхтний үйл ажиллагаа, бүтэц өөрчлөгдөх |
| <u>Дэмжлэг шаардлагатай: 2</u><br>• Бусдын дэмжлэг зайлшгүй хэрэгтэй<br>• Ямар нэгэн тусгай хэрэгцээ, дэмжлэг шаардлагатай (Тусгай хэрэгцээ) | |

| Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал: 1 | Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал: 2 |
|---|---|
| • Суралцах, амьдрах, нийгмийн харилцаанд ороход хязгаарлагдмал байдал үүсэх | • Бие махбодын бүтцийн өөрчлөлтөөс үүдэн үйлдэл хязгаарлагдах<br>• Бие эрхтний үйл ажиллагаа, бүтцийн өөрчлөлтөөс үүдэн ниймийн оролцоо, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа их бага хэмжээгээр хязгаарлагдаж, хүндрэл үүсэх |
| Орчны саад тотгор: 1<br>Тухайн нэг орчинд саад тотгор үүсэх, эсвэл биеийн аль нэг хэсгийн хөгжил хоцрогдох | Орчны саад тотгор: 2<br>• Орчны саад тотгороос үүдэн үйлдэл хязгаарлагдах<br>• Хөгжлийн бэрхшээл гэдэг нь бие махбодын бүтцийн өөрчлөлт болон орчны хүчин зүйлээс үүдэн бий болсон саад бэрхшээл, хүндрэл юм. |

Үүнээс дүгнэхэд эрүүл мэндийн загварт суурилсан хөгжлийн бэрхшээлийн талаарх уламжлалт ойлголт нийгмийн загварт шилжиж байгаа гэж хэлэхэд хүндхэн байна.

### 3-2 Мэдлэг, ойлголт

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн Салбар комиссын энэ салбартай холбоотой мэдлэг, ойлголтыг үнэлэх зорилгоор 6 үндсэн сэдвийн 22 асуулттай тестийн аргыг ашигласан. Сэдэв тус бүрийн болон асуулт бүрийн зөв хариултын тоог Хүснэгт 1-14, 1-15-д үзүүлэв.

*Хүснэгт 1-14 “Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт” тест*

*(Баянгол дүүрэг) (N=7)*

| № | Асуулт | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|---|---|
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | **50%** | **78.57%** |
| 1.1 | НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал”-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ? | 2/7 | 6/7 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, “Бие махбодын бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл”, “Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал”-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | 5/7 | 5/7 |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | **46.43%** | **57.14%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 6/7 | 5/7 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ? | 2/7 | 2/7 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 3/7 | 3/7 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 2/7 | 6/7 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | **67.86%** | **67.86%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 6/7 | 6/7 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 5/7 | 4/7 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 3/7 | 3/7 |
| 3.4 | Бага насны мэдрэхүйн хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 5/7 | 6/7 |
| **4** | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | **53.57%** | **57.14%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 3/7 | 2/7 |

| | | | |
|---|---|---|---|
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 7/7 | 7/7 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 3/7 | 3/7 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 2/7 | 4/7 |
| **5** | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | **32.14%** | **42.86%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 3/7 | 5/7 |
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ? | 1/7 | 2/7 |
| 5.3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)" боловсруулахад илүү тохиромжтой вэ? | 4/7 | 4/7 |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн "Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)" онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 1/7 | 1/7 |
| **6** | **Багшлах арга зүйн талаарх ойлголт** | **46.43%** | **46.43%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 5/7 | 3/7 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 1/7 | 4/7 |
| 6.3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 4/7 | 3/7 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 3/7 | 3/7 |

Баянгол дүүргийн Салбар комиссын тухайд суурь судалгаатай харьцуулахад "Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт", "Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт", "Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт" сэдвийн тестийн гүйцэтгэл эцсийн төлөв байдлын судалгаанд илүү өндөр гарсан. Харин Салбар комисст шууд хамааралгүй "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт", "Багшлах арга зүй талаарх ойлголт" зэрэг боловсролтой холбоотой сэдвийн тестийн гүйцэтгэл эцсийн төлөв байдлын судалгаанд мөн 50% хүрэхгүй байсан.




*График 1-2 "Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт" тестийн асуулт тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Баянгол дүүрэг) (N=7)*

*Хүснэгт 1-15 "Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт" тест (Хөвсгөл аймаг )*

*(Суурь судалгаа N=6, Эцсийн төлөв байдлын судалгаа N=7)*

| № | Асуулт | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|---|---|
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | **75.00%** | **57.14%** |
| 1.1 | НҮБ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал"-ыг Монгол Улс хэззэ соёрхон баталсан бэ? | 4/6 | 4/7 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, "Бие махбодын бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл", "Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал"-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | 5/6 | 4/7 |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | **45.83%** | **53.57%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 1/6 | 7/7 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ? | 4/6 | 1/7 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 1/6 | 5/7 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 5/6 | 2/7 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | **54.17%** | **67.86%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 5/6 | 6/7 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 1/6 | 4/7 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 5/6 | 6/7 |
| 3.4 | Бага насны мэдрэхүйн хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 2/6 | 3/7 |
| 4 | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | **45.83%** | **46.43%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 5/6 | 2/7 |
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 6/6 | 6/7 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 0/6 | 2/7 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 0/6 | 3/7 |
| 5 | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | **45.83%** | **50.00%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 5/6 | 5/7 |
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ? | 1/6 | 3/7 |
| 5.3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)" | 3/6 | 3/7 |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсруулахад илүү тохиромжтой вэ? | | |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн "Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)" онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 2/6 | 3/7 |
| **6** | **Багшлах арга зүйн талаарх ойлголт** | **29.17%** | **28.57%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 2/6 | 1/7 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 0/6 | 0/7 |
| 6.3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 3/6 | 3/7 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 2/6 | 4/7 |

Суурь судалгаатай харьцуулахад Хөвсгөл аймгийн Салбар комиссын "Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт", "Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг", "Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт" нь эцсийн төлөв байдлын судалгаанд илүү дээгүүр гүйцэтгэлтэй байна.




*График 1-3 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт тестийн сэдэв тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Хөвсгөл аймаг)*
*(Суурь судалгаа N=6, Эцсийн төлөв байдлын судалгаа N=7)*

**3-3 Хөгжлийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх**

Салбар комиссын гишүүд хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадварын талаар хэрхэн туршлага хуримтлуулж, ямар ойлголттой болсон талаар ярилцаж 1) Хөгжлийн үнэлгээ хийх чадвар, 2) Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвар, 3) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар гэсэн 3 чиглэлээр асуулт тавив.

**Баянгол дүүргийн Салбар комиссын 7 гишүүнтэй хийсэн ярилцлага (2018.12.24)**

### 1) Хөгжлийн үнэлгээ

Төслийн хүрээнд МУБИС болон Нагоя Их сургуулийн "Танака Бине оюун ухааны сорил V"-ын Монгол хувилбар боловсруулах хамтарсан судалгаанд тодорхой дэмжлэг үзүүлэн оролцсон. Жишиг тогтоох судалгаанд Салбар комиссын 2 гишүүн 2 удаа сорил авагчаар оролцсон. Ингэхдээ ялгаатай насны хүүхдээс сорил авсан тул сорил авагчийн хувьд нилээд итгэлтэй, туршлагатай болсон.

Мөн төсөл "Шинэчилсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр"-ийн Монгол хувилбарыг боловсруулсан ба уг хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад Салбар комиссын 3 гишүүн оролцсон. Эдгээр 3 гишүүний 1 нь зөвлөгөө өгч ажиллахгүй байгаа ба бусад 2 гишүүн нь Салбар комиссын ээлжит хуралдаанаар хөгжлийн хоцрогдолтой нь тогтоогдсон хүүхдүүдэд тус хөтөлбөрийг ашиглан зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна.

Үүнээс дүгнэхэд Баянгол дүүргийн Салбар комиссын хөгжлийн үнэлгээ хийх чадавх бэхжсэн байна.

### 2) Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан ээлжит хуралдааныг сард 2 удаа зохион байгуулж байна. Төслөөс өгсөн зөвлөгөөний үр дүнд эцэг эх, асран хамгаалагчийн хүлээх цаг урьдынхаасаа илүү багассан зэргээр хурлыг үр бүтээлтэй зохион байгуулдаг болсон.

Түүнчлэн шийдвэрлэхэд хүндрэлтэй хүүхдийн кэйсийг сонгон авч "Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)"-д суурилсан үнэлгээ хийн、хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулдаг Кэйс хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. 2018 оны 12 сарын байдлаар 5 удаа тус хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна. ICF-ын зарчмын талаах нэлээдгүй ойлголттой болсон тул 2018 оны 10 сард төслийн дэмжлэг оролцоогүйгээр бие даан зохион байгуулан.

Сонгож хэлэлцсэн кэйсийн нэг болох Баянгол дүүргийн гэр хороололд амьдардаг 7 настай хүүгийн тухайд гэр бүл нь ойролцоох Чингэлтэй дүүрэг рүү нүүсэн шалтгаанаар Баянгол дүүрэгт дэмжлэг авах боломжгүй байсныг Чингэлтэй дүүргийн Салбар комиссд шилжүүлж, дэмжлэг авах боломжтой болгож зохицуулсан. Түүний үр дүнд зорилтот хүүхэд Чингэлтэй дүүргийн ЕБС-д элсэн орж, дүү нь ч цэцэрлэгт хамрагдаж чадсан. Хяналтын үйл ажиллагаагаар дамжуулан хүүгийн ээжийг ажил эрхлэх боломжтой болсныг тодруулсан.

Үүнээс дүгнэхэд Баянгол дүүргийн Салбар комиссын хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх бэхжсэн байна.

### 3) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдийг 3 дахь шатлалын эрүүл мэндийн байгууллага руу илгээгээд зогссохгүй, цэцэрлэгт хамруулах зорилгоор хүүхэд, түүний гэр бүлийг дэмжих зайлшгүй шаардлагатай гэж үзэн, төслийн хүрээнд туршилтын аймаг, дүүргийн Салбар комисстой хамтран “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг зохион байгуулж байна. Баянгол дүүрэгт Салбар комиссын 2 гишүүн багшаар бэлтгэгдэн хөтөлбөрийг хариуцан зохион байгуулдаг. Цаашид ДЭМТ-өөс 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн тайлан мэдээг авч, Салбар комиссоос “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-т хамруулах хүүхдийг сонгон зохицуулалт хийж байхаар болсон.

Эдгээр хариултаас үзэхэд Баянгол дүүргийн Салбар комиссын хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавх бэхжсэн гэж дүгнэж болохоор байна.

**<u>Хөвсгөл аймгийн Салбар комиссын 6 гишүүнтэй хийсэн ярилцлага (2018.10.31)</u>**

**1) Хөгжлийн үнэлгээ**

“Танака Бине оюун ухааны сорил V”-ын Монгол хувилбар боловсруулах судалгаанд Салбар комиссын 3 гишүүн сорил авагчаар оролцсон. Тус сорилын талаар илүү гүнзгий ойлголттой болж, сорилын арга зүйд суралцсан гэж бодож байгаа.

Портеж эрт боловсролын хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад 3 гишүүн оролцсон. Эдгээр гишүүдийн хувьд зөвлөгөө өгч ажиллахгүй байгаа ч тус хөтөлбөрийг ашиглаж байгаа Хөвсгөл аймгийн 3 байгууллагын мэргэжилтнүүдэд дэмжлэг үзүүлдэг. Салбар комиссын 1 гишүүн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд Портеж хөтөлбөрөөр зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх байр гаргаж өгсөн.

**2) Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах**

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхчүүдэд зориулсан ээлжит хуралдааныг сард 2 удаа тогтмол зохион байгуулдаг. Эцэг эх, асран хамгаалагчтай ярилцаж, зөвлөгөө өгөн, аймгийн холбогдох газар, хэлтэс, байгууллагууд руу холбон зуучилдаг.

Кэйс хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сарын байдлаар 3 удаа зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээр сургуульд шилжин суралцахад дэмжлэг үзүүлэх, Нийслэлийн эмнэлэгт үзлэг шинжилгээ өгөхөөр явахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулдаг. Кэйс бүр дээр хариуцан ажиллах хүн/байгууллагыг томилж, дэмжлэгийн дараах хяналт хийдэг болсон.

Үүнээс дүгнэхэд Хөвсгөл аймгийн Салбар комиссын хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадавх бэхжсэн гэж үзэж байна.

**3) Хөгжлийн дэмжлэг үзүүлэх**

Хөвсгөл аймагт ч мөн ялгаагүй Салбар комиссын удирдлага дор “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөвсгөл аймгийн ЭМГ нь 18 сартай

хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгээс хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй нь илэрсэн хүүхдүүдийг тус хөтөлбөрт хамруулдаг.

Иймд Хөвсгөл аймгийн Салбар комиссын зүгээс хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадвар бэхжсэн гэж үзэж байна.

## 4. АСУУЛГЫН ХУУДАС

### КОМИСС & САЛБАР КОМИСС

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ийн "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах" төсөл нь 2015 оны 8-р сараас хэрэгжиж эхэлсэн. Төслийн үйл ажиллагаа явуулах туршилтын тойргийн хувьд Нийслэл болоод Хөвсгөл аймгийг сонгосон болно.

Тус төслийн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаар нэгтгэн дүгнэх зорилготойгоор эцсийн шатны судалгаа /endline survey /-г зохион байгуулж байна.

Та нэрээ заавал бичнэ үү! Судалгааны мэдээллийг зөвхөн төслийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд, судалгаанд оролцогчдын нэр болон хувийн мэдээллийг нууцлах болно.

*Энэхүү судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд заасан албан ёсны тодорхойлолтыг ойлгоно.

Он сар өдөр: ...............................................

Судалгаанд оролцогчийн нэр:...................

Мэдээлэл цуглуулагч: ...............................

**1. Ерөнхий мэдээлэл**

| № | Асуулт | Хариулт | |
|---|---|---|---|
| 1.1 | Комиссын нэр | | |
| 1.2 | Таны комисст гүйцэтгэж буй ажил үүрэг | | |
| 1.3 | Өөрийн комиссын чиг үүргүүдийг сонгоно уу? (ажлын чиг үүрэгтэй холбоотой боломжит бүх хувилбарыг сонгоно уу) | ☐Салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | ☐ХБХ-д дэмжлэг өгөх бусад байгууллагуудтай холбон зуучлах |
| | | ☐Хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон чадварыг үнэлэх, дэмжлэг үзүүлэх | ☐Салбар комиссын үйл ажиллагаа, гишүүдийн ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавих |
| | | ☐ХБХ-ийн эцэг эхийн санал, хүсэлтийг харгалзан үзэх | ☐Хөгжлийн дэмжлэг үзүүлэх бусад байгууллагуудад шаардлага тавих |
| | | ☐ХБХ-ийн бүртгэл, мэдээллийг улсын хэмжээнд гаргах талаар улсын бүртгэл болон статистикийн асуудал | ☐Дүгнэлт, шийдвэр гаргахдаа нарийн мэргэжлийн эмч, багшийг оролцуулах |

| | | | |
|---|---|---|---|
| | | хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах | |
| | | ☐Салбар комиссын шийдвэрийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах | ☐Шаардлагатай тохиолдолд хүүхдийг нарийвчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах зорилгоор холбогдох байгууллагад хүсэлт гаргах |
| | | ☐Комиссын үйл ажиллагааны тайланг жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавих, олон нийтэд мэдээлэх | ☐ХБХ-ийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх дүрэм, журам, заавар боловсруулах |
| | | ☐Шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллах | ☐Үйл ажиллагааны тайланг улирал тутамд комисст ирүүлэх |
| 1.4 | ХБХ-тэй ажиллахад та ямар үүрэгтэй вэ? | | |

**2. Мэдлэг, чадвар**

| № | Асуулт | Хариулт |
|---|---|---|
| 2.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи сургалтанд сууж байсан уу<br><br>(хэдэн ч хариулт байж болно) | □ Огт үгүй .<br>□ Богино хугацааны сургалтанд сууж байсан (нэг долоо хоногоос бага).<br>□ Тийм, дунд хугацааны сургалтанд (хэдэн долоо хоногоос 6сар хүртэлх).<br>□ Тийм, ХБХ-тэй хамаатай коллежийн хичээлд. (Жишээлбэл, МУБИС-ын 1жилийн анги г.м ) |
| 2.2 | (Зөвхөн салбар комиссын нарийн бичиг хариулна уу)<br>ХБХ-ийн хэдэн тохиолдолтой ажилласан бэ? /хүүхдийн тоо/ | …………………………… тохиолдолтой (2015)<br>…………………………….тохиолдолтой (2018) |
| 2.3 | Та "Хөгжлийн бэрхшээл" гэдэг үгийг нэг хоёр өгүүлбэрээр тайлбарлана уу? | |

**3. Бусад байгууллагатай харилцах**

| № | Асуулт | Хариулт | |
|---|---|---|---|
| | | Байгууллага | Хэрхэн ажилласан тухай |
| 3.1 | 2018 оны 3 сараас ХБХ-ийн асуудлаар бусад байгууллагуудтай ажилласан уу? (хэд хэдэн хариулт өгч болно) | ☐ Аймгийн нийгмийн хөгжлийн хэлтэс | |
| | | ☐ Аймгийн нийгмийн халамж үйлчилгээ-ний хэлтэс | |
| | | ☐ Аймгийн боловсролын газар | |
| | | ☐ Хүүхдийн цэцэрлэг | |
| | | ☐ Тусгай сургууль | |
| | | ☐ Ердийн сургууль | |
| | | ☐ Аймгийн хөдөл-мөрийн хэлтэс | |
| | | ☐ Аймгийн нэгдсэн эмнэлэг | |
| | | ☐ Баг,хорооны нийгмийн ажилтан | |
| | | ☐ Баг,хорооны өрхийн эмч | |
| | | ☐ Бусад | |
| 3.2 | *(Та салбар комиссын гишүүн бол)* ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын **Комиссын** талаар мэдэх үү? | ☐ Үгүй, Комиссын талаар мэдэхгүй<br>☐ Тийм, Комиссын талаар сонссон<br>☐ Тийм, Комиссын чиг үүрэг болон гишүүдийг мэднэ<br>☐ Тийм, Комисстой холбоо барьсан удаа бий | |
| 3.3 | **(Хэрэв 3.2-т тийм гэж хариулсан бол) Комиссын** ажил үүрэгтэй холбоотой Таны хүлээлт юу вэ? | | |
| 3.4 | *(Зөвхөн салбар комиссын нарийн бичиг хариулна уу)* Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаар туршлага судлахаар | 2014/2015 | 2017/2018 |
| | | ....... хүн | ......... хүн |

| | | | |
|---|---|---|---|
| | ирсэн хүмүүсийн тоо? | | |

**ТА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ МЭДЭЭЛЛЭЭ БИДЭНТЭЙ ХУВААЛЦНА УУ?**

| I | **Хөгжлийн бэрхшээлийн талаархи ойлголт** |
|---|---|
| 1 | НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал”-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ?<br>☐ 1985 онд.<br>☐ 2009 онд.<br>☐ Соёрхон батлаагүй<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)- д хөгжлийн бэрхшээлийг, ‘эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны алдагдал’, ‘үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал’ зэргээс гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ?<br>☐ Оролцооны хязгаарлагдмал байдал<br>☐ Эдийн засгийн хязгаарлагдмал байдал<br>☐ Хөдөлгөөний хязгаарлагдмал байдал<br>☐ Мэдэхгүй |

| II | **Эрт илрүүлэлт болоод хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | Дараах хариултын аль нь хүүхдийн үзлэг оношилгооны зорилгод хамаарах вэ?<br>☐ Хөгжлийн бэрхшээлийн төрлийг тодорхой болгох<br>☐ Хөгжлийн бэрхшээлтэй болоод бэрхшээлгүй хүүхдийг ялгаж таних<br>☐ Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тохирох тусламж үйлчилгээнд холбож өгөх<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ?<br>☐ Ой 5 сартайд<br>☐ 5 настайд<br>☐ Хөгжлийн бэрхшээлийн ангиллаас хамааран ялгаатай<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, эрт дэмжлэгт хамгийн чухал нь юу вэ?<br>☐ Нарийн мэргэжлийн эмнэлэгт хийх оношилгоо<br>☐ Эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол,төрийн байгууллагын хамтын ажиллагаа<br>☐ Нэн даруй халамжийн мөнгө олгох үйл ажиллагаа<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ?<br>☐ Эргэн тойрны тохиромжгүй харилцаанаас үүдсэн сэтгэл хөдлөл, үйл хөдлөлийн үл зохицох шинж<br>☐ Бусад хүүхдүүдтэй адилхан байх боломжгүйгээр шалтаглан эцэг/эхийн зүгээс хүчирхийлэл үзүүлэх<br>☐ Эцэг/эх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ юу ч чадахгүй гэж бодсоноос хэт их анхаарал халамж тавих.<br>☐ Мэдэхгүй |

| III | **Хүүхдийн хөгжлийн талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | Дараах хариултын аль нь хүүхдийн хөгжлийн үнэлгээний индекст багтах ба төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ?<br>☐ Нярайн рефлекс<br>☐ Ганганаж гунганах<br>☐ Инээмсэглэх<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аль илэрхийлэл нь 9 сар орчимтой хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн индекст багтах вэ?<br>☐ Харьцаж буй хүнийхээ яриаг ойлгон хамт мэдрэх<br>☐ Харьцаж буй хүнийхээ хөдөлгөөнийг даган дууриах<br>☐ Харьцаж буй хүнийхээ нүдний харц, дохио зангаагаар адил зүйлд анхаарал хандуулах<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн талаарх тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь эд юмсыг барих болон танин мэдэхүйн хөгжилтэй холбоотой.<br>☐ Том булчингийн хөдөлгөөний хөгжил нь хүүхэд бүрт ялгаа багатай, харин жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь их ялгаатай байдаг.<br>☐ Хэрэв оюуны бэрхшээлтэй бол том булчингийн хөдөлгөөний хөгжил хоцрогддог, жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь хоцрогдохгүй.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Хүүхдийн мэдрэхүйн хөгжлийн талаарх тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Төрсний дараа 1 сартайдаа насанд хүрсэн хүнтэй адилхан хардаг болно.<br>☐ Толгойгоо даадаг болсны дараа дагуулан харж сурна.<br>☐ Ураг эхийн хэвлийд байхаасаа дуу чимээг сонсож эхлэх ба сонсгол мэдрэхүй нь төрөхөөс өмнө бий болдог.<br>☐ Мэдэхгүй |

| IV | **Хөгжлийн бэрхшээлийн ангиллын талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | Оюуны бэрхшээлийн тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Нийгмийн харилцаанд орж чадаагүйн улмаас, хэвийн хөгжиж эхэлсэн оюуны үйл ажиллагаа нь буурахыг хэлнэ.<br>☐ Оюуны үйл ажиллагаа нь үе тэнгийнхнээс маш доогуур, өдөр тутмын бие эрхтний хөдөлгөөн нь хязгаарлагдахыг хэлнэ.<br>☐ Оюуны бэрхшээл нь хүүхдийн хөгжлийн үе төдийгүй, өсвөр насанд ч илэрч болно.<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аутизмыг оношлох стандартад аль нь багтах вэ?<br>☐ Бусадтай харилцахад хүндрэлтэй<br>☐ Хэл ярианы хоцрогдолтой<br>☐ Оюуны хөгжил нь хоцрогдолтой<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Тархины саажилттай хүүхдийн хараа нь асуудалгүй боловч, харааны танин мэдэхүйн бэрхшээлтэй байх тохиолдол бий.<br>☐ Тархины саажилттай хүүхдүүдээс зарим дуу авианы бэрхшээлтэй хүүхэд нь оюуны хоцрогдолтой байдаг.<br>☐ Тархины саажилттай хүүхдэд сэргээн засал эмчилгээ хийлгэснээр хөдөлгөөний хөгжлийн |

| | |
|---|---|
| | бэрхшээлгүй болгох боломжтой.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Суралцах бэрхшээлийн тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Оюуны бэрхшээлтэй хавсарсан байж болно.<br>☐ Сонсголын бэрхшээл байх магадлалтай.<br>☐ Танин мэдэхүйн тэнцвэр алдагдсанаас үүсдэг.<br>☐ Мэдэхгүй |

| V | **“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-ний талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахтай холбогдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үнэлгээ хийхэд аль нь чухал вэ?<br>☐ Зориулалтын хэрэглэгдэхүүн ашиглан, хөгжлийн сорил болон оюун ухааны сорилыг мэргэжлийн байгууллага дээр авах.<br>☐ Мэргэжлийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ, оношилгоо хийх.<br>☐ Эцэг/эхийн мэдээлэлд үндэслэн хүүхдийн төлөв байдлыг ажиглан, хүүхдийн талаар олон талаас нь судлах.<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аль нь “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-ний зорилгыг агуулж байна вэ?<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний чанарыг сайжруулах.<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан бүлгээр сургах сургалтын чанарыг сайжруулах.<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан гэрээр сургах сургалтын чанарыг сайжруулах.<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Аль зорилт нь “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахад илүү тохиромжтой вэ?<br>☐ Хичээлийн агуулгаа гүйцэх чадвартай болгохыг урт хугацааны зорилт болгох.<br>☐ Богино хугацааны зорилтыг хангах замаар урт хугацааны зорилтдоо хүрэх байдлаар төлөвлөх.<br>☐ Эцэг/эхийнх нь хамгийн их хүсч буй зүйлийг урт хугацааны зорилт болгох.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах Л.С.Выготскийн “Ойр хөгжлийн бүс (Zone of Proximal Development)”-д хамаатай аргыг тэмдэглэнэ үү?<br>☐ Урт хугацааны зорилтоо тодорхойлох<br>☐ Богино хугацааны зорилтоо тодорхойлох<br>☐ Сургалтын аргаа тодорхойлох<br>☐ Мэдэхгүй |

| VI | Багшлах арга зүйн талаарх ойлголт |
|---|---|
| 1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюуны бэрхшээлтэй хүүхдийг сургахад тохиромжтой аргыг тэмдэглэнэ үү?<br>☐ Авиа зөв дуудах аргыг заах.<br>☐ Зурагт карт ашиглан эд зүйлийн нэрийг заах.<br>☐ Хэл ярианаас ондоо илэрхийллийн арга ашиглах.<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцлийг тэмдэглэнэ үү?<br>☐ Хөтөлбөр, үйлийн дэс дараалльг харахад ойлгогдохоор зураг, фото зургаар үзүүлэх.<br>☐ Өөртөө үйлчлэх дадал, үйл хөдлөл, дохио зангааг үе тэнгийн хүүхдүүдийн дунд нь сургах.<br>☐ Тухайн хүүхдийн дуртай зүйлийг хийлгэн, биеэ барихгүй байдлаар чөлөөтэй байлгах. |

| | |
|---|---|
| | ☐ Мэдэхгүй |
| 3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамааралтай нөхцөлийг тэмдэглэнэ үү?<br>☐ Үсгийн том, жижгийг таних<br>☐ Өнгө таних<br>☐ Хэлбэр дүрс таних<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой вэ?<br>☐ Чанга дуугаар бодит зүйлийг харуулан тоолуулах.<br>☐ Тоонуудыг харахад хялбар байдлаар бичиж өгөн, дэвтэрт нь хуулуулах.<br>☐ Тооны талаар үндсэн ойлголттой байгаа эсэхийг ажиглах.<br>☐ Мэдэхгүй |

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮД

Энэ бүлэгт Баянгол дүүрэг болон Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг хамруулж 2016 оны 3-4 сар (Баянгол дүүрэг), 2017 оны 01 дүгээр сард (Хөвсгөл аймаг) тус тус зохион байгуулсан суурь судалгааны үр дүнг 2018 оны 10 дугаар сард явуулсан эцсийн төлөв байдлын судалгаа үр дүнтэй харьцуулсаныг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 2-1 Харьцуулсан үзүүлэлтүүд*

| Үндсэн бүлэг | Дэд бүлэг | Аргачлал |
|---|---|---|
| Ерөнхий мэдээлэл | • Ажил, үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал | Асуулгын хуудас |
| Ажлын туршлага | • ЭХЭМД-ийг ашиглах арга зүй<br>• Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах<br>• Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа<br>• Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүний тоо | Асуулгын хуудас |
| Мэдлэг, чадвар | • Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт<br>• Мэдлэг, ойлголт (Тест) | Асуулгын хуудас |
| | • (Зөвхөн сургагч багш нар*) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц | Бүлгийн ярилцлага<br>Асуулгын хуудас |

*Төслийн хүрээнд ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулж, Баянгол дүүргээс 6 хүн , Хөвсгөл аймгаас 8 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн.

## 1. Ерөнхий мэдээлэл

### 1-1 Судалгааны зорилтот бүлэг

Судалгаанд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 2-2 Баянгол дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд*

| Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|
| | | ДЭМТ-Хүүхэд, өсвөр үе хариуцсан асуудал хариуцсан ерөнхий зохицуулагч | 1 |
| ДЭМТ-Эмч | 1 | ДЭМТ-Эмч | 1 |
| ӨЭМТ-Төвийн дарга | 6 | ӨЭМТ-Төвийн дарга | 16 |
| ӨЭМТ-Эмч | 17 | ӨЭМТ-Эмч | 8 |
| ӨЭМТ-Сувилагч | 1 | | |
| Хариулаагүй | 1 | | |
| Нийт | 26 | Нийт | 26 |

*Хүснэгт 2-3 Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд*

| Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|
| АЭМГ-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн | 1 | АЭМГ-Тасгын дарга | 1 |
| ӨЭМТ-Эмч | 3 | АЭМГ-Нөхөн үржихүйн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| ӨЭМТ-Нийгмийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн | 2 | АЭМГ-Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн | 1 |
| Сум дундын эмнэлэг-Эмнэлгийн дарга | 5 | АНЭ-Эмч | 1 |
| СЭМТ-Төвийн дарга | 11 | Сум дундын эмнэлэг-Эмнэлгийн дарга | 3 |
| СЭМТ-Эмч | 3 | СЭМТ-Төвийн дарга | 13 |
| СЭМТ-Сувилагч | 3 | СЭМТ-Эмч | 3 |
| Нийт | 28 | Нийт | 23 |

## 1-2 Ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдал

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн ажил үүрэгтэй холбоотойгоор сургалтад хамрагдсан байдлыг График 2-1-д үзүүлэв. Суурь судалгааны үеийнхээс Эцсийн төлөв байдлын судалгаанд "Сургалтад хамрагдсан" гэсэн хариултын тоо нэмэгдсэн байсан.




*График 2-1 Сургалтад хамрагдсан байдал (Баянгол дүүрэг: Суурь судалгаа N=26, Эцсийн төлөв байдлын судалгаа N=26, Хөвсгөл аймаг: Суурь судалгаа: N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

## 2. Ажлын туршлага

## 2-1 ЭХЭМД-ийг ашиглах арга зүйн мэдлэг

Монгол улс бага насны хүүхдийн хөгжил, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ЭХЭМД-ийг нэвтрүүлсэн. ЭХЭМД-ийг зөв зохистой ашигласнаар хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх боломжтой бөгөөд төслийн хүрээнд ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Судалгаагаар ЭХЭМД-ийг хэрхэн ашиглаж байгааг тодруулсныг Хүснэгт 2-4, 2-5-д үзүүлэв.

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн аль алинд ЭХЭМД-ийг идэвхтэй ашиглаж байгаа ба энэ нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэхэд нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

*Хүснэгт 2-4 ЭХЭМД-ийн ашиглалтын байдал (Баянгол дүүрэг) (N=26)*

| Хэрхэн ашиглаж байгаа талаар | Суурь судалгаа* | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ашиглаж байгаа | % | Ашиглаж байгаа | % |
| Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх | | | 26 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ээжийн ойлголт, мэдлэгийг шалгах | | | 26 | 100% |
| Дархлаажуулалт хийсэн эсэхийг шалгах | | | 26 | 100% |
| Хүүхэд тухайн насныхаа хөгжлийн үе шатын дагуу өсч, торниж байгаа эсэхийг шалгах | | | 26 | 100% |
| Хүүхдийн өсөлт, хөгжлийн явцыг шалгах (Өндөр, жин) | | | 26 | 100% |
| Эцэг эх, асран хамгаалагч нар хөх хуудсыг бөглөсөн эсэхийг шалгах (Хөгжлийн явцыг тэмдэглэх хуудас) | | | 26 | 100% |
| Бусад | | | 6 | 23% |

* Суурь судалгааны үед ЭХЭМД ашиглалтыг сайжруулах ажлыг төлөвлөөгүй байсан учир судалгааны үзүүлэлтэд багтаагүй.

*Хүснэгт 2-5 ЭХЭМД-ийн ашиглалтын байдал (Хөвсгөл аймаг)*

*(Суурь судалгаа N＝28, Эцсийн төлөв байдлын судалгаа N＝23)*

| Хэрхэн ашиглаж байгаа талаар | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ашиглаж байгаа | % | Ашиглаж байгаа | Ашиглаж байгаа |
| Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх | 25 | 89.29% | 22 | 96.65% |
| Ээжийн ойлголт, мэдлэгийг шалгах | 26 | 92.86% | 19 | 82.61% |
| Дархлаажуулалт хийсэн эсэхийг шалгах | 28 | 100% | 22 | 96.65% |
| Хүүхэд тухайн насныхаа хөгжлийн үе шатын дагуу өсч, торниж байгаа эсэхийг шалгах | 28 | 100% | 21 | 91.3% |
| Хүүхдийн өсөлт, хөгжлийн явцыг шалгах (Өндөр, жин) | 27 | 96.43% | 21 | 91.3% |
| Эцэг эх, асран хамгаалагч нар хөх хуудсыг бөглөсөн эсэхийг шалгах (Хөгжлийн явцыг тэмдэглэх хуудас) | 27 | 96.43% | 19 | 82.65% |
| Бусад | 8 | 28.57% | 5 | 21.74% |

## 2-2 Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах

Төслийн дэмжлэгтэйгээр Баянгол дүүрэгт 2017 оын 05 дугаар сард 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулж эхэлсэн. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт үед илрүүлж, шаардлагатай дэмжлэгт холбох нь энэхүү ажлын нэг зорилго юм. 2017 оноос хойш эцсийн төлөв байдлын судалгаа (2018.10) хүртэл сард 1 удаа буюу нийт 17 удаа үзлэгийг тогтмол зохион байгуулаад байна. Хөвсгөл аймагт 2017 оны 10 дугаар сард эхэлж, эцсийн төлөв байдлын судалгаа хүртэл нийт 12 удаа тус үзлэгийг зохион байгуулж байна. Эцсийн төлөв байдлын судалгаагаар 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг хийж байгаа эсэх, хэрэв тийм бол хэдэн удаа үзлэг хийсэн талаар асууж тодруулсныг доорх хүснэгтэд тэмдэглэв.

Судалгаагаар Баянгол дүүргийн эмч нарын 90-ээс дээш, Хөвсгөл аймгийн эмч нарын 70-аас хувь нь 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийж байгаа нь тогтоогдов.




*График 2-2 Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах (N=49)*

## 2-3 Холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа

Хамтарч ажилласан байгууллагууд болон хийсэн ямар чиглэлээр ажилласан талаарх мэдээллийг доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Баянгол дүүргийн тухайд суурь судалгаанд "Цэцэрлэгтэй хамтарч ажилладаг" гэж 1 эмч хариулж байсан бол эцсийн төлөв байдлын судалгаанд энэ хариултын тоо 10 болж өссөн байна. Суурь судалгааны үед ердийн сургуультай хамтарч ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд байхгүй байсан бол эцсийн төлөв байдлын судалгаанд 8 хүн "Ердийн сургуультай хамтран ажиллаж байна" гэж хариулсан. Хамтарч хийсэн үйл ажиллгаануудын тухайд "18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг", "Салбар комиссын ээлжит хуралдаан", "Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр" зэрэг төслийн хүрээнд нэвтрүүлсэн үйл ажиллагааг дурдсан.

*Хүснэгт 2-6 Хамтарч ажилласан байгууллага, ажлын агуулга (Баянгол дүүрэг) (N=26)*

| Хамтарч ажилласан байгууллагууд | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ажлын агуулга | Хариултын тоо | Ажлын агуулга | Хариултын тоо |
| Дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс | • Судалгаа хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик гаргасан.<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцсон.<br>• Бүртгэл<br>• Асрах үйлчилгээ үзүүлсэн | 6/26 | • 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцох<br>• Асуудал шийдвэрлэх | 13/26 |
| Дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой судалгаа хийсэн.<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулж сургалт хийсэн.<br>• Асуудал шийдвэрлэсэн.<br>• Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн. | 6/26 | • Салбар комиссын ээлжит хуралдаан зохион байгуулах<br>• Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцох<br>• Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Амьжиргаа дэмжих | 20/26 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дүүргийн Боловсролын хэлтэс | • Сургалт хийж, мэдээлэл солилцсон.<br>• Үйлчилгээ авах нөхцөл, боломжийг сайжруулсан. | 1/26 | • Сургуульд хамрагдахад дэмжлэг үзүүлэх | 2/26 |
| Цэцэрлэг | • Цэцэрлэгт хамрагдахад дэмжлэг үзүүлсэн. | 1/26 | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах | 10/26 |
| Сургууль | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулсан. | 4/26 | — | 4/26 |
| Ердийн сургууль | — | 0/26 | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах | 8/26 |
| Дүүргийн хөдөлмөрийн хэлтэс | — | 0/26 | | 3/26 |
| Хорооны нийгмийн ажилтан | • Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлсэн.<br>• Гэрээр эргэлт хийж уулзсан.<br>• Бүртгэл<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцсон.<br>• Судалгаа хийсэн. | 13/26 | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Асаргаа, сувилгааны байгууллага, төвүүдийг ашиглах<br>• Асуудал шийдвэрлэх | 19/26 |
| Бусад | • ТББ-уудтай хамтарч, витаминжуулсан.<br>• Хувийн эмнэлэгүүдтэй хамтарч үзлэг хийсэн. | 6/26 | • ТББ-уудтай хамтарч ажиллах | 1/26 |

Нөгөөтэйгүүр Эцсийн төлөв байдлын судалгаанд өгсөн Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хариултаас үзэхэд суурь судалгаанаас хойш аймгийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран хийх ажлын төлөвлөгөө боловсруулах болон аймгийн БСУГ-тай хамтран сургалт зохион байгуулдаг болсныг тодруулсан. Түүнчлэн цэцэрлэг, ердийн сургуультай хамтарч ажилласнаар сургуульд хамрагдахад үзүүлэх дэмжлэг, сурах орчин нөхцөл сайжирсан байна.

*Хүснэгт 2-7 Хамтарч ажилласан байгууллага, ажлын агуулга (Хөвсгөл аймаг)*
*(Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

| Хамтарч ажилласан байгууллагууд | Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|
| | Ажлын агуулга | Хариултын тоо | Ажлын агуулга | Ажлын агуулга |
| Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой судалгаа хийсэн.<br>• Мэдээлэл солилцсон. | 9/28 | • Хамтран хийх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцох<br>• Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх | 8/23 |
| Аймгийн Нийгмийн халамжийн газар | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн.<br>• Аян зохион байгуулсан. | 16/28 | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Зөвлөгөө өгөх | 10/23 |
| Аймгийн БСУГ | • Боловсролын сэргээн засах үйлчилгээ үзүүлсэн.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой судалгаа хийсэн.<br>• Сумын соёлын төвтэй хамтарч хандивын тоглолт | 5/28 | • Хөгжлийн дэмжлэг үзүүлэх<br>• Сургалт зохион байгуулах (Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал-ICF | 4/23 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохион байгуулсан. | | зэрэг) | |
| Цэцэрлэг | • Цэцэрлэгт хамрагдахад дэмжлэг үзүүлсэн.<br>• Хандивын тогтолт зохион байгуулсан. | 9/28 | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах<br>• Хөгжлийн дэмжлэг үзүүлж, цэцэрлэгт хамрагдалтыг дэмжих<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх<br>• Сургалт хийж, мэдээлэл солилцох | 13/23 |
| Сургууль | — | 2/28 | • Сургалт зохион байгуулах | 1/23 |
| Ердийн сургууль | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулсан.<br>• Осол гэмтэл болон бэлгийн замын өвчнөөс сэргийлэх тоглоомт үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>• Бие бялдар хөгжүүлэх тоног төхөөрөмжөөр хангасан. | 20/28 | • Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах<br>• Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх<br>• Сургуульд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, сурах таатай орчин нөхцөл бүрдүүлэх<br>• Сургалт зохион байгуулах | 6/23 |
| Аймгийн Хөдөлмөрийн газар | • Зөвлөгөө өгсөн. | 3/28 | — | 2/23 |
| Аймгийн НЭ | • Тодорхойлолт гаргасан.<br>• Семинар зохион байгуулсан.<br>• Сурталчилж, мэдээллэсэн.<br>• Судалгаа явуулж “1 сувилагч 1 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд” аян хэрэгжүүлсэн. | 13/28 | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Өрхийн амьжиргааны судалгаа хийх<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх<br>• Асуудал шийдвэрлэх | 7/23 |
| Багийн (Сум) нийгмийн ажилтан | • ЭМГ-тай хамтарч ажилласан.<br>• Дэлхийн зөн ОУБ-тай хамтарч ажилласан. | 3/28 | • ЭМГ-тай хамтарч ажиллах | 1/23 |

## 2-4 Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагаа

Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагааг үнэлэх зорилготой “Комиссын талаар мэдэх үү”, “Салбар комиссын талаар мэдэх үү” гэсэн асуултын хариултыг График 2-3, 2-4-т үзүүлэв. Суурь судалгааны үетэй харьцуулахад эцсийн төлөв байдлын судалгаанд Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн аль аль нь комисс болон Салбар комиссын талаар мэддэг болж, “Хамтарч ажилладаг” гэсэн хариултын тоо өссөн үзүүлэлттэй байна.




*График 2-3“Комиссын талаар мэдэх үү” асуултын хариулт (Баянгол дүүрэг: Суурь судалгаа N=26, Эцсийн төлөв байдлын судалгаа N=26, Хөвсгөл аймаг: Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*




*График 2-4 “Салбар комиссын талаар мэдэх үү” асуултын хариулт (Баянгол дүүрэг: Суурь судалгаа N=26, Эцсийн төлөв байдлын судалгаа N=26, Хөвсгөл аймаг: Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

"Комиссын ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ", "Салбар комиссын ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ" гэсэн асуултад өгсөн хариултыг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 2-8 "Комиссын ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ" асуултын хариулт (Суурь судалгаа N=54, Эцсийн төлөв байдлын судалгаа N=49)*

| Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|
| Комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт | |
| • Бүх хүүхдийн амьдралын түвшин, эмчилгээнд анхаарч эрүүл чийрэг болгоход төвлөрч ажиллах шаардлагатай<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олон нийтийн үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх шаалдлагатай<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэхэд анхаарах хэрэгтэй<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, бие даах чадварыг дээшлүүлэх шаардлагатай | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх (3)<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжин туслах үйл ажиллагааг идэвхжүүлэх<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадварыг хөгжүүлэхийг зорьж ажиллах<br>• Нийгмийн асуудлыг шийдэх |
| Салбар комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт | |
| • Үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл түгээх (4)<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн талаар мэдээллээр хангах (2)<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нарыг дэмжих шаардлагатай (2)<br>• АЭМГ-тай нягт уялдаатай ажиллах шаардлагатай<br>• Сургалтууд зохион байгуулах | • Ээлжит хуралдааны зохион байгуулалтыг сайжруулахад анхаарах (Бэлтгэл, ХБХ-ийн эцэг эх, асран хамгаалагчид санаа тавих, цагийн зохицуулалт, асуудлыг шийдэх) (6)<br>• Эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх, тэдний оролцоог нэмэгдүүлэх (3)<br>• Салбар комиссуудад заавар зөвлөгөө өгөх (2)<br>• Шаардлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэх<br>• Холбогдох хууль, дүрмийг үзүүлэх |
| Цаашид шинээр хийж өгөхийг хүсч буй ажлууд | |
| • Алслагдсан бүс нутагт ч үйл ажиллагааг хэрэгжүүлэх<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нэн ялангуяа төв мэдрэлийн саажилттай хүүхдэд сэргээн засах эмчилгээг хөдөө орон нутагт ч хийх<br>• Суманд сэтгэл зүйч, зөвлөгөө өгөх төв байгуулах<br>• Нийгмийн халамжийн тэтгэмжийг нэмэх | • Тусгай цэцэрлэг байгуулах |

*Хаалтан дотор хариултын тоог тэмдэглэв.

*Хүснэгт 2-9 "Салбар комиссын ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ" асуултын хариулт (Суурь судалгаа N=54, Эцсийн төлөв байдлын судалгаа N=49)*

| Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|
| Комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт | |
| • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах<br>• Бүх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх | • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх<br>• Нийгмийн асуудлыг шийдэх<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах |
| Салбар комиссын ажил үүрэгтэй холбоотой хүлээлт | |

| | |
|---|---|
| • Сайн мэдэхгүй учраас мэдээллээр хангаж байх (3)<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн ерөнхий асуудлыг хариуцаж шийдэх мэргэжилтнийг аймгийн засаг даргын тамгын газрын мэргэжилтнээр ажиллуулах<br>• Сумдад амьдардаг хүүхдүүдэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, асуудлыг шийдэх<br>• Уялдаа холбоогоо бэхжүүлэх | • Ээлжит хуралдааны зохион байгуулалтыг сайжруулах (Цагийн зохицуулалт, эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх, асуудлыг шийдэх)<br>• Хүүхдийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийн явцад хяналт тавих<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах<br>• Орон нутагт үйл ажиллагаагаа тайлагнах<br>• Салбар комиссын гишүүнээр удаан хугацаагаар тогтвортой ажиллах<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар бүрэн дүүрэн мэдлэг, ойлголттой болох<br>• ӨЭМТ-тэй нягт хамтран ажиллах |
| Цаашид шинээр хийж өгөхийг хүсч буй ажлууд | |
| | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, сувилгаа хийх мэргэжилтэн, нарийн мэргэжлийн эмч наын тоог нэмэх |

*Хаалтан дотор хариултын тоог тэмдэглэв.

### 2-6 Туршлага судлахаар ирсэн хүний тоо

Төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнө болон дараа туршлага судлахаар ирсэн хүний тоог харьцуулан үзэв. Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн аль алинд төсөл хэрэгжиж эхлэснээс хойш туршлага судлахаар ирсэн хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 2-10 Туршлага судлахаар ирсэн хүний тоо*

| | 2014-2015 он | 2017-2018 он | Өсөлт |
|---|---|---|---|
| Баянгол дүүрэг эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд | 18 | 35 | 1.94 |
| Хөвсгөл аймаг эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд | 60 | 185 | 3.08 |

## 3. Мэдлэг чадвар

### 3-1 Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг үнэлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлийн тухай асуусан бөгөөд өгсөн хариултуудыг "Бие эрхтний үйл ажиллагаа", "Дэмжлэг шаардлагатай", "Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал", "Орчны саад тотгор" гэж ангилав.

Баянгол дүүргийн тухайд суурь судалгаанд хариулсан хүний 77% нь зөвхөн бие эрхтний үйл ажиллагааг онцолж байсан бол эцсийн төлөв байдлын судалгаанд 50% болон буурч, үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон хариулт нэмэгдсэн байна. Мөн 1 хүн орчны саад тотгортой холбоотой хариулт өгсөн.

*Хүснэгт 2-11 Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт (Баянгол дүүрэг) (N=26)*

| Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|
| Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 20 | Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 13 |
| Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 2 | Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 2 |
| Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 2 | Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 6 |
| Орчны саад тотгорыг онцолсон | 0 | Орчны саад тотгорыг онцолсон | 1 |
| Бусад* | 2 | Хариулаагүй | 4 |

* Бусад гэдэгт "Мэдэхгүй", "Ердийн хүмүүсээс өөр бүлэгт хамаардаг" гэх зэрэг хариултууд байсан.

Харин Хөвсгөл аймагт асуумжид хариулт өгсөн хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн талаарх үзэл бодол нь төслийн эхний төлөв байдлын судалгааны үеийнхээс өөрчлөгдөөгүй бөгөөд эрүүл мэндийн загварт суурилсан хэвээр байсан.

*Хүснэгт 2-12 Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт (Хөвсгөл аймаг) (Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

| Суурь судалгаа | | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|
| Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 16 | Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 17 |
| Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 0 | Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 0 |
| Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 6 | Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 0 |
| Орчны саад тотгорыг онцолсон | 0 | Орчны саад тотгорыг онцолсон | 0 |
| Хариулаагүй | 6 | Хариулаагүй | 6 |

## 3-2 Мэдлэг, ойлголт

Баянгол дүүрэг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн "Хөгжлийн бэрхшээл"-ийн талаарх мэдлэг, ойлголтыг 6 үндсэн сэдвийн 22 асуулттай тестээр шалгасан ба асуулт тус бүрийн зөв хариултын тоог Хүснэгт 2-13, 2-14-т үзүүлэв.

*Хүснэшт 2-13 "Хөгжлийн бэрхшээл"-ийн талаарх мэдлэг, ойлголт тест (Баянгол дүүрэг) (N=26)*

| № | Асуулт | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|---|---|
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | **30.77%** | **28.85%** |
| 1.1 | НҮБ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал"-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ? | 4/26 | 9/26 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, "Бие махбодын | 12/26 | 6/26 |

| | | | |
|---|---|---|---|
| | бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл", "Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал"-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | | |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | **53.85%** | **46.15%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 17/26 | 20/26 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ? | 13/26 | 3/26 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 12/26 | 17/26 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 14/26 | 8/26 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | **48.08%** | **51.92%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 21/26 | 19/26 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 6/26 | 6/26 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 12/26 | 12/26 |
| 3.4 | Бага насны мэдрэхүйн хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 11/26 | 17/26 |
| **4** | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | **42.31%** | **28.85%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 17/26 | 7/26 |
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 12/26 | 16/26 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 8/26 | 5/26 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 7/26 | 2/26 |
| **5** | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | **29.81%** | **25.96%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 7/26 | 5/26 |
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ? | 7/26 | 7/26 |
| 5.3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)" боловсруулахад илүү тохиромжтой вэ? | 12/26 | 11/26 |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн "Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)" онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 5/26 | 4/26 |
| **6** | **Багшлах арга зүйн талаарх ойлголт** | **27.88%** | **27.88%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 10/26 | 5/26 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 5/26 | 1/26 |
| 6.3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 11/26 | 14/26 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 3/26 | 9/26 |

Баянгол дүүрэгт "Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг" сэдвийн тестийн зөв хариултын дундаж үзүүлэлт суурь судалгааны үеийнхээс багагүй ахисан ч бусад сэдвийн тестийн дүн нэг их өөрчлөгдөөгүй, эсвэл буурсан байна.




*График 2-5 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт тестийн сэдэв тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Баянгол дүүрэг) (N=26)*

*Хүснэгт 2-14 "Хөгжлийн бэрхшээл"-ийн талаарх мэдлэг, ойлголт тест (Хөвсгөл аймаг) (Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

| № | Асуулт | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа |
|---|---|---|---|
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | **39.29%** | **21.74%** |
| 1.1 | НҮБ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал"-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ? | 10/28 | 4/23 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, "Бие махбодын бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл", "Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал"-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | 12/28 | 6/23 |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | **50.00%** | **41.30%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 19/28 | 14/23 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ? | 14/28 | 0/23 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 12/28 | 14/23 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 11/28 | 10/23 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | **49.11%** | **57.61%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 18/28 | 18/23 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 8/28 | 6/23 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 16/28 | 16/23 |
| 3.4 | Бага насны мэдрэхүйн хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 13/28 | 13/23 |
| **4** | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | **19.64%** | **30.43%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 5/28 | 7/23 |
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 8/28 | 16/23 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 6/28 | 1/23 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 3/28 | 4/23 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | **26.79%** | **28.26%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 11/28 | 8/23 |
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ? | 5/28 | 4/23 |
| 5.3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)" боловсруулахад илүү тохиромжтой вэ? | 9/28 | 12/23 |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн "Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)" онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 5/28 | 2/23 |
| **6** | **Багшлах арга зүйн талаарх ойлголт** | **25.89%** | **21.74%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 12/28 | 6/23 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 5/28 | 3/23 |
| 6.3 | Хараану мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 5/28 | 7/23 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 7/28 | 4/23 |

Хөвсгөл аймагт "Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг" болон "Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт" сэдвийн тестийн зөв хариултын дундаж үзүүлэлт 10%-аар өссөн.




*График 2-6 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт тестийн сэдэв тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Хөвсгөл аймаг)*
*(Суурь судалгаа N=28, Эцсийн төлөв байдлын судалгаа N=23)*

## 4. (Зөвхөн сургагч багш нар) Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтийг дэмжих зорилгоор ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ирсэн. Туршилтын аймаг, дүүрэгт гол чиглүүлэгч болох сургагч багшийг бэлтгэх зорилгоор 2018 оны 02 дугаар сард 3 өдрийн сургалт зохион байгуулсан ба сургалтад Баянгол дүүрэг, Хөвсгөл аймагт удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэдэг эрүүл мэндийн байгууллагын 14 эмч, мэргэжилтнүүд оролцсон. эцсийн төлөв байдлын судалгаагаар энэхүү сургалтын сүүлийн өдөр боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг тандсан.

## 4-1 Баянгол дүүргийн эрүүл мэндийн байгууллагын 3 эмч, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага (2018.11.02)

Сургалтад оролцогчдын боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжилтийн явцыг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 2-15 Үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц (Баянгол дүүрэг) (N＝3)*

| Үйл ажиллагааны төлөвлөгөө | Хэрэгжилтийн явц |
|---|---|
| 1. Баянгол дүүргийн 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг чанарыг сайжруулах | Хариулагч 1, 2: Төлөвлөгөө боловсруулж, хуваарийн дагуу сургалтуудаа хийсэн.<br>Хариулагч 3: 2018 оны 09 дүгээр сар хүртэлх үзлэгийн хамруулалтын дундаж үзүүлэлт 84% байна. |
| 2. Сургагч багш нар ӨЭМТ-үүдэд бүсчилсэн сургалт зохион байгуулах (14 бүсд хуваах) | Хариулагч 1, 2: Өөрсдийн ажилладаг төв дээр 1 удаа сургалт зохион байгуулсан.<br>Хариултагч 3: 5 дугаар сард шинээр ажилд орсон 22 эмчид эрүүл мэндийн үзлэгийн талаар сургалт зохион байгуулсан. |
| 3. ЭХЭМД-ийн ашиглалт, хөтлөлтөөр ӨЭМТ-үүдэд бүсчилсэн тандалт судалгаа хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | Хариулагч 1, 2: 4, 8 дугаар сард хийсэн хяналтаар илэрсэн асуудалд зөвлөгөө өгсөн.<br>Хариулагч 3:Хэвтэн эмчлүүлж буй 50 хүүхдийн ЭХЭМД-ийн ашиглалт, хөтлөлтийг шалгасан. |
| 4. ЭХЭМД-ийн хөтлөлтийг сайжруулах (ӨЭМТ-үүдийн хооронд аян зохион байгуулах удирдамж боловсруулах, дотоодын сургалтуудыг зохион байгуулах) | Хариулагч 1, 2: Улирал тутамд төвдөө сургалт зохион байгуулж байгаа.<br>Хариулагч 3: 2018 оын 12 дугаар сард ЭХЭМД-ийн ашиглалтад хяналт хийж, сургалт зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. |
| 5. 7 хоног бүр ЭХЭМТ-ийн ээжүүдийн бөглөх хэсгийг яаж ашиглах талаар ӨЭМТ-д өөрсдийн зорилтот хэсэгт сургалт явуулах, мөн хуваарийн дагуу нэгдсэн сургалт сурталчилгаа явуулах (Сургагч багш нар хянах) | Хариулагч 1: 11 дүгээр сард сургалт зохион байгуулж, 12 дугаар сард тайлан нэгтгэнэ.<br>Хариулагч 2: 11 дүгээр сард сургалт зохион байгуулж, 12 дугаар сарын эхээр тайлан нэгтгэнэ.<br>Хариулагч 3: Хариулаагүй |
| 6. 18 сартай хүүхдийн цогц үзлэгийн явцыг хянах, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах | Хариулагч 1, 2 : 11 дүгээр сард эрүүл мэндийн үзлэгийн явцыг тодруулж, эмнэлэгтээхэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулна.<br>Хариулагч 3: Эрүүл мэндийн явцыг сар бүр хяналт хийж, ДЭМТ-д тайлагнана. |
| 7. Үзлэгээр илэрсэн хүүхдийг “Эх хүүхдийн хөтөлбөр”-т хэрхэн хамруулах талаар өдөрлөг зохион байгуулах | Хариулагч 1, 2: Үзлэгээр илэрсэн 1 хүүхэд 8 дугаар хороонд хэрэгждэг “Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-т хамрагдаж байгаа.<br>Хариулагч 3: Хариулаагүй. |

Сургагч багшаар бэлтгэгдсэний дараа ямар ахиц, өөрчлөлт гарсан талаар асууж тодруулав. “Хамт ажилладаг эмч нартаа зөвлөгөө өгдөг болсон” зэрэг хариултаас үзэхэд сургалтаар олж авсан мэдлэгээ хэрэгжүүлэн ажиллая гэсэн хандлагатай байгаа нь харагдлаа.

*Хүснэгт 2-16 ЭХЭМД-ийн сургагч багш бэлтгэх сургалтын оролцогчдод гарсан өөрчлөлт (Баянгол дүүрэг) (N=3)*

| Асуулт | Хариулт |
|---|---|
| 1. Сургагч багшийн сургалтад хамрагдсанаар таны ажилд ямар өөрчлөлт гарсан бэ? | Хариулагч 1, 2: Мэдлэг, чадвараа дээшлүүлж, судалгаа, үнэлгээ хийж чаддаг болсон.<br>Хариулагч 3: Ажлын хамт олондоо зөвлөгөө өгдөг болсон. |
| 2. Та болон таны хамт олон цаашид ямар талын мэдлэг, чадвараа дээшлүүлэх шаардлагатай байгаа вэ? | **<u>Хариулагчийн тухай</u>**<br>Хариулагч 1, 2: Өөрийгөө илүү чадваржуулахыг зорьж, бусаддаа үлгэр дуурайлал үзүүлж ажиллах<br>Хариулагч 3: Хариулаагүй. |
| | **<u>Хамт олны тухай</u>**<br>Хариулагч 1: ЭХЭМД-ийн тухай тогтмол хэлэлцэж байх<br>Хариулагч 2: ЭХЭМД-ийн талаар зөв ойлголттой болох<br>Хариулагч 3: Хамт олондоо ерөнхий агуулгын талаар сургалт явуулах |

## 4-2 Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагын 5 эмч, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага болон асуумжийн хуудсаар авсан судалгаа (2018.11.01-02)

Эдгээр эмч, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага болон асуулгын хуудас дахь хариултуудаас ЭХЭМД-ийн ашиглалтыг сайжруулахаар идэвх, санаачлагатай ажиллаж байгаа болох нь харагдсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан нөлөөллийн үйл ажиллагааг ч идэвхтэй зохион байгуулж байна.

*Хүснэгт 2-17 2-15 Үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц (Хөвсгөл аймаг) (N=5)*

| Үйл ажиллагааны төлөвлөгөө | | Хэрэгжилтийн явц |
|---|---|---|
| 1. Сургалтын дараах төлөвлөгөө хийх | 2018.03.15 | • Сургалтын төлөвлөгөөг 2018 оын 03 дугаар сарын 29-ний өдөр ЭМГ-ын даргын тушаалаар батлуулсан. Сургалт нь 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах арга зүй, үнэлгээний арачлал, эцэг эх, асран хамгаалагчийн ЭХЭМД хөтлөх арга гэсэн агуулгатай.<br>• 8 хүн дээр нэмж АНЭ, ӨЭМТ-ийн эмч нар сургагч багш болж эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг 3-7 дугаар сард зохион байгуулсан.<br>• Жилийн эцсийн тайлангийн хурал зохион байгуулна. |
| 2. График гаргах (Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах) | 2018.03.15 | Тусгасан. |
| 3. Ягаан дэвтрийн тандалт судалгаа хийх<br>- Энх үйлс ӨЭМТ<br>- Их уул сум дундын эмнэлэг<br>- Рэнчинлхүмбэ СЭМТ<br>- АНЭ | 2018.033 сард эхлэнэ Цаашдаа улирал бүр хийнэ | Төлөвлөгөөнд оруулсан 4 эмнэлгээс гадна бүх сумдад судалгаа хийсэн. |
| 4. Ягаан дэвтрийн сургалт хийх<br>5. ЭМБ-д<br>6. Эцэг эхчүүдэд | Жилийн турш | 23 суманд нийт 350 эрүүл мэндийн ажилтан, 400 эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалт хийсэн. |

| | | |
|---|---|---|
| 7. Хэвлэл мэдээллээр ухуулан сурталчилах арга хэмжээ авах.<br>8. ТВ 7 хоног бүр цувралаар гаргах<br>9. Сард 1 удаа сонинд хэвлүүлэх | 2018.03 сараас эхлэн жилийн турш | • Сард 1 удаа орон нутгийн 2 телевизээр (Мөрөн Лха, Далай Ээж) мэдээлэл түгээсэн.<br>• ЭМГ-ын сонинг жилийн эцэст үнэгүй тараадаг.<br>• Далай-Ээж сонинд мэдээлэл нийтлэсэн. |
| 10. Дотоод сургалт хийх<br>11. Жишээ нь: Тасаг дээр 7 хоног бүрийн 5 дахь өдөр 1 цаг эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх | Тогтмол хийнэ | • АНЭ-ийн хүүхдийн эмч, эх барих эмч нарт сургалт явуулсан.<br>• Мягмар гариг бүр жирэмсэн эхчүүдэд ЭХЭМД хөтлөлтийн талаар заасан. (Нийт 105 хүн)<br>• Баасан гариг бүр Хүүхдийн тасагт мэдээлэл түгээсэн. (Нийт 28 удаа, 250 хүн)<br>• Сард 1 удаа хоол, шим тэжээлийн талаар сургалт хийсэн.<br>• 5 дугаар цэцэрлэгээр айлчилж сургалт, үзлэг хийсэн.<br>• Нийт 9 суманд 450 хүнийг хамруулсан сургалт зохион байгуулсан. |
| 12. Хөгжлийн үе шатыг харуулсан зурагт хуудас хийх | _ | Зурагт хуудас хийх талаар 11 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцэнэ. |

Сургагч багшаар бэлтгэгдсэний дараа ямар ахиц, өөрчлөлт гарсан талаар асууж тодруулав. Дээрх хүснэгтэд үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон давхардсан хариултыг нэгтгэж үзүүлэв. Үүнээс харахад хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх тухай гүнзгий мэдлэгтэй болсон бөгөөд 8 сургагч багш 1 баг болж сайн ажиллаж байгаа нь харагдаж байна.

*Хүснэгт 2-18 ЭХЭМД-ийн сургагч багш бэлтгэх сургалтын оролцогчдод гарсан өөрчлөлт (Хөвсгөл аймаг) (N=5)*

| Асуулт | Хариулт |
|---|---|
| **1.** Сургагч багшийн сургалтад хамрагдсанаар таны ажилд ямар өөрчлөлт гарсан бэ? | • Сургалтад хамрагдахын өмнө ЭХЭМД-ийг хэрхэн ашиглах талаар бүрэн мэдлэггүй байсан. Тус сургалтаар дамжуулж их зүйл сурч авсан. Өрхийн эмч нарт зориулан сургалт хийж байгаа.<br>• Сургагч багш нар баг болж ажиллаж байгаа.<br>• Сар бүр Салбар комиссын ээлжит хуралдаанд оролцож, эцэг эх, асран хамгаалагч нарыг хүлээж байх хугацаанд сургалт хийсэн.<br>• 8 сургагч багш нар олон газар мэдээлэл түгээж байхаар болсон.<br>• Эцэг эх, асран хамгаалагч болон эмч нарыг магтаж, урам өгдөг болсон.<br>• Эрт илрүүлэг, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилсэн. |
| 2. Та болон таны хамт олон цаашид ямар талын мэдлэг, чадвараа дээшлүүлэх шаардлагатай байгаа вэ? | **<u>Хариулагчийн тухай</u>**<br>• Эцэг эх, асран хамгаалагч нар олон төлийн зөвлөгөө авахыг хүсдэг учир хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, заах арга зүйд суралцана гэж бодож байгаа.<br>• Судалгааны үр дүнг нэгтгэх арга, эрүүл мэндийн үзлэгт дэмжлэгт хяналт хийх талаарх мэдлэг, чадвараа ахиулах |
| | **<u>Хамт олны тухай</u>**<br>• Сумын эмч, сувилагч нар их шилжиж, ажлаа сольдог тул шинээр орсон хүмүүст эрүүл мэндийн үзлэг хийх талаар заах шаардлагатай.<br>• Эцэг эх, асран хамгаалагч нарын хүүхэд өсгөх мэдлэгийг сайжруулах |

## 5. АСУУЛГЫН ХУУДАС

### ЭМБ БА БУСАД БАЙГУУЛЛАГА

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага- (JICA)-ийн "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах" төсөл нь 2015 оны 8-р сараас хэрэгжиж эхэлсэн. Төслийн үйл ажиллагаа явуулах туршилтын тойргийн хувьд Нийслэл болоод Хөвсгөл аймгийг сонгосон болно.

Тус төслийн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаар нэгтгэн дүгнэх зорилготойгоор эцсийн шатны судалгаа /endline survey /-г зохион байгуулж байна.

Та нэрээ заавал бичнэ үү! Судалгааны мэдээллийг зөвхөн төслийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд, судалгаанд оролцогчдын нэр болон хувийн мэдээллийг нууцлах болно.

*Энэхүү судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд заасан албан ёсны тодорхойлолтыг ойлгоно.

Он сар өдөр: ..............................................

Судалгаанд оролцогчийн нэр:...................

Мэдээлэл цуглуулагч: ...............................

**1. Ерөнхий мэдээлэл**

| № | Асуулт | Хариулт |
|---|---|---|
| 1.1 | Байгууллагын нэр | |
| 1.2 | Таны албан тушаал | |
| 1.3 | ХБХ-тэй ажиллахад та ямар үүрэгтэй вэ? | |

**2. Мэдлэг, чадвар**

| № | Асуулт | Хариулт |
|---|---|---|
| 2.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх сургалтад сууж байсан уу?<br>(хэдэн ч хариулт байж болно) | □ Огт үгүй<br>□ Богино хугацааны сургалтад хамрагдсан (1 долоо хоногоос бага )<br>□ Тийм, дунд хугацааны сургалтад (хэдэн долоо хоног, 6 сар хүртэлх )<br>□ Тийм, ХБХ-тэй хамаатай коллежийн хичээлд (Жишээлбэл, МУБИС-ийн 1 жилийн анги г.м) |
| 2.2 | Өмнөх сард ХБХ-ийн хэдэн тохиолдолтой ажилласан бэ? /хэдэн хүүхэд/ | .........тохиолдол |
| 2.3 | Та "Хөгжлийн бэрхшээл" гэдэг үгийг нэг хоёр өгүүлбэрээр тайлбарлана уу? | |
| 2.4 | Та Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр /цаашид ЭХЭМД гэх/-ийг | □ ЭХЭМД-ийг ашиглан эцэг эхэд нь зөвлөгөө өгдөг<br>□ Эцэг эхийн мэдлэгийг шалгадаг<br>□ Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн эсэхийг |

| | | |
|---|---|---|
| | хэрхэн ашигладаг вэ?<br><br>(хэдэн ч хариулт сонгож болно) | шалгадаг<br>□ Хүүхдийн хөгжил насны дагуу явагдаж байгаа эсэхийг шалгадаг<br>□ Хүүхдийн өсөлт/ өндөр, биеийн жин/-ийн байдлыг шалгадаг<br>□ Эцэг эх цэнхэр хуудсыг бөглөж байгаа эсэх<br>□ Бусад（ ）<br>□ Хэрэглэдэггүй. Миний ажилтай хамаагүй |
| 2.5 | 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг хийдэг үү? | ☐ Тийм<br>Хэрэв тийм гэж хариулсан бол хэдэн удаа?<br>....... удаа<br>☐ Үгүй |

**3. Бусад байгууллагатай харилцах**

| № | Асуулт | Хариулт | |
|---|---|---|---|
| | 2018 оны 3 сараас ХБХ-ийн асуудлаар бусад байгууллагуудтай ажилласан уу?<br>(хэд хэдэн хариулт өгч болно) | Байгууллага | Хэрхэн ажилласан тухай |
| 3.1 | | □ Аймаг/дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс | |
| | | □Аймаг/дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс | |
| | | □ Аймаг/дүүргийн боловсрол,соёл, урлагийн газар | |
| | | □ Хүүхдийн цэцэрлэг | |
| | | □ Тусгай сургууль | |
| | | □ Ердийн сургууль | |
| | | □ Аймаг/дүүргийн хөдөлмөрийн хэлтэс | |
| | | □ Аймаг/дүүргийн нэгдсэн эмнэлэг | |
| | | □ Баг, хорооны нийгмийн ажилтан | |
| | | □ Өрхийн эмч | |
| | | □ Бусад | |
| 3.2 | ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын **Комиссын** талаар мэдэх үү? | □ Үгүй, комиссын талаар мэдэхгүй<br>□ Тийм, комиссын талаар сонссон<br>□ Тийм, комиссын чиг үүрэг болон гишүүдийг нь мэднэ<br>□ Тийм, комисстой холбоо барьсан удаа бий | |
| 3.3 | **(Хэрэв 3.2-т тийм гэж хариулсан бол) комиссын** | | |

| | | | |
|---|---|---|---|
| | ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ? | | |
| 3.4 | ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын **Салбар комиссын** талаар мэдэх үү? | □ Үгүй, салбар комиссын талаар мэдэхгүй<br>□ Тийм, салбар комиссын талаар сонссон<br>□ Тийм, салбар комиссын чиг үүрэг болон гишүүдийг нь мэднэ<br>□ Тийм, салбар комисстой хамтран ажилласан удаа бий | |
| 3.5 | (Хэрэв 3.4-т тийм гэж хариулсан бол) Салбар **комиссын** ажил үүрэгтэй холбоотой таны хүлээлт юу вэ? | | |
| 3.6 | Танай ЭМБ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй үйлчилгээг үзэж сонир-хохоор ирсэн хүмүүсийн тоог хэлж өгнө үү. | 2014/2015 | 2017/2018 |
| | | | |

**ТА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ МЭДЭЭЛЛЭЭ БИДЭНТЭЙ ХУВААЛЦНА УУ?**

| I | **Хөгжлийн бэрхшээлийн талаархи ойлголт** |
|---|---|
| 1 | НҮБ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал"-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ?<br>☐ 1985 онд.<br>☐ 2009 онд.<br>☐ Соёрхон батлаагүй<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF), -д хөгжлийн бэрхшээлийг 'эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны алдагдал', 'үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал' зэргээс гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг бэ?<br>☐ Оролцооны хязгаарлагдмал байдал<br>☐ Эдийн засгийн хязгаарлагдмал байдал<br>☐ Хөдөлгөөний хязгаарлагдмал байдал<br>☐ Мэдэхгүй |

| II | **Эрт илрүүлэлт болон хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | Дараах хариултын аль нь хүүхдийн үзлэг оношилгооны зорилгод хамаарах вэ?<br>☐ Хөгжлийн бэрхшээлийн төрлийг тодорхой болгох<br>☐ Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдийг ялгаж таних<br>☐ Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тохирох тусламж үйлчилгээнд холбож өгөх<br>☐ Мэдэхгүй |

| | |
|---|---|
| 2 | Хүүхдийг, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ?<br>☐ 18 сартайд<br>☐ 5 настайд<br>☐ Хөгжлийн бэрхшээлийн ангиллаас хамааран ялгаатай байх<br>☐ Мэдэхгүй |
| 3 | **Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, дэмжлэгт хамгийн чухал нь юу вэ?**<br>☐ Нарийн мэргэжлийн эмнэлэгт хийх оношлогоо<br>☐ Эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол төрийн байгууллагын хамтын ажиллагаа<br>☐ Нэн даруй халамжийн мөнгө олгох үйл ажиллагаа<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ?<br>☐ Эргэн тойрны тохиромжгүй харилцаанаас үүдсэн сэтгэл хөдлөл, үйл хөдлөлийн үл зохицох шинж<br>☐ Бусад хүүхдүүдтэй адилхан байх боломжгүйгээр шалтаглан эцэг эхийн зүгээс хүчирхийлэл үзүүлэх<br>☐ Эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ юу ч чадахгүй гэж бодсоноос хэт их анхаарал халамж тавих<br>☐ Мэдэхгүй |

| III | **Хүүхдийн хөгжлийн талаархи ойлголт** |
|---|---|
| 1 | Дараах хариултын аль нь хүүхдийн хөгжлийн үнэлгээний индекст багтах ба төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ?<br>☐ Нярайн рефлекс<br>☐ Ганганаж гунганах<br>☐ Инээмсэглэх<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аль илэрхийлэл нь 9 сар орчимтой хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн индекст багтах вэ?<br>☐ Харьцаж буй хүнийхээ яриаг ойлгон хамт мэдрэх<br>☐ Харьцаж буй хүнийхээ хөдөлгөөнийг даган дууриах<br>☐ Харьцаж буй хүнийхээ нүдний харц, дохио зангаагаар адил зүйлд анхаарал хандуулах<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн талаарх тайлбарыг тэмдэглэнэ үү<br>☐ Жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь эд юмсыг барих болон танин мэдэхүйн хөгжилтэй холбоотой.<br>☐ Том булчингийн хөдөлгөөний хөгжил нь хүүхэд бүрт ялгаа багатай, харин жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь их ялгаатай байдаг.<br>☐ Хэрэв оюуны бэрхшээлтэй бол том булчингийн хөдөлгөөний хөгжил хоцрогддогч, жижиг булчингийн хөдөлгөөний хөгжил нь хоцрогдохгүй.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Аль чадвар нь нярайн мэдрэхүйн хөгжлийн тухай зөв тайлбар вэ?<br>☐ Төрсний дараа 1 сартайдаа насанд хүрсэн хүнтэй адилхан хардаг болно.<br>☐ Толгойгоо даадаг болсны дараа дагуулан харж сурна.<br>☐ Ураг эхийн хэвлийд байхаасаа дуу чимээг сонсож эхлэх ба сонсгол мэдрэхүй нь |

| | |
|---|---|
| | төрөхөөс өмнө бий болдог.<br>☐ Мэдэхгүй |

| IV | **Хөгжлийн бэрхшээлийн ангиллын талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | Оюуны бэрхшээлийн тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Нийгмийн харилцаанд орж чадаагүйн улмаас, хэвийн хөгжиж эхэлсэн оюуны үйл ажиллагаа нь буурахыг хэлнэ.<br>☐ Оюуны үйл ажиллагаа нь үе тэнгийнхэнээс маш доогуур, өдөр тутмын бие эрхтний хөдөлгөөн нь хязгаарлагдахыг хэлнэ.<br>☐ Оюуны бэрхшээл нь хүүхдийн хөгжлийн үе төдийгүй, өсвөр насанд ч илэрч болно.<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аутизмыг оношлох стандартад аль нь багтах вэ?<br>☐ Бусадтай харилцахад хүндрэлтэй<br>☐ Хэл ярианы хоцрогдолтой<br>☐ Оюуны хөгжлийн хоцрогдолтой<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Тархины саажилттай хүүхдийн хараа нь асуудалгүй боловч, харааны танин мэдэхүйн асуудалтай байх тохиолдол бий.<br>☐ Тархины саажилттай хүүхдүүдээс зарим дуу авианы бэрхшээлтэй хүүхэд нь оюуны хоцрогдолтой байдаг.<br>☐ Тархины саажилттай хүүхэд сэргээн засал эмчилгээ хийлгэснээр хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл нь эдгэрэх боломжтой.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Суралцах бэрхшээлийн тухай зөв тайлбарыг тэмдэглэнэ үү?<br>☐ Оюуны бэрхшээлтэй хавсарсан байж болно<br>☐ Сонсголын бэрхшээл байх магадлалтай<br>☐ Танин мэдэхүйн тэнцвэр алдагдсанаас үүсдэг<br>☐ Мэдэхгүй |

| V | **"Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний талаарх ойлголт** |
|---|---|
| 1 | "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө" боловсруулахтай холбогдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үнэлгээ хийхэд аль нь чухал вэ?<br>☐ Зориулалтын хэрэглэгдэхүүн ашиглан, хөгжлийн сорил болон оюун ухааны сорилыг мэргэжлийн байгууллага дээр авах.<br>☐ Мэргэжлийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ, оношилгоо хийх.<br>☐ Эцэг/эхийн мэдээлэлд үндэслэн хүүхдийн төлөв байдлыг ажиглан, хүүхдийн талаар олон талаас нь судлах.<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аль нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний зорилгыг агуулж байна вэ?<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний чанарыг сайжруулах.<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан бүлгээр сургах сургалтын чанарыг сайжруулах.<br>☐ Хүүхэд бүрийн хэрэгцээнд тохируулан гэрээр сургах сургалтын чанарыг сайжруулах.<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө" боловсруулахад илүү тохиромжтой вэ? |

| | |
|---|---|
| | ☐ Хичээлийн агуулгаа гүйцэх чадвартай болгохыг урт хугацааны зорилт болгох<br>☐ Богино хугацааны зорилтыг хангах замаар урт хугацааны зорилтдоо хүрэх байдлаар төлөвлөх.<br>☐ Эцэг/эхийнх нь хамгийн их хүсч буй зүйлийг урт хугацааны зорилт болгох.<br>☐ Мэдэхгүй |
| 4 | "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө" боловсруулах Л.С.Выготскийн "Ойр хөгжлийн бүс (Zone of Proximal Development)"-д хамаатай аргыг тэмдэглэнэ үү?<br>☐ Урт хугацааны зорилтоо тодорхойлох<br>☐ Богино хугацааны зорилтоо тодорхойлох<br>☐ Сургалтын аргаа тодорхойлох<br>☐ Мэдэхгүй |

| VI | **Багшлах арга зүйн талаархи ойлголт** |
|---|---|
| 1 | Хэл ярианы бэрхшээл хавсарсан хүнд хэлбэрийн оюуны бэрхшээлтэй хүүхдийг сургахад тохиромжтой аргыг тэмдэглэнэ үү?<br>☐ Авиа зөв дуудах аргыг заах<br>☐ Зурагт карт ашиглан эд зүйлийн нэрийг заах<br>☐ Хэл ярианаас ондоо илэрхийллийн арга ашиглах<br>☐ Мэдэхгүй |
| 2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү?<br>☐ Хөтөлбөр, үйлийн дэс дараалыг харахад ойлгогдохоор зураг, фото зургаар үзүүлэх<br>☐ Өөртөө үйлчлэх дадал, үйл хөдлөл, дохио зангааг үе тэнгийн хүүхдүүдийн дунд нь сургах<br>☐ Тухайн хүүхдийн дуртай зүйлийг хийлгэн, биеэ барихгүй байдлаар чөлөөтэй байлгах<br>☐ Мэдэхгүй |
| 3 | Хараaны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамааралтай нөхцлийг тэмдэглэнэ үү.<br>☐ Үсгийн том, жижгийг таних<br>☐ Өнгө таних<br>☐ Хэлбэр дүрс таних<br>☐ Мэдэхгүй |
| 4 | Тоо буюу цифр мэдэхгүй хүүхдэд заахдаа юуг илүү анхаарах ёстой вэ?<br>☐ Чанга дуугаар бодит зүйлийг харуулан тоолуулах<br>☐ Тоонуудыг харахад хялбар байдлаар бичиж өгөн, дэвтэрт хуулуулах<br>☐ Тооны талаар үндсэн ойлголттой байгаа эсэхийг ажиглах<br>☐ Мэдэхгүй |

| № | **Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тухай мэдлэг шалгах сорил** |
|---|---|
| 1. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр хэнд зориулагдсан бэ?Авиа зөв дуудах аргыг заах<br>☐ Жирэмсэн эмэгтэй<br>☐ Төрсөн эх<br>☐ Нярай хүүхэд<br>☐ Бага насны хүүхэд<br>☐ Дээрх бүх хүнд |
| 2. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг хэдэн насны хүүхдэд ашигладаг вэ?<br>☐ Нярай<br>☐ 1-2 нас хүртэлх<br>☐ 5 нас хүртэлх |

| | |
|---|---|
| 3. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг хэн хөтлөх вэ?<br>☐ Эцэг эх ☐ Цэцэрлэгийн багш<br>☐ Эмч ☐ Нийгмийн ажилтан<br>☐ Сувилагч ☐ Дээрх бүгд |
| 4. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт ямар мэдээлэл байдаг вэ?<br>☐ Хүүхдийн хооллолт ☐ Дархлаажуулалт<br>☐ Хүүхдийн өсөлт ☐ Өвчтэй хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ<br>☐ Хүүхдийн хөгжил ☐ Дээрх бүгд |
| 5. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг эцэг эх өөртөө нандигнан хадгалж, байнга уншиж ашиглах нь хүүхдийн эрүүл мэндэд чухал нөлөөтэй.<br>☐ Тийм ☐ Үгүй |
| 6. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг өрх, сумын эмчид хүүхдээ үзүүлэхдээ авч ирнэ, бусад үед ашиглах шаардлагагүй.<br>☐ Тийм ☐ Үгүй |
| 7. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт хүүхдийн өсөлтийн хүснэгт хэдэн төрөл байдаг вэ?<br>Доорхи насны ангилалаас сонгоно уу?（хэдэн ч хариулт сонгож болно）<br>☐ 2 нас хүртэлх хүүхэд<br>☐ 2-5 насны хүүхэд<br>☐ Ялгаа байхгүй |
| 8. | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт хүүхдийн өсөлтийн хүснэгтийг хүйснээс хамаарч сонгодог.<br>☐ Тийм ☐ Үгүй |
| 9. | Хүүхдийн хөгжлийг ямар өнгийн хуудсанд тэмдэглэдэг вэ?<br>☐ Улаан<br>☐ Цэнхэр<br>☐ Өнгөгүй |

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 3. ТУРШИЛТЫН ТУСГАЙ, ЕРДИЙН СУРГУУЛИУД БОЛОН ТУРШИЛТЫН АЙМАГ, ДҮҮРГИЙН ТУРШИЛТЫН БУС СУРГУУЛИУД

Энэ бүлэгт туршилтын тусгай, ердийн сургууль болон туршилтын аймаг, дүүргийн туршилтын бус сургуулиудын (Ердийн сургууль) удирдах ажилтнуудыг хамруулан 2016 оны 3-4 дүгээр сард (Нийслэл, Баянгол дүүрэг) 2017 оны 01 дүгээр сард (Хөвсгөл аймаг) явуулсан суурь судалгаа үр дүнтэй 2018 оны 10-11 дүгээр сард зохион байгуулсан эцсийн төлөв байдлын судалгааны үр дүнг харьцуулсан үзэв. Харьцуулсан үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 3-1 Харьцуулсан үзүүлэлт*

| Үндсэн бүлэг | Дэд бүлэг | Аргачлал |
|---|---|---|
| Ерөнхий мэдээлэл | • Хүүхдийн тоо, багшийн тоо, ээлжийн тоо<br>• Сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо<br>• Бусад сургууль руу шилжсэн, гарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | Асуулгын хуудас |
| Тохируулгат орчин бүрдүүлэх | • Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах<br>• Үнэлгээний арга<br>• Багш нарын нэмэгдэл цалин, урамшуулал<br>• Сургуулийн орчин<br>• ХБХ-ийг хүлээж авч буй байдал<br>• Холбоглох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа<br>• Комисс, Салбар комиссын талаарх мэдлэг, хамтын ажиллагаа<br>• Туршлага судлахаар ирсэн хүний тоо | Асуулгын хуудас |

## 1. Ерөнхий мэдээлэл

### 1-1 Судалгаанд хамрагдсан сургуулийн суралцагч, багш, ээлжийн тоо

Сургуульд хамрагдаж буй нийт суралцагч, багш, ээлжийн тоог доорх хүснэгтэд үзүүлэв. Суурь судалгаа болон эцсийн төлөв байдлын судалгааг харьцуулахад суралцагчдын тоо нь туршилтын тусгай сургуульд ойролцоогоор 1.13 дахин (1,136-1,283), туршилтын ердийн сургуульд 1.16 дахин (13,700-15,855) болж нэмэгдсэн байна.. Баянгол дүүргийн туршилтын бус сургуулиудад ч ойролцоогоор 1.22 дахин (26,832-32,642), харин Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиудад хамрагдаж буй хүүхдийн тоо 1.03 дахин (22,129-22,924) болж өссөн буюу суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгаанд үр дүн дорвитой өөрчлөлт ажиглагдаагүй.

*Хүснэгт 3-2 Сургуулиудын ерөнхий мэдээлэл (Туршилтын тусгай сургууль, ердийн сургууль)*

| Сургуулийн нэр | | Суурь судалгаа | | | | Эцсийн төлөв байдлын судалгаа | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүүхдийн тоо | | Багш нарын тоо | Ээлжийн тоо | Хүүхдийн тоо | | Багш нарын тоо | Ээлжийн тоо |
| | | Эр | Эм | | | Эр | Эм | | |
| Тусгай Сургууль | 25-р тусгай сургууль | 131 | 92 | 50 | 2 | 136 | 84 | 56 | 2 |
| | 55-р тусгай сургууль | 188 | 268 | 81 | 2 | 306 | 203 | 94 | 2 |
| | 63-р тусгай сургууль | 115 | 99 | 37 | 1 | 132 | 118 | 47 | 1 |
| | 70-р тусгай сургууль | 130 | 113 | 32 | 1 | 186 | 118 | 44 | 2 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийслэл | 16-р сургууль | 678 | 634 | 66 | 2 | 805 | 783 | 70 | 2 |
| | 26-р сургууль | 315 | 255 | 34 | 1 | 311 | 299 | 30 | 2 |
| | 28-р сургууль | 1,090 | 1,150 | 108 | 2 | 1,266 | 1,290 | 117 | 2 |
| | 34-р сургууль | 418 | 427 | 51 | 1 | 489 | 486 | 52 | 2 |
| | 35-р сургууль | 782 | 773 | 75 | 2 | 1,597 | 758 | 50 | 2 |
| | 79-р сургууль | 1,109 | 1,196 | 127 | 1 | 1,126 | 1,183 | 114 | 2 |
| | 111-р сургууль | 640 | 584 | 46 | 3 | 745 | 714 | 51 | 3 |
| | 113-р сургууль | 736 | 781 | 70 | 2 | 834 | 886 | 69 | 2 |
| Хөвсгөл | Титэм 2-р сургууль | 693 | 746 | 71 | 2 | 687 | 917 | 74 | 2 |
| | Ирээдүй 21-р зуун цогцолбор | 348 | 345 | 53 | 1 | 366 | 313 | 48 | 2 |
| | Нийт | 7,373 | 7,463 | 901 | | 8,986 | 8,152 | 916 | |

*Хүснэгт 3-3 Сургуулиудын ерөнхий мэдээлэл (Баянгол дүүргийн туршилтын бус сургуулиуд)*

| | Сургуулийн нэр | Суурь судалгаа | | | | Эцсийн төлөв байдлын судалгаа | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүүхдийн тоо | | Багш нарын тоо | Ээлжийн тоо | Хүүхдийн тоо | | Багш нарын тоо | Ээлжийн тоо |
| | | Эр | Эм | | | Эр | Эм | | |
| 1 | 13-р сургууль | 1,066 | 1,088 | 101 | 3 | 1,238 | 1,244 | 109 | 2 |
| 2 | 20-р сургууль | 1,120 | 1,264 | 86 | 2 | 1,564 | 1,432 | 108 | 2 |
| 3 | 38-р сургууль | 478 | 580 | 56 | 2 | 1,256 | 1,185 | 86 | 2 |
| 4 | 40-р сургууль | 1,020 | 1,053 | 91 | 1 | 1,178 | 1,225 | 104 | 2 |
| 5 | 47-р сургууль | 818 | 786 | 74 | 2 | 814 | 840 | 78 | 2 |
| 6 | 51-р сургууль | 817 | 868 | 75 | 3 | 858 | 887 | 79 | 2 |
| 7 | 73-р сургууль | 410 | 400 | 46 | 3 | 671 | 654 | 61 | 2 |
| 8 | 93-р сургууль | 501 | 589 | 38 | 2 | 703 | 701 | 48 | 2 |
| 9 | Эрдмийн Ундраа цогцолбор сургууль | 1,954 | 2,087 | 183 | 2 | 2,392 | 2,250 | 203 | тодорхойгүй |
| 10 | Эрдмийн Өргөө цогцолбор сургууль | 1,661 | 1,693 | 133 | 2 | 2,118 | 2,193 | 196 | 3 |
| 11 | Оюуны Ундраа цогцолбор сургууль | 1,480 | 1,720 | 126 | 2 | 2,149 | 2,118 | 152 | 2 |
| 12 | Монгени цогцолбор сургууль | 759 | 800 | 88 | 2 | 680 | 713 | 85 | 2 |
| 13 | Сэтгэмж цогцолбор сургууль | 986 | 834 | 76 | 2 | 786 | 793 | 64 | 3 |
| | Нийт | 13,070 | 13,762 | 1,173 | | 16,407 | 16,235 | 1,373 | |

*Хүснэгт 3-4 Сургуулиудын ерөнхий мэдээлэл (Хөвсгөл аймгийн туршилтын бус сургуулиуд)*

| | Сургуулийн нэр | Суурь судалгаа | | | | Эцсийн төлөв байдлын судалгаа | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүүхдийн тоо | | Багш нарын тоо | Хүүхдийн тоо | Багш нарын тоо | | Хүүхдийн тоо | Багш нарын тоо |
| | | Эр | Эм | | | Эр | Эм | | |
| 1 | Аваргууд | 189 | 135 | 31 | 2 | 237 | 140 | 36 | 2 |
| 2 | АвьясахYIII | 267 | 280 | 41 | 2 | 312 | 308 | 44 | 2 |
| 3 | Алаг-Эрдэнэ | 220 | 197 | 31 | 2 | 236 | 207 | 31 | 2 |
| 4 | Арбулаг | 261 | 231 | 31 | 2 | 241 | 241 | 31 | 2 |
| 5 | Баянзүрх | 399 | 367 | 48 | 2 | 443 | 385 | 45 | 1 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Бүрэнтогтох | 270 | 233 | 39 | 2 | 262 | 247 | 40 | тодорхойгүй |
| 7 | Бүрэнхаан | 178 | 178 | 14 | 2 | 20 | 20 | 3 | 2 |
| 8 | Галт | 457 | 487 | 48 | тодорхойгүй | 452 | 482 | 62 | 2 |
| 9 | Сод-Эрдэм | 272 | 308 | 38 | 1 | 421 | 402 | 52 | 1.5 |
| 10 | Дэлгэрмөрөн | 1,055 | 1,228 | 108 | 2 | 1,144 | 1,366 | 109 | 1.5 |
| 11 | Жаргалант | | 1,026 | 59 | 2 | 630 | 570 | 58 | тодорхойгүй |
| 12 | Зүрх | тод-гүй | тод-гүй | 5 | 1 | 60 | 32 | 5 | 1 |
| 13 | Их-Уул | 435 | 448 | 51 | 1.5 | 413 | 454 | 51 | 1 |
| 14 | Гурван-Эрдэнэ | 652 | 667 | 65 | 2 | 728 | 704 | 74 | тодорхойгүй |
| 15 | Могой | 29 | 39 | 5 | 2 | | 69 | 5 | 2 |
| 16 | Рашаант | 362 | 371 | 41 | 2 | 342 | 352 | 44 | тодорхойгүй |
| 17 | Рэнчинлхүмбэ | 357 | 417 | 50 | 2 | 403 | 408 | 48 | 2 |
| 18 | Тариалан | | 1,130 | 59 | 2 | 592 | 585 | 60 | 2 |
| 19 | Тосонцэнгэл | 396 | 424 | 40 | 1.5 | 415 | 382 | 43 | 2 |
| 20 | Төмөрбулаг | 310 | 346 | 36 | 1 | 329 | 332 | 34 | 2 |
| 21 | Түнэл | 279 | 269 | 30 | бага 2 дунд 1 | | 564 | 31 | 2 |
| 22 | Улаан-Уул | 400 | 454 | 54 | 2 | 408 | 393 | 54 | 2 |
| 23 | Ханх | 278 | 265 | 39 | 2 | 287 | 279 | 37 | тодорхойгүй |
Одоо: Сурах таатай орчин нөхцөл бүрдээгүй, бусад хүүхдүүдэд саад болно, хурал зохион байгуулж бусад хүүхдүүдэд ойлгуулж, тайлбарлах шаардлагатай, сургуулийн дэмжлэгийн багтай хамтарч ажиллах шаардлагатай, нэмэлт цалин урамшуулал өгдөггүй, мэргэжлийн багш байхгүй, анги танхим хүрэлцдэггүй, ирж очиход хүндрэлтэй, шинэ багш учраас итгэлгүй байна.




*График 4-9 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах итгэл (Туршилтын тусгай сургууль) (N=197)*

Туршилтын ердийн сургуулийн хувьд ч төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнө (2014-2015 оны хичээлийн жил), төсөл хэрэгжиж эхлэснээс хойш (Одоо үе) маш тодорхой өөрчлөлтүүд гарсан байгаа нь ажиглагдсан. 16, 28, 35, 111, 113-р сургуулиуд өмнө “Итгэлгүй байна” гэсэн хариулж байсан бол энэ хандлага өөрчлөгдөж “Бага зэрэг итгэлтэй байна” гэсэн хариулт нэмэгдсэн байна. Харин 26, 34, 79, Титэм 2-р сургуулиуд болон Ирээдүй 21-р зуун цогцолбор сургуулийн хувьд “Итгэлтэй байна” гэсэн хариулт зонхилж байна. Олон багш нар итгэлтэй болсон шалтгаанаа “Хөгжлийн бэрхшээл, заах арга зүйн талаарх сургалтад хамрагдаж мэдэж авсан” гэж тайлбарласан. Эсрэгээр итгэлгүй байгаагаа “Сургалтад суугаагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн мэдлэггүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл зааж байгаагүй” зэрэг шалтгаанаар тайлбарлаж, нэг сургуулийн багш нар ч мэдлэг, туршлагаараа харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.




*График 4- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах итгэл*
*(Туршилтын ердийн сургууль) (N=638)*

## 3. Мэдлэг, чадвар

### 3-1 Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт

Багш нараас хөгжлийн бэрхшээлийн талаар асууж, мэдлэг, ойлголтын түвшинг нь үнэлэв. Хөгжлийн бэрхшээлийн талаар тайлбарласан хариултуудыг "Бие эрхтний үйл ажиллагаа", "Дэмжлэг шаардлагатай", "Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдал", "Орчны саад тотгор"-т ангилан дүгнэлт хийсэн.

Туршилтын тусгай сургуулиас судалгаанд хамрагдсан багш нарын 32.99%, Туршилтын ердийн сургуулийн багш нарын 54.55% нь "Бие эрхтний үйл ажиллагаа"-тай холбож тайлбарласан. Ердөө 3 хүн орчны саад бэрхшээлийн талаар онцолж хариулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын үзэл санаа дэлгэрээгүй байгаа нь харагдаж байна.

*Хүснэгт 4-5 Багш нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт*

*(Туршилтын тусгай сургууль N=197, Туршилтын ердийн сургууль N=638)*

| Туршилтын тусгай сургууль | | туршилтын ердийн сургууль | |
|---|---|---|---|
| Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 65 | Бие эрхтний үйл ажиллагааг онцолсон | 348 |
| Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 29 | Дэмжлэг шаардлагатайг онцолсон | 65 |
| Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 29 | Үйл ажиллагаа, оролцооны хязгаарлагдмал байдлыг онцолсон | 38 |
| Орчны саад тотгорыг онцолсон | 0 | Орчны саад тотгорыг онцолсон | 3 |
| Бусад* | 30 | Бусад* | 71 |
| Хариулаагүй | 44 | хариулт | 113 |

* Бусад гэдэгт “Бусад хүүхдүүдээс өөр онцлогтой” гэх зэрэг хариултууд байсан.

## 3-2 Мэдлэг, ойлголт

Туршилтын тусгай болон ердийн сургуулийн багш нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг 6 үндсэн сэдвийн 22 асуулттай тестээр шалгасан ба асуулт тус бүрийн гүйцэтгэлийг Хүснэгт 4-6, 4-7-д үзүүлэв.

*Хүснэгт 4-6 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт шалгах тест*

*(Туршилтын тусгай сургууль) Суурь судалгаа N=176, Эцсийн төлөв байдлын судалгаа: Нийт хариулсан багш нар N=197, Ажлын хэсэг N=36)*

| № | Асуулт | Сургуулийн нэр | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Хариулсан багш нарын нийт тоо | Ажлын хэсэг |
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | | **32.49%** | **37.60%** | **53.57%** |
| 1.1 | НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал”-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ? | 25-р тусгай сургууль | 1/39 | 11/50 | 2/12 |
| | | 55-р тусгай сургууль | 21/69 | 17/84 | 4/14 |
| | | 63-р тусгай сургууль | 6/37 | 14/32 | 2/4 |
| | | 70-р тусгай сургууль | 6/31 | 14/31 | 4/6 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, “Бие махбодын бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл”, “Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал”-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | 25-р тусгай сургууль | 29/39 | 16/50 | 6/12 |
| | | 55-р тусгай сургууль | 35/69 | 33/84 | 7/14 |
| | | 63-р тусгай сургууль | 9/37 | 16/32 | 4/4 |
| | | 70-р тусгай сургууль | 13/31 | 15/31 | 4/6 |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | | **43.61%** | **45.64%** | **50.74%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 25-р тусгай сургууль | 37/39 | 32/50 | 5/12 |
| | | 55-р тусгай сургууль | 48/69 | 60/84 | 11/14 |
| | | 63-р тусгай сургууль | 21/37 | 28/32 | 4/4 |
| | | 70-р тусгай сургууль | 23/31 | 25/31 | 6/6 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал | 25-р тусгай сургууль | 11/39 | 16/50 | 1/12 |
| | | 55-р тусгай сургууль | 19/69 | 24/84 | 5/14 |
| | | 63-р тусгай сургууль | 12/37 | 10/32 | 3/4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тохиромжтой вэ? | 70-р тусгай сургууль | 20/31 | 12/31 | 2/6 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 25-р тусгай сургууль | 12/39 | 13/50 | 2/12 |
| | | 55-р тусгай сургууль | 8/69 | 18/84 | 3/14 |
| | | 63-р тусгай сургууль | 7/37 | 13/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 5/31 | 8/31 | 2/6 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 25-р тусгай сургууль | 25/39 | 17/50 | 2/12 |
| | | 55-р тусгай сургууль | 30/69 | 42/84 | 6/14 |
| | | 63-р тусгай сургууль | 12/37 | 17/32 | 2/4 |
| | | 70-р тусгай сургууль | 10/31 | 14/31 | 5/6 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | | **44.66 %** | **54.22%** | **52.60%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 25-р тусгай сургууль | 16/39 | 27/50 | 5/12 |
| | | 55-р тусгай сургууль | 41/69 | 47/84 | 4/14 |
| | | 63-р тусгай сургууль | 9/37 | 17/32 | 1/4 |
| | | 70-р тусгай сургууль | 18/31 | 16/31 | 4/6 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 10/39 | 21/50 | 5/12 |
| | | 55-р тусгай сургууль | 27/69 | 33/84 | 10/14 |
| | | 63-р тусгай сургууль | 11/37 | 20/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 8/31 | 12/31 | 2/6 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 29/39 | 22/50 | 3/12 |
| | | 55-р тусгай сургууль | 30/69 | 41/84 | 4/14 |
| | | 63-р тусгай сургууль | 7/37 | 19/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 20/31 | 15/31 | 4/6 |
| 3.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 25/39 | 30/50 | 4/12 |
| | | 55-р тусгай сургууль | 36/69 | 59/84 | 10/14 |
| | | 63-р тусгай сургууль | 18/37 | 24/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 14/31 | 20/31 | 5/6 |
| 4 | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | | **52.57%** | **46.87%** | **54.69%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 26/39 | 21/50 | 3/12 |
| | | 55-р тусгай сургууль | 44/69 | 43/84 | 9/14 |
| | | 63-р тусгай сургууль | 15/37 | 11/32 | 1/4 |
| | | 70-р тусгай сургууль | 25/31 | 17/31 | 4/6 |
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 25-р тусгай сургууль | 31/39 | 29/50 | 5/12 |
| | | 55-р тусгай сургууль | 43/69 | 57/84 | 8/14 |
| | | 63-р тусгай сургууль | 26/37 | 25/32 | 4/4 |
| | | 70-р тусгай сургууль | 24/31 | 25/31 | 5/6 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 16/39 | 13/50 | 4/12 |
| | | 55-р тусгай сургууль | 6/69 | 26/84 | 4/14 |
| | | 63-р тусгай сургууль | 8/37 | 11/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 12/31 | 6/31 | 1/6 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 17/39 | 18/50 | 4/12 |
| | | 55-р тусгай сургууль | 33/69 | 40/84 | 7/14 |
| | | 63-р тусгай сургууль | 15/37 | 17/32 | 3/3 |
| | | 70-р тусгай сургууль | 18/31 | 11/31 | 3/4 |
| **5** | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | | **42.02%** | **39.21%** | **40.71%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 25-р тусгай сургууль | 20/39 | 24/50 | 4/12 |
| | | 55-р тусгай сургууль | 39/69 | 41/84 | 7/15 |
| | | 63-р тусгай сургууль | 21/37 | 19/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 17/31 | 18/31 | 3/6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ?。 | 25-р тусгай сургууль | 14/39 | 2/50 | 2/12 |
| | | 55-р тусгай сургууль | 1/69 | 10/84 | 1/14 |
| | | 63-р тусгай сургууль | 6/37 | 1/32 | 0/4 |
| | | 70-р тусгай сургууль | 5/31 | 5/31 | 2/6 |
| 5.3 | Аль зорилт нь "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)" боловсруулахад илүү тохиромжтой вэ? | 25-р тусгай сургууль | 33/39 | 31/50 | 6/12 |
| | | 55-р тусгай сургууль | 37/69 | 47/84 | 11/14 |
| | | 63-р тусгай сургууль | 21/37 | 16/32 | 2/4 |
| | | 70-р тусгай сургууль | 18/31 | 20/31 | 4/6 |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн "Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)" онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 25-р тусгай сургууль | 17/39 | 16/50 | 2/12 |
| | | 55-р тусгай сургууль | 27/69 | 37/84 | 5/14 |
| | | 63-р тусгай сургууль | 8/37 | 15/32 | 3/4 |
| | | 70-р тусгай сургууль | 8/31 | 7/31 | 1/6 |
| **6** | **Багшлах арга зүй талаарх ойлголт** | | **27.97%** | **26.59%** | **34.38%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 8/39 | 6/50 | 1/12 |
| | | 55-р тусгай сургууль | 9/69 | 12/84 | 2/14 |
| | | 63-р тусгай сургууль | 4/37 | 7/32 | 2/4 |
| | | 70-р тусгай сургууль | 6/31 | 0/31 | 0/6 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 25-р тусгай сургууль | 18/39 | 24/50 | 5/12 |
| | | 55-р тусгай сургууль | 35/69 | 34/84 | 7/14 |
| | | 63-р тусгай сургууль | 11/37 | 18/32 | 4/4 |
| | | 70-р тусгай сургууль | 7/31 | 7/31 | 3/6 |
| 6.3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 25-р тусгай сургууль | 3/39 | 13/50 | 1/12 |
| | | 55-р тусгай сургууль | 11/69 | 12/84 | 2/14 |
| | | 63-р тусгай сургууль | 12/37 | 4/32 | 0/4 |
| | | 70-р тусгай сургууль | 16/31 | 11/31 | 3/6 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 25-р тусгай сургууль | 4/39 | 11/50 | 3/12 |
| | | 55-р тусгай сургууль | 27/69 | 28/84 | 3/14 |
| | | 63-р тусгай сургууль | 12/37 | 14/32 | 2/4 |
| | | 70-р тусгай сургууль | 14/31 | 7/31 | 4/6 |

Суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгааны хариулт өгсөн нийт багш нарын дүн, зөвхөн ажлын хэсгийн гүйцэтгэлийн дүнг хооронд нь харьцуулахад, ажлын хэсгийн гүйцэтгэлийн аль аль үзүүлэлт суурь судалгааны үеийнхээс дээгүүр байна. Үүнээс ажлын хэсгийн мэдлэг, ойлголт суурь судалгааны үеэс ч илүү дээшилсэн байгаа гэж дүгнэлээ.




*График 4-11 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт тестийн сэдэв тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Туршилтын тусгай сургууль), (Суурь судалгаа N=176, Эцсийн төлөв байдлын судалгаа: Нийт хариулсан багш нар хүн N=197, Ажлын хэсэг N=36)*

*Хүснэгт 4-7 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт шалгах тест (Туршилтын ердийн сургууль) (Суурь судалгаа N=603, Эцсийн төлөв байдлын судалгаа: Нийт хариулсан багш нар N=638, Ажлын хэсэг N=93)*

| № | Асуулт | Сургуулийн нэр | Суурь судалгаа | Эцсийн төлөв байдлын судалгаа | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт хариулсан хүний тоо | Ажлын хэсэг |
| **1** | **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт** | | **17.84%** | **24.30%** | **43.13%** |
| 1.1 | НҮБ-ын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай тунхаглал"-ыг Монгол Улс хэзээ соёрхон баталсан бэ? | 16-р сургууль | 8/58 | 5/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 7/35 | 11/32 | 2/7 |
| | | 28-р сургууль | 14/108 | 19/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 2/56 | 7/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 6/72 | 11/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 12/120 | 20/99 | 5/18 |
| | | 111-р сургууль | 2/42 | 4/48 | 0/6 |
| | | 113-р сургууль | 9/61 | 6/67 | 4/14 |
| | | Титэм | 14/28 | 24/62 | 7/13 |
| | | Ирээдүй | 5/23 | 8/44 | 3/14 |
| 1.2 | Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д хөгжлийн бэрхшээлийг, "Бие махбодын бүтэц, үйл ажиллагааны бэрхшээл", "Үйлдэл, чадварын хязгаарлагдмал байдал"-аас гадна өөр юуг багтаан цогц нэр томъёо болгон ашигладаг вэ? | 16-р сургууль | 9/58 | 21/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 7/35 | 10/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 27/108 | 28/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 7/56 | 13/50 | 3/7 |
| | | 35-рсургууль | 23/72 | 16/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 25/120 | 34/99 | 8/18 |
| | | 111-р сургууль | 3/42 | 10/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 10/61 | 14/67 | 3/14 |
| | | Титэм | 6/28 | 29/62 | 8/13 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ирээдүй | 6/23 | 15/44 | 4/14 |
| **2** | **Эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголт** | | **35.07%** | **36.49%** | **33.22%** |
| 2.1 | Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго юу вэ? | 16-р сургууль | 37/58 | 29/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 22/35 | 25/32 | 4/7 |
| | | 28-р сургууль | 67/108 | 65/114 | 2/6 |
| | | 34-р сургууль | 26/56 | 29/50 | 6/7 |
| | | 35-рсургууль | 42/72 | 29/68 | 2/4 |
| | | 79-р сургууль | 77/120 | 60/99 | 8/18 |
| | | 111-р сургууль | 15/42 | 23/48 | 4/6 |
| | | 113-р сургууль | 32/61 | 30/67 | 8/14 |
| | | Титэм | 24/28 | 44/62 | 10/13 |
| | | Ирээдүй | 15/23 | 32/44 | 10/14 |
| 2.2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэгт хэдийд хамруулбал тохиромжтой вэ? | 16-р сургууль | 16/58 | 14/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 12/35 | 10/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 39/108 | 39/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 16/56 | 19/50 | 2/7 |
| | | 35-рсургууль | 16/72 | 18/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 27/120 | 35/99 | 6/18 |
| | | 111-р сургууль | 10/42 | 9/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 19/61 | 21/67 | 7/14 |
| | | Титэм | 5/28 | 22/62 | 4/13 |
| | | Ирээдүй | 11/23 | 19/44 | 7/14 |
| 2.3 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, дэмжлэг үзүүлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 16-р сургууль | 8/58 | 10/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 13/35 | 6/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 23/108 | 31/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 7/56 | 16/50 | 2/7 |
| | | 35-рсургууль | 9/72 | 12/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 25/120 | 22/99 | 3/18 |
| | | 111-р сургууль | 5/42 | 7/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 12/61 | 10/67 | 2/14 |
| | | Титэм | 10/28 | 13/62 | 3/13 |
| | | Ирээдүй | 3/23 | 9/44 | 5/14 |
| 2.4 | Хоёрдогч бэрхшээл гэж юу вэ? | 16-р сургууль | 20/58 | 12/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 12/35 | 16/32 | 3/7 |
| | | 28-р сургууль | 28/108 | 47/114 | 2/6 |
| | | 34-р сургууль | 14/56 | 14/50 | 3/7 |
| | | 35-рсургууль | 27/72 | 13/68 | 2/4 |
| | | 79-р сургууль | 36/120 | 40/99 | 6/18 |
| | | 111-р сургууль | 11/42 | 14/48 | 3/6 |
| | | 113-р сургууль | 22/61 | 15/67 | 2/14 |
| | | Титэм | 10/28 | 31/62 | 4/13 |
| | | Ирээдүй | 7/23 | 19/44 | 1/14 |
| **3** | **Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг** | | **28.12%** | **36.18%** | **36.03%** |
| 3.1 | Дараах хариултын аль нь нярайн хөгжлийн үнэлгээний үзүүлэлт болж, төв мэдрэлийн | 16-р сургууль | 17/58 | 18/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 12/35 | 19/32 | 3/7 |
| | | 28-р сургууль | 37/108 | 43/114 | 1/6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тогтолцоо бүрэлдэж гүйцэхтэй зэрэгцэн аяндаа алга болдог вэ? | 34-р сургууль | 14/56 | 21/50 | 3/7 |
| | | 35-рсургууль | 24/72 | 16/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 40/120 | 31/99 | 6/18 |
| | | 111-р сургууль | 10/42 | 14/48 | 3/6 |
| | | 113-р сургууль | 17/61 | 11/67 | 4/14 |
| | | Титэм | 13/28 | 35/62 | 5/13 |
| | | Ирээдүй | 10/23 | 24/44 | 9/14 |
| 3.2 | 9 орчим сартай хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт аль нь вэ? | 16-р сургууль | 13/58 | 17/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 11/35 | 13/32 | 3/7 |
| | | 28-р сургууль | 29/108 | 20/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 3/56 | 7/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 14/72 | 13/68 | 2/4 |
| | | 79-р сургууль | 24/120 | 20/99 | 4/18 |
| | | 111-р сургууль | 6/42 | 8/48 | 2/6 |
| | | 113-р сургууль | 6/61 | 15/67 | 6/14 |
| | | Титэм | 7/28 | 26/62 | 4/13 |
| | | Ирээдүй | 3/23 | 18/44 | 7/14 |
| 3.3 | Бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 15/58 | 5/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 6/35 | 9/32 | 2/7 |
| | | 28-р сургууль | 18/108 | 36/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 6/56 | 19/50 | 4/7 |
| | | 35-рсургууль | 9/72 | 13/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 18/120 | 26/99 | 6/18 |
| | | 111-р сургууль | 5/42 | 13/48 | 3/6 |
| | | 113-р сургууль | 12/61 | 19/67 | 5/14 |
| | | Титэм | 16/28 | 21/62 | 4/13 |
| | | Ирээдүй | 5/23 | 14/44 | 6/14 |
| 3.4 | Бага насны мэдрэхүйн хөгжлийн зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 23/58 | 21/54 | 2/4 |
| | | 26-р сургууль | 20/35 | 23/32 | 5/7 |
| | | 28-р сургууль | 43/108 | 68/114 | 3/6 |
| | | 34-р сургууль | 17/56 | 27/50 | 5/7 |
| | | 35-рсургууль | 20/72 | 24/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 31/120 | 54/99 | 11/18 |
| | | 111-р сургууль | 7/42 | 14/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 21/61 | 29/67 | 9/14 |
| | | Титэм | 17/28 | 42/62 | 8/13 |
| | | Ирээдүй | 15/23 | 31/44 | 10/14 |
| 4 | **Хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаарх ойлголт** | | **20.43%** | **23.74%** | **23.96%** |
| 4.1 | Оюун ухааны бэрхшээлийн зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 23/58 | 18/54 | 2/4 |
| | | 26-р сургууль | 11/35 | 15/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 51/108 | 53/114 | 2/6 |
| | | 34-р сургууль | 17/56 | 9/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 22/72 | 20/68 | 3/4 |
| | | 79-р сургууль | 33/120 | 39/99 | 10/18 |
| | | 111-р сургууль | 17/42 | 19/48 | 3/6 |
| | | 113-р сургууль | 25/61 | 19/67 | 7/14 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Титэм | 15/28 | 29/62 | 6/13 |
| | | Ирээдүй | 12/23 | 18/44 | 8/14 |
| 4.2 | Аутизмын хүрээний эмгэгийг оношлох стандартад аль нь багтах вэ? | 16-р сургууль | 8/58 | 15/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 7/35 | 11/32 | 2/7 |
| | | 28-р сургууль | 11/108 | 25/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 14/56 | 19/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 9/72 | 12/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 22/120 | 38/99 | 4/18 |
| | | 111-р сургууль | 5/42 | 8/48 | 0/6 |
| | | 113-р сургууль | 9/61 | 15/67 | 3/14 |
| | | Титэм | 6/28 | 14/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 2/23 | 20/44 | 7/14 |
| 4.3 | Бага насны хүүхдийн тархины саажилтын тухай зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 7/58 | 6/54 | 0 /4 |
| | | 26-р сургууль | 3/35 | 4/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 16/108 | 9/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 2/56 | 4/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 8/72 | 5/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 7/120 | 11/99 | 1/18 |
| | | 111-р сургууль | 5/42 | 5/48 | 0/6 |
| | | 113-р сургууль | 4/61 | 4/67 | 0/14 |
| | | Титэм | 5/28 | 10/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 1/23 | 6/44 | 6/14 |
| 4.4 | Суралцахуйн бэрхшээлийн тухай зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 10/58 | 5/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 10/35 | 11/32 | 4/7 |
| | | 28-р сургууль | 21/108 | 21/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 8/56 | 13/50 | 2/7 |
| | | 35-рсургууль | 15/72 | 9/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 16/120 | 25/99 | 3/18 |
| | | 111-р сургууль | 6/42 | 6/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 5/61 | 7/67 | 2/14 |
| | | Титэм | 7/28 | 16/62 | 3/13 |
| | | Ирээдүй | 2/23 | 7/44 | 4/14 |
| **5** | **Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) талаарх ойлголт** | | **21.40%** | **22.71%** | **21.48%** |
| 5.1 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэхэд хамгийн чухал нь юу вэ? | 16-р сургууль | 14/58 | 6/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 12/35 | 10/32 | 0/7 |
| | | 28-р сургууль | 20/108 | 18/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 13/56 | 13/50 | 2/7 |
| | | 35-рсургууль | 16/72 | 7/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 20/120 | 19/99 | 2/18 |
| | | 111-р сургууль | 6/42 | 12/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 11/61 | 8/67 | 3/14 |
| | | Титэм | 19/28 | 20/62 | 4/13 |
| | | Ирээдүй | 7/23 | 12/44 | 7/14 |
| 5.2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний (ГСТ) зорилгын тухай зөв тайлбар аль нь вэ? | 16-р сургууль | 11/58 | 3/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 6/35 | 0/32 | 0/7 |
| | | 28-р сургууль | 13/108 | 18/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 7/56 | 10/50 | 0/7 |
| | | 35-рсургууль | 13/72 | 9/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 21/120 | 21/99 | 2/18 |
| | | 111-р сургууль | 5/42 | 10/48 | 1/6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 113-р сургууль | 7/61 | 10/67 | 3/14 |
| | | Титэм | 4/28 | 6/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 2/23 | 4/44 | 2/14 |
| 5.3 | Аль зорилт нь “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)” боловсруулахад илүү тохиромжтой вэ? | 16-р сургууль | 16/58 | 12/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 10/35 | 14/32 | 2/7 |
| | | 28-р сургууль | 39/108 | 42/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 15/56 | 21/50 | 5/7 |
| | | 35-рсургууль | 28/72 | 26/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 37/120 | 36/99 | 3/18 |
| | | 111-р сургууль | 10/42 | 17/48 | 5/6 |
| | | 113-р сургууль | 14/61 | 19/67 | 6/14 |
| | | Титэм | 13/28 | 32/62 | 8/13 |
| | | Ирээдүй | 9/23 | 33/44 | 11/14 |
| 5.4 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах Л.С.Выготскийн “Ойрын хөгжлийн бүс (Zone of Proximal Development)” онолд хамаатай аргыг тэмдэглэнэ үү? | 16-р сургууль | 10/58 | 4/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 3/35 | 5/32 | 0/7 |
| | | 28-р сургууль | 18/108 | 21/114 | 1/6 |
| | | 34-р сургууль | 1/56 | 5/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 18/72 | 13/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 15/120 | 12/99 | 2/18 |
| | | 111-р сургууль | 3/42 | 3/48 | 0/6 |
| | | 113-р сургууль | 6/61 | 4/67 | 2/14 |
| | | Титэм | 3/28 | 18/62 | 5/13 |
| | | Ирээдүй | 3/23 | 15/44 | 5/14 |
| **6** | **Багшлах арга зүй талаарх ойлголт** | | **21.86%** | **19.65%** | **18.54%** |
| 6.1 | Ярьж чаддаггүй, хүнд хэлбэрийн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд хамгийн тохиромжтой заах арга аль нь вэ? | 16-р сургууль | 13/58 | 10/54 | 0/4 |
| | | 26-р сургууль | 7/35 | 5/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 24/108 | 23/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 13/56 | 7/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 16/72 | 9/68 | 0/4 |
| | | 79-р сургууль | 23/120 | 21/99 | 1/18 |
| | | 111-р сургууль | 6/42 | 8/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 20/61 | 8/67 | 1/14 |
| | | Титэм | 6/28 | 17/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 9/23 | 5/44 | 1/14 |
| 6.2 | Аутизмтай хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх тохиромжтой нөхцөлийг тэмдэглэнэ үү? | 16-р сургууль | 4/58 | 5/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 2/35 | 5/32 | 2/7 |
| | | 28-р сургууль | 7/108 | 7/114 | 2/6 |
| | | 34-р сургууль | 3/56 | 10/50 | 3/7 |
| | | 35-рсургууль | 6/72 | 6/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 8/120 | 11/99 | 1/18 |
| | | 111-р сургууль | 2/42 | 7/48 | 2/6 |
| | | 113-р сургууль | 4/61 | 6/67 | 3/14 |
| | | Титэм | 0/28 | 11/62 | 3/13 |
| | | Ирээдүй | 4/23 | 9/44 | 3/14 |
| 6.3 | Харааны мэдрэмжээр уншиж бичиж сургахад хамгийн хамааралтай нь аль нь вэ? | 16-р сургууль | 9/58 | 6/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 13/35 | 8/32 | 1/7 |
| | | 28-р сургууль | 33/108 | 34/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 14/56 | 14/50 | 2/7 |
| | | 35-рсургууль | 22/72 | 10/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 27/120 | 36/99 | 4/18 |
| | | 111-р сургууль | 6/42 | 9/48 | 1/6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 113-р сургууль | 17/61 | 12/67 | 2/14 |
| | | Титэм | 11/28 | 12/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 6/23 | 11/44 | 2/14 |
| 6.4 | Тоо мэдэхгүй хүүхдэд заахдаа юунд илүү анхаарах ёстой? | 16-р сургууль | 12/58 | 17/54 | 1/4 |
| | | 26-р сургууль | 18/35 | 9/32 | 3/7 |
| | | 28-р сургууль | 35/108 | 23/114 | 0/6 |
| | | 34-р сургууль | 14/56 | 12/50 | 1/7 |
| | | 35-рсургууль | 22/72 | 9/68 | 1/4 |
| | | 79-р сургууль | 30/120 | 30/99 | 4/18 |
| | | 111-р сургууль | 10/42 | 14/48 | 1/6 |
| | | 113-р сургууль | 23/61 | 16/67 | 5/14 |
| | | Титэм | 9/28 | 21/62 | 2/13 |
| | | Ирээдүй | 5/23 | 10/44 | 4/14 |

Туршилтын ердийн сургуулийн багш нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэгийн түвшинг үнэлэхдээ суурь судалгаа, эцсийн төлөв байдлын судалгаа, ажлын хэсгийн судалгааны тестийн гүйцэтгэлийг хооронд нь харьцуулсан. Ажлын хэсгийн “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт” бүлгийн тестийн гүйцэтгэл нь суурь судалгааны үеийн үр дүн болон эцсийн төлөв байдлын судалгааны нийт хариулт өгсөн хүмүүсийн гүйцэтгэлээс нилээд дээгүүр үзүүлэлттэй байна. Түүнчлэн “Хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг”, “Хөгжлийн бэрхшээлийн ангилал” бүлгийн тестийн гүйцэтгэл ч суурь судалгааны үеийнхээс эцсийн төлөв байдлын судалгаан дээр илүү өндөр үзүүлэлттэй байна. Гэвч бусад бүлгийн тестийн тухайд суурь судалгаатай харьцуулахад нэг их өөрчлөлт гараагүй байна.




*График 4-12 Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт тестийн сэдэв тус бүрийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт (Туршилтын ердийн сургууль), (Суурь судалгаа N=603, Эцсийн төлөв байдлын судалгаа: Нийт хариулт өгсөн багш нар N=638, Ажлын хэсэг N=93)*

**3-3 (Зөвхөн туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэг) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний харьцуулалт**

2018 оны 08 дугаар сарын 31-ний өдөр болон 09 дүгээр сарын 03-ны өдөр туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэгтэй бүлгийн ярилцлага хийсэн.

*Хүснэгт 4-8 Ярилцлагын талаарх мэдээлэл*

| Туршилтын тусгай сургууль | Ярилцлага хийсэн өдөр | Оролцогчдын тоо |
|---|---|---|
| 25-р тусгай сургууль | 8/31 | 11 |
| 55-р тусгай сургууль | 8/31 | 9 |
| 63-р тусгай сургууль | 9/3 | 5 |
| 70-р тусгай сургууль | 9/3 | 9 |

Сургуулийн ажлын хэсэгтэй төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнө боловсруулж байсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон төслийн оролцоо, дэмжлэгээр сайжирсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хооронд нь харьцуулан дүгнэж, хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадвар хэрхэн өөрчлөгдсөн талаар ярилцав. Төсөл тусгай сургуулиудтай хамтарч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг боловсруулан, сургууль бүр ашиглах боломжтой болсноор ажлын хэсгийн хүүхдийн бодит байдлыг үнэлэх чадвар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чадваруудад дараах эерэг ахиц, өөрчлөлтүүд гарсан гэж үзэж байна.

- Хүүхдийн бодит байдлыг үнэлдэг болсон.
- Тодорхой урт, богино хугацааны зорилт, заах агуулга төлөвлөж чаддаг болсон.
- Багш нар өөр хоорондоо мэдээллээ сайн солилцдог болсон.
- Хүүхдийн ар гэрийнхэнтэй ярилцаж чаддаг болсон.

Хариултууд дунд "Ангийн бүх хүүхэд боловсролын үйлчилгээг эрх тэгш хүртэх боломжтой болж ирсэн. Өмнө нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдээс тусдаа өөр зүйл хийдэг байсан бол ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулдаг болсноос хойш хичээлд хамтдаа оролцох боломжтой болсон" гэсэн сэтгэгдэл ч байсан.

**<u>25-р тусгай сургууль</u>**

- Төсөл эхлэхээс өмнө байсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь хичээл тус бүрийн зорилт,заах аргачлалыг сургууль болон гэртээ гэсэн байдлаар маш ерөнхий тэмдэглэдэг зүйл байсан. Төсөлтэй хамтран боловсруулсан шинэ загвар нь хүүхдийн бодит байдлыг дэлгэрэнгүй тэмдэглэх, урт, богино хугацааны зорилтыг тус тусад нь бичих боломжтой бөгөөд тухайн хүүхэдтэй холбоотой олон талын мэдээллийг бүхэлд нь харж болохоор болсон. Анхандаа урт болон богино хугацааны зорилтыг зөв тодорхойлж бичих нь хүндрэлтэй байсан. Бичиж сурах хүртэл нэлээд хэдэн удаа багш нараараа зөвлөлдөх хэрэг гарч байсан.
- Төсөл эхлэхээс өмнөх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хичээл тус бүр дээр ангид сурлагаараа хоцрогдож байгаа хүүхдэд боловсруулж ажиллаж байсан. Сүүлийн

үед хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олширч байгаа тул тэдгээр хүүхдүүдэд боловсруулж ашиглахад хялбар загвар болгон засч, сайжруулж ирсэн. 2016 онд тус сургуулийн загвар нь бусад сургуулийнхаас өөр байсан гэж бодож байна. Анги даасан багш нар ганцаараа бие даан боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөө зөвхөн өөрсдөө л ашигладаг байсан. Одоогийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд хүүхдийн бодит байдлаас эхлээд бусад олон төрлийн мэдээллүүд бичигддэг. Бусад хичээлийн багш нар ч өөр хоорондоо юу зааж, ямар зорилт дэвшүүлснээ ярилцах боломжтойгоор боловсруулагдсан болохоор сайжирсан гэж үзэж байна. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахын тулд хэд хэдэн багш нар баг болж ажиллах нь хүүхдийн хөгжлийн ахиц, амжилтад нөлөөлнө гэдгийг ойлгосон.

- Төслөөр дамжуулан багш нар олон зүйл сурч мэдсэн. Төсөл эхлэхээс өмнө ашиглаж байсан загварт ерөнхий агуулга бичиж байсан учир нарийн зүйлийг мэдэх боломжгүй байсан. Төсөлтэй хамтран боловсруулсан шинэ загвар нь гэр бүлийн бүтэц, хүүхдийн хөгжлийн үе шат зэрэг олон мэдээллийг бичих боломжтой болсон нь хамгийн их таалагдсан. Урт хугацааны зорилтыг нэн түрүүнд дэвшүүлж, түүнийгээ богино хугацааны зорилтод хуваaж бичих нь гол давуу тал гэж бодож байна. Урьд өмнө "Уншиж сурна", "Хайчилж сурна" зэрэг ерөнхий зорилт бичдэг байснаас уншиж сурахад нь хэрхэн дэмжлэг үзүүлж ажиллах тухай төлөвлөж бичдэггүй байсан. Хийх үйл ажиллагааг маш дэлгэрэнгүй тодорхой төлөвлөх боломжтой болсноороо ач холбогдолтой.

**<u>55-р тусгай сургууль</u>**

- Төсөл эхлэхээс өмнөх загварт хүүхдийн мэдээллийг бичдэггүй байсан учраас анги даасан багш тухайн хүүхдийн талаар сайн ойлголтгүй байдаг байсан. Төсөлтэй хамтран боловсруулсан шинэчилсэн загварт хүүхдийн мэдээллийг тэмдэглэх хэсэгтэй тул бусад багш нарт ойлгомжтой болсон. Мөн өмнө эцэг эх, асран хамгаалагч болон тухайн хүүхдийн хүслийг асуулгүйгээр ангийн багш нь бичдэг байсан. Хэтэрхий ерөнхий агуулгыг бичдэг байсан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилтот хугацаа нь хэр тохиромжтой байгаа талаар хэлэлцэж ирээгүй. Шинэчилсэн загварт хүүхдийн талаар маш дэлгэрэнгүй бичих боломжтой болсон. Тухайн хүүхэдтэй ажилладаг багш нар хамтдаа зөвлөлдөж боловсруулах боломжтой болсноор багш нарын хамтын ажиллагаа ч сайжирсан. Хэзээ, хаана, юу заах вэ гэдгийг тэмдэглэх хэсэг байгаа учраас хичээл заахад ойлгомжтой болсон. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж үзвэл хүүхдийн ахиц өөрчлөлтийг амархан анзаарч харна.

**<u>63-р тусгай сургууль</u>**

- Төсөл эхлэхээс өмнө ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний нэгдсэн загвар гэж байгаагүй. 20 минутын ганцаарчилсан сургалтын хугацаанд л ганцаарчилсан

сургалтын төлөвлөгөө боловсруулж, ашиглаж байсан. Хэл заслын багш нарын тухайн хүүхэд дээр боловсруулсан төлөвлөгөөг бусад багш нар мэддэггүй байсан. Төсөл эхлэснээс хойш хүүхэдтэй ажилладаг багш нар мэдээлэл авах, солилцох боломжтой болсон. Эхний 1 жилд ойлгохгүй асуудлууд гарч байсан ч 2 дахь жилээс бүгдээрээ боловсруулж чаддаг болсон. Өөрөөр хэлбэл 3 жилийн өмнөх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь маш ерөнхий агуулгатай байсан. Хүүхдийн одоогийн байдал ямар байгааг огт бичдэггүй байсан. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн тухайд ч хичээл тус бүр дээр ерөнхийд нь бичиж, хүүхэд нэг бүрт зориулсан төлөвлөгөө гэхээс илүү нийт ангийн сурагчдын төлөвлөгөө гэхээр зүйл байсан. Багш ямар үед хүүхдэд дэмжлэг үзүүлэх вэ гэсэн агуулга ч бичигддэггүй байсан.

- Шинэчилсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загварт зорилт, дэмжлэгийн агуулгыг хичээл тус бүрээр бичих боломжтой болсон байгаа. Ээлжит хичээлийн хөтөлбөрийн агуулга ч тодорхой болж, ангийн бүх хүүхэд боловсролд тэгш хамрагдах боломжтой болж ирж байна. Өмнө хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхдүүдээс тусдаа өөр зүйл хийдэг байсан бол ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулдаг болсноор ч хичээлд хамтдаа оролцож, адилхан үйл ажиллагаа хийдэг болсон.
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бодит байдлыг үнэлж, хөгжлийн аль үе шатандаа байгаа, дараагийн алхамд хүрэхэд юуг, хэрхэн заах вэ гэдгээ сайн боддог болсон. Урт хугацааны зорилтод тулгуурлан хүүхдэд хамгийн ойр, хялбар зүйлээс эхлэн алхам алхмаар хүнд даалгавар гүйцэтгүүлдэг болж ирсэн. Багш нар ч урьд өмнөхөөсөө илүү хамтарч ажилладаг болсон. Багаар ажилладаг болсноор сургууль, гэр бүлийн харилцаа ч сайжирсан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг ашигладаг багш нарыг багшлах арга зүй ч өөрчлөгдсөн.

**<u>70-р тусгай сургууль</u>**

- Төсөл эхлэхээс өмнө багш нар өөр өөрсдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг байсан. Сайдаар батлуулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний шинэ загвар нь бичих агуулга нарийн тодорхой болж, хүүхэд нэг бүрийн тухай тухайн хүүхэдтэй ажилладаг багш нар зөвлөлдөн бичих боломжтой болсон. Бага, дунд ангийн багш нарын хамтын ажиллагаа сайжирсан. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бага ангиас дунд анги руу шилжих үед ч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тусламжтай дараагийн анги даах багшид шилжүүлэн хүлээлгэж өгөхөд амар болсон. 4 төрлийн хөгжлийн айтай учраас дэлгэрэнгүй бичиж боловсруулах боломжтой болсон.
- Төсөл маш их үр өгөөжтэй байсан гэж бодож байна. Багш нар маш их зүйл сурсан. Заах арга зүйн талаар ч олон шинэ мэдлэг олж авсан. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь бодит байдлыг тодорхойлж үнэлгээ хийснээр ай бүрийн зорилтыг

дэвшүүлдэг. Тиймээс энэ нь хүүхэд хөгжүүлэх аргачлал болсон гэж бодож байна. Гэр бүл, сургуулийг холбох харилцааны арга болгож ч ашиглах боломжтой болсон. Эцэг эх, асран хамгаалагчаас хүүхдийн бодит байдлыг асууж тодруулдаг болсноор өмнө мэддэггүй байсан ар гэрийн байдлыг мэдэх боломжтой болсон. Төслийн ачаар заах арга зүй сайжруулж, хүүхдүүдтэй ч сайн ажилладаг болсон гэж бодож байгаа. Өмнө мэдлэгтэй байсан ч түүнийгээ хэрхэн гаргаж ашиглахаа мэддэггүй байсан. Одоо юу хийж, яаж ажиллахаа сайн ойлгодог болсон.

- Төсөлтэй хамтран боловсруулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загварт хичээлийн цагийн зорилго, хүүхдийн зорилгыг бичих хэсэгтэй болсон учраас хичээлийн зорилго ойлгомжтой болсон. Өмнөх загварт нэгтгээд бичдэг байсан тул хичээлийн нарийн төлөвлөгөө багшийн толгойд л байдаг байлаа. Хичээлд шаардлагатай зүйлийг цаасан дээр буулгаж бичихийг сурсан. Урьд өмнө сургууль бүр л, цаашлаад нэг сургуулийн багш нар хүртэл өөр өөр загвар ашиглаж төлөвлөгөө боловсруулдаг байсан. Харин одоо нэгдсэн нэг загвараар ижил агуулга бичдэг болсон нь багш нарт ч хүүхдэд ч адилхан давуу талтай болсон.

**3-4 (Зөвхөн туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэг) Хичээлийн харьцуулалт**

Сургуулийн ажлын хэсэгт төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнөх хичээл (2016 он) болон төсөл хэрэгжиж эхлэснээс хойших хичээлийн (2018 он) видеог 20 мин орчим үзэж харьцуулан, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах чадвар хэрхэн өөрчлөгдсөнийг ярилцсан.

4-өөс 3 сургуулийн ажлын хэсэг нь ээлжит хичээлийн хөтөлбөрийн талаар онцолж ярьсан ба ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан судалгаат хичээл зохион байгуулах туршлагаар дамжуулан хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцүүлэн заах ур чадвар дээшилсэн байгаа нь тодорхой байв. Тухайлбал хүүхдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулагдсанаар туслах багш нар хүүхдийн хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой болсон. Түүнчлэн хүүхдийг магтаж урам өгдөг болсон.

<u>**25-р тусгай сургууль**</u>

| |
|---|
| Үзсэн хичээлийн дүрс бичлэг:<br>2016.03.23 Математикын хичээл, 3-р анги, “Хөдөлгөөний бодлого” (Хичээл заасан багш: Н.Мөнхзул)<br>2018.03.06 Математикын хичээл, 3-р анги, “Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг ялгаж, ижил дүрсийг хайцгаая) (Хичээл заасан багш: Д.Идэрхүү) |

- Туслах багшийн хөдөлгөөн урьдынхаас өөр болсон байна. 2018 оны хичээл дээр туслах багш шаардлагатай үед нь хүүхдийн хийж буй үйлдэлд дэмжлэг үзүүлж байна.
- 2018 оны хичээл дээр хүүхдийн анхаарлыг сарниулах илүү зүйлсийг анги танхимд

тавихгүй байхад анхаарсан байна. Хүүхдийн хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан даалгавруудыг өгч, багш дэргэдээс нь зааварлаж байна. Хичээлийн бэлтгэлээ хэр сайн хангана төдий чинээ сайн хичээл болдог гэдгийг ойлгосон.

**<u>55-р тусгай сургууль</u>**

| |
|---|
| Үзсэн хичээлийн дүрс бичлэг:<br>2016.03.24 Амьдрах ухааны хичээл, 1-р анги, "Тээврийн хэрэгслийн тухай" (Хичээл заасан багш: М.Сайнбуян)<br>2018.05.08 Амьдрах ухааны хичээл, 5-р анги, "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай", (Хичээл заасан багш: Ц.Энхсүрэн) |

- 2016 оны хичээлд туршлагатай багш байсан ч хүүхдэд ганцаарчилж даалгавар өгөөгүй. Хүүхдүүдийн түвшинд тохируулж даалгавруудыг өгч байсан ч цаасан дээр хэвлэж тараагаагүй.
- 2018 оны ээлжит хичээлийн хөтөлбөр нь дэлгэрэнгүй төлөвлөгдсөн байсан бөгөөд ээлжит хичээлийн хөтөлбөрийг маш тодорхой бичиж боловсруулах нь ямар их үр дүнтэй болохыг сургуулийн багш нар бүрэн ойлгосон байсан. Түүнчлэн хичээлд ашигладаг сургалтын хэрэглэдэхүүний төрөл ч олширсон байна. Жижиг алхмуудаар зааж, чадсан үед нь магтаж урам өгч чаддаг болсон байна.

**<u>63-р тусгай сургууль</u>**

| |
|---|
| Үзсэн хичээлийн дүрс бичлэг:<br>2016.03.23 Математикын хичээл, 3-р анги, "1000-ын дотор үржих, хуваах" (Хичээл заасан багш: Тодорхойгүй)<br>2018.04.12 Дүрслэх урлаг, технологийн хичээл, 3-р анги, "Гүзээлзгэнэ хийх", (Хичээл заасан багш: С.Эрдэнэчимэг) |

- 2016 оны хичээлд багш зөвхөн заахдаа л бүх анхаарлаа хандуулж, сонсож байгаа хүүхдийн хариу үйлдлийг анзаарахгүй байх шиг байсан. Магтаж, урам өгөх нь ч бага байсан бөгөөд сургалтын олон янзын арга барилыг хичээлдээ ашиглаж байгаа харагдаагүй.
- 2018 оны хичээл нь бүх хүүхдийг оролцуулахад анхаарч, туслах багшийн үүрэг болон хүүхэдтэй ажиллах арга барил ч өөрчлөгдсөн байна. Өмнө нь суудлын байрлалыг тохируулдаггүй байсан бол 2018 оны хичээлийн видео дээр багш хүүхэд хариу үйлдэл үзүүлж, хариулт өгөхийг хүлээдэг болсон байсан. Аажим аажмаар хүүхдийн хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлж чаддаг болж байна.
- 2018 оны хичээлд хүүхдийн байдлыг харгалзан ээлжит хичээлийн хөтөлбөрийг 3 түвшинд хувааж, сургалтын хэрэглэгдэхүүнийг ч мөн ялгаатай байдлаар бэлдсэн байна.

**70-р тусгай сургууль**

| |
|---|
| Үзсэн хичээлийн дүрс бичлэг: |
| 2016.03.23 Монгол хэлний хичээл, 3-р анги, "Уншиж, бичих" (Хичээл заасан багш: М.Батхишиг) |
| 2018.03.15 Монгол хэлний хичээл, 3-р анги, "Салхи сэдвийн дор үйлдэл илэрхийлэх үгийг ялгах" (Хичээл заасан багш: М.Өнөрмаа) |

- 2016 онд хичээлийн эхэнд багш хүүхдүүдтэй мэндэлж байгаа ч, үйл ажиллагааны турш магтаж, урмын үг хэлэх нь бага байсан. Хичээлийн зорилтыг хүүхэд бүрийн түвшинд тохируулж, зөвхөн толгой дотроо төлөвлөж заах бус, 2018 онд ээлжит хичээлийн хөтөлбөрийг бичиж боловсруулсанаар илүү тодорхой, ойлгомжтой болсон байна.
- 2018 онд хичээлд гараар хийсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг их ашиглах болсон байна. Хүүхдээр жижиг булчингийн хөдөлгөөнийг нь хөгжүүлэх бүтээл хийлгэдэг болсон байна. Түүнчлэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хүүхдийн бодит байдлыг үнэлж чаддаг болсон учраас хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн арга барилаар зааж чадаж байна.

**3-5 (Зөвхөн туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэг) Ердийн сургуульд үзүүлэх дэмжлэг**

Тусгай сургуулиуд болон ердийн сургуулиудын уялдааг сайжруулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах нөхцөлийг ердийн сургууль болгон өргөжүүлэх зорилгоор төслийн хүрээнд туршилтын 1 тусгай сургуульд туршилтын 2 ердийн сургуулийг тус тус хамтран ажиллагч болгож, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Эцсийн төлөв байдлын судалгааны үеэр туршилтын тусгай сургуулийн ажлын хэсэгтэй зөвлөн туслах үйл ажиллагааны талаар ярилцав.

Зөвлөн туслах үйл ажиллагаагаар дамжуулан ажлын хэсэг нь ердийн сургуулийн багш нартай мэдлэг, ур чадвар, багшлах хүсэл, эрмэлзэл өөрчлөгдсөн, мөн илүү их дэмжлэг авах шаардлагатайг мэдэрч байгааг олж мэдсэн. Түүнчлэн хамтран ажиллагч ердийн сургуулиудын багш нар өөрчлөгдөж, зөв ойлголттой болгосон гэж үзэж байна.

*Хүснэгт 4-9 Туршилтын тусгай сургуулиудын хамтран ажилласан ердийн сургуулиуд*

| Туршилтын тусгай сургууль | Хамтран ажилласан ердийн сургууль |
|---|---|
| 25-р тусгай сургууль | 16-р сургууль, 35-р сургууль |
| 55-р тусгай сургууль | 79-р сургууль, 111-р сургууль |
| 63-р тусгай сургууль | 26-р сургууль, 34-р сургууль |
| 70-р тусгай сургууль | 28-р сургууль, 113-р сургууль |

**25-р тусгай сургууль**

Ердийн сургуульд зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүлэхдээ онол, практикын хувьд өндөр мэдлэгтэй байх шаардлагатайг ойлгосон. Нийслэл болон Хөвсгөл аймгийн туршилтын ердийн сургуулиуд ч сурлагын хоцрогдолтой хүүхдийг "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд" гэж ойлгоод байдаг. Ямар онцлогтой, юу чадах вэ гэдгийг судлахгүйгээр 1 минутанд унших ёстой үгсийг уншиж чадахгүй байгаа болохоор оюун ухааны бэрхшээлтэй байж магадгүй гэж шууд харддаг. Сургуулийн зүгээс үнэлгээ хийлгэх хүсэлтэй ихэнх хүүхэд тийм хүүхдүүд байдаг.

Сурлагаар хоцрогдож байгаа хүүхдэд "Тэнэгүүдийн 25-р тусгай сургуульдаа яв" гэж дээхэн үеэс л хэлдэг байсан. Тусгай сургууль болон ердийн сургуулийн багш нар хамтарч ажилладаггүй, бие биенээ ойлгоё ч гэж хичээгээгүй ирсэн.

Тус төслийн үйл ажиллагаагаар дамжуулж ердийн сургуульд аутизм, суралцахуйн бэрхшээлийн талаар лекц уншихад ойлгодог багш ч, ойлгохгүй багш ч байсан. Ярьдаггүй хүүхдүүд ихсэх хандлагатай байгаа учраас ердийн сургуульд хэл заслын талаар мэдмээр байна гэсэн хэрэгцээ, шаардлага ч нэмэгдсэн байна. Цаашид ердийн сургуулийн багш нарт ч багшлах арга зүй болон хөгжлийн бэрхшээлийн ангилалын талаар зааж явах шаардлагатай гэж үзэж байна.

**55-р тусгай сургууль**

Туршилтын ердийн сургууль дээр асран хамгаалагчдад зориулсан сургалт зохион байгуулах үед асран хамгаалагчдын зүгээс сургалтын материал, хэрэглэгдхүүний талаар ихээхэн сонирхож байсан. Миний сайн мэддэг зүйл учир ярихад амар байлаа. 111-р сургуулийн багш нар ч их өөрчлөгдөж ирсэн. Зөвлөн туслах ажилд оролцоход өөрийнхөө мэддэг зүйлийг ч сэргээн санах боломжтой болж, надад өөрт ч хичээл болдог. (55-р тусгай сургууль)

**63-р тусгай сургууль**

Ердийн сургуулийн багш нар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхолтой" гэсэн сэтгэл байвч хэрхэн ажиллах аргаа мэддэггүй. Зөвлөн туслах үйл ажиллагаагаар нэг бүрчлэн заавал хийж чадах ч, тийм их цаг зарцуулах нь хүндрэлтэй.

Зөвлөн туслах үйл ажиллагаагаар хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн жишээ дурдан ярихад ердийн сургуулийн багш нар гайхаж байсан. Тусгай сургуульд суралцдаг хүүхэд, ердийн сургуульд суралцдаг хүүхдийн бодит байдал хэт их ялгаатай учраас тийм ч их санаа авахаар биш байсан.

Багш нар хоорондын ойлголт ч их ялгаатай байсан. Хийх хүсэлтэй багш байхад сонирхож анхаарахгүй багш нар ч байсан. Сурлагын хоцрогдлыг суралцахуйн бэрхшээл гэж бодон, үнэхээр ийм бэрхшээлтэй эсэхийг үнэлээд өгөөч гэсэн багш нар ч байсан. Оношилж үнэлэхээс илүү тухайн хүүхдэд хэрхэн зааж, сургах вэ гэдэг нь чухал гэдгийг ойлгуулж хэлэх нь маш хэцүү байсан.

Зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бид бүхнийг мэддэг гэсэн үг биш учраас、төслөөс зохион байгуулсан сургалт, материалууд их тус болсон. Энэ нь ердийн сургуулийн багш нарыг зөв ойлголт, хандлагатай болгоход нөлөөлсөн гэж бодож байна.

**70-р тусгай сургууль**

2 багш 28-р сургуульд зөвлөн тусласан. 28-р сургуульд байгуулсан Хүүхэд хөгжүүлэх төвд ямар сургалтын хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлж ашиглах талаар зөвлөгөө өгсөн. Төвд сурч байгаа 4 хүүхэдтэй ямар арга барилаар ажиллахыг зөвлөн, хэл заслын сургалт явуулсан. Эхний жилд багш нарь зөвлөгөө өгч, 2 дахь жилд Хүүхэд хөгжүүлэх төвд суралцдаг хүүхдүүдэд сургалт ч явуулсан. илүү бодит, хүртээмжтэй байдлаар зааж чаддаг болсон. эдгээр 4 хүүхдийн нэгнийх нь эцэг эх "70-р тусгай сургуульд ирж саажилттай хүүхдэд маань юм заагаад өгөөч" гэж хэлсэн тохиолдол ч гарсан.

Ердийн сургуульд зөвлөн туслах үйл ажиллагаагаа цаашид ч үргэлжлүүлэн хийнэ. 05 дугаар сард Баянгол дүүргийн ердийн сургуулиудад үнэлгээ хийсэн. Энэ үед бусад ердийн сургуулиудаас ч зөвлөгөө авах хүсэлт ирсэн. Баянгол дүүрэгт ердийн 19 сургууль байдаг ба тэдгээрийн 1 сургууль бага ангийн багш нартаа зориулж сургалт авах хүсэлт тавьсан. Дүүргийн бүх сургуулийн бага ангийн багш нарыг цуглуулж сургалт хийх талаар боловсролын хэлтэстэй ярилцаж, төлөвлөгөө гаргаж байна.

### 3-6 (Зөвхөн туршилтын ердийн сургуулийн ажлын хэсэг ) Тохируулгат орчноор хангах

Туршилтын ердийн сургуулиудын багш нарын тохируулгат орчноор хангах чадварт төсөл дэмжлэг үзүүлэхээс өмнөх үетэй харьцуулахад хэрхэн ахиц, өөрчлөлт гарсан эсэхийг тандах зорилгоор туршилтын 10 ердийн сургуулийн ажлын хэсгээс ярилцлага авав.

*Хүснэгт 4-10 Ярилцлагын мэдээлэл*

| Туршилтын сургууль | Ярилцлага хийсэн өдөр | Оролцогчдын тоо |
|---|---|---|
| 16-р сургууль | 12.11 | 6 |
| 26-р сургууль | 12.11 | 8 |
| 28-р сургууль | 10.26 | 9 |
| 34-р сургууль | 10.25 | 6 |
| 35-р сургууль | 10.24 | 3 |
| 79-р сургууль | 12.14 | 4 |
| 111-р сургууль | 10.23 | 4 |
| 113-р сургууль | 12.10 | 9 |
| Титэм 2-р сургууль | 10.31 | 6 |
| Ирээдүй 21-р зуун цогцолбор сургууль | 11.01 | 10 |

Аль ч сургуулийн хувьд ихэнх багш нар төслийн оролцоо, дэмжлэгээр дамжуулж тохируулгат орчин гэдэг ойлголтыг мэддэг болсон ба олон ажлын хэсгийн гишүүд зурган карт зэрэг хэрэглэгдэхүүнийг ашиглах, хүүхдэд ойлгомжтойгоор заавар өгөх, сургалтын агуулгыг хүүхдэд тохируулан уян хатан байдлаар өөрчлөх зэргээр ажиллаж байгааг олж мэдсэн. Цаашид ч үргэлжлүүлэн хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн зааж, сургах төлөвлөгөөтэй бөгөөд энэ бүхний үр дүнд "Зөвхөн хүүхэд төдийгүй багш нарын ажил ч хөнгөвчлөгдсөн" гэж хэлэх ажлын хэсгийн гишүүд ч байсан.

**16-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө "Тохируулгат орчин" гэдэг үгийг ч мэддэггүй байсан. 5-6 жилийн өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байсан ч тухайн үед тэр хүүхдэд зориулж тусгай ямар нэг дэмжлэг үзүүлдэггүй байсан.

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Зурган карт ашиглаж байгаа ч, хүрэлцдэггүй учраас эцэг эхчүүдээс дэмжлэг хүссэн байгаа.
- 1-р ангийн хүүхдийн хичээлийн хуваарийг харуулахдаа хичээлийн нэрийг үсгээр биш тухайн хичээлийн сурах бичгийн хавтсыг хувилж нааж ашиглаж байгаа.
- Замын хөдөлгөөнд анхаарал, болгоомжтой оролцох, гарын ариун цэвэр зэргийн талаар заадаг.
- Анги нийтийн нэгдсэн сургалт явуулдаг учир хүүхэд бүрийн ойлголтоос хамаарч сургалтын агуулга өөрчилдөггүй.
- Товч, ойлгомжтой байдлаар заавар хэлдэггүй.

**26-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэх хүртэл "Тохируулгат орчин" гэдэг үгийг ч мэддэггүй байсан. Зүгээр л хөгжлийн бэрхшээлтэй гэж бодогдсон хүүхдийг үнэлэхээс хэтэрдэггүй байсан.
- 2016 онтой харьцуулахад багш нарын ойлголт сайжирсан.

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Одоо ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдийн сургалтын агуулгыг тохируулан өөрчилж байгаа. Тухайлбал давхарлаж бичих сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж ашиглаж байгаа.
- 1-р ангийн хүүхдүүдэд зураг ашиглан хичээлийн цагийн хуваарыг үзүүлдэг.
- Зурагтай наалт зэргийг ашиглан заавар өгч байгаа.
- Ангийн хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэж ойлгуулж заадаг.
- Тэргэнцэртэй хүүхэд зорчих боломжтой (Төслийн дэмжлэгээр) налуу замыг тавьж

өгсөн нь их тус болж байгаа.

- Холоос зорчдог хүүхдүүд их байсан тул сургуулийн автобусны тосох, хүргэх үйлчилгээ маш их тус болж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүүхдүүдийн харилцаа сайжирч байгаа.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч ядмаг ойлголттой байсан ч одоо бол сайн ойлгодог болсон. Өдөр бүр биш ч боломжтой үедээ ирээрэй гэхэд сургуулийн автобусанд суухгүй байсан ч үдэд өөрөө автобусанд суугаад ирдэг хүүхдүүд ч байдаг болсон.

**28-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө нийгмийн ажилтан тохируулгат орчны талаар мэддэг байсанч багш нар мэддэггүй байсан. Математикийн хичээл зэрэг дээр хүүхдүүдийг мэдлэгийн түвшингээр нь хувааж сургалтаа зохион байгуулдаг.
- Зөвхөн хүүхэд төдийгүй багш нарт маш их үр дүнтэй байсан учраас цаашид ч тохируулгат орчноор хангахад анхаарч ажиллана..

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Нийт багш нар хүүхдийн ойлголтод тулгуурлан сургалтын агуулгаа өөрчилж хичээлийг зохион байгуулж байна. Зурган карт, бодит эд юмсыг ч ашиглаж байгаа. Тусгай боловсрол, дэмжлэг шаардлагатай хүүхдэд 1 өдрийн хичээлийн цагийн хуваарийг ойлгомжтойгоор харуулахын тулд зураг зэргийг ашигладаг болсон. Заавар хүүхдэд маш ойлгомжтойгоор хэлнэ гэдгийг багш нар сайн ойлгодог болсон.

**34-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө хөгжлийн бэрхшээлтэй 2 охин сурдаг байсан ч тохируулгат орчин гэдэг үгийг мэддэггүй байсан.
- Хүүхдийн хэрэгцээнд нийцүүлж зааж сургах нь илүү үр дүнтэй гэдгийг ойлгосон учраас үргэлжлүүлэн тохируулгат орчин бүрдүүлж ажиллана.

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Хүүхдийн хэр сайн ойлгосныг харгалзан сургалтын агуулгаа өөрчилж хичээлийг зохион байгуулж байна. Давтлага өгдөг. Бүх багш нар зурган карт, бодит зүйлийг хичээлдээ ашиглаж байгаа. Хичээлийн цагийн хуваарийг харуулах тал дээр онцгойлж хэрэгжүүлсэн санаа байхгүй.
- Заавар хэлэх тал дээр ч онцгойлж хэрэгжүүлсэн санаа байхгүй.

**35-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө "Тохируулгат орчин" гэдэг үгийг мэддэггүй байсан.

- Цаашид ч үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Сургалтын агуулгаа өөрчилж, зурган карт ашиглан, цагийн хуваарийг ч ашигтай байдлаар хийж ашиглаж байгаа. Хүүхдийг дуудахдаа нэг их онцолж, анхаардаггүй.

**79-р сургууль**

【Ойлголт, хандлагын өөрчлөлт】

- Төсөл дэмжлэг үзүүлж эхлэхээс өмнө тохируулгат орчин гэдэг үгийг мэддэггүй байсан. Сургуулийн захирал Япон дахь сургалтад хамрагдан , сургууль дээр тайлан тавьсанаар энэ нэр томъёог мэддэг болсон.
- Үр дүн мэдрэгдэж байгаа. Үргэлжлүүлнэ.
- Анги бүрт 1-2 ганцаарчилж хичээллэх шаардлагатай хүүхэд байгаа гэж ойлгож байна. "Ганцаарчилж заахад ажиллагаа ихтэй учраас тусгай ангидаа сурсан нь дээр" гэж үзэх багш нар байгаа ч тэгж болохгүй. Хамтдаа сурах нь зөв гэж бодож байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт нэмэлт цалин олгох нь зүйтэй.

【Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохируулга】

- Бүх ангиудад сургалтандаа зурган карт, бодит зүйл ашиглаж байхад анхаарч байгаа.
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхдэд сургалтын агуулгыг өөрчилж тохируулж байгаа.
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллээгүй хүүхдэд, ялангуяа бага ангийн хүүхдэд цагийн хуваарийг үзүүлэхдээ зураг ашиглах зэргээр санаачлан ажиллаж байна. Анги даасан багш нарт зураг тарааж өгсөн.
- Зааврыг ойлгомжтой болгох тал дээр сургуулийн зүгээс ямар нэг юм хийгээгүй. Багш нарт даалгасан байгаа.
